

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
(2024 оны жилийн эцсийн байдлаар)

2024 оны 12 дугаар сарын 20

Арвайхээр

Шийд- вэрийн дэс дугаар	Зүйл, заалт ын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
Монгол Улсын Хууль					
1	1	БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ 2003-05-30 Дугаар 2003_01 15.2.3. Бүс нутгийн хөгжилд улсын төсвөөс оруулж буй хөрөнгө оруулалт болон санхүүгийн бусад дэмжлэгийг зориулалтынх нь дагуу үр ашигтай ашиглах;	Аймгийн хэмжээнд 2016-2024 оны хугацаанд улс, орон нутгийн 606.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн салбарт Зоонозын өвчин судлалын төвийн барилга, Богд сумын Эрүүл мэндийн төв, Бат-Өлзий, Хайрхандулаан, Сант, Гучин-Ус, Төгрөг сумдын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгууд тус тус баригдаж, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хархорин суманд “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг байгуулан эрт илрүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулж байна. Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг иж бүрэн чих, хамар хоолойн орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, бактерлоги лаборатори шинээр байгуулж бактерлогийн бүрэн автомат анализатор, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд харвалт, шигдээсийн нэгж байгуулж, ангиографийн аппаратыг суурилуулан, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэн 2023 онд судсан доторх оношилгоо, эмчилгээг нутагшуулан нийт өөрийн аймгийн болон хил залгаа аймгийн 130 гаруй хүнд оношилгоо, эмчилгээ хийсэн. Боловсролын салбарт сургуулийн барилга 22, цэцэрлэгийн барилга 24, цэцэрлэгийн өргөтгөл 5, спорт заал 6, соёлын төв 8, дотуур байр 6, багийн төв	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		10, ахмадын өргөө 1, бизнес хөгжлийн төв 1, хүний хөгжлийн төв 1, цагдаагийн газар 4, сумын Засаг даргын Тамгын газар-3, усан спорт цогцолборын барилга -1 тус тус баригдаж, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдлээ. Мөн хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 57.56 км авто замын их засвар шинэчлэлийн ажил бүрэн хийгдэж, хангайн болон баруун бүсийн аймгуудын аюулгүй зорчих ая таатай нөхцөл бүрдээд байна.		
2	15.2.4. Бүс нутгийн хөгжлийн талаар хийж байгаа ажлын үр дүнг Зөвлөлд тайлагнах;	Хангайн бүсийн зөвлөл 2005 онд байгуулагдан Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль болон түүнийг дагалдан гарсан тогтоол шийдвэр, дүрэм журмыг удирдлага болгон үйл ажиллагаа явуулж ирсэн. Жил бүр Хангайн бүсийн зөвлөлийн дарга, Монгол Улсын Шадар сайдын хооронд «Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулсан гэрээ»-ний үндсэн дээр жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан “Бүсийн зөвлөл”-ийн хурлаар тухайн оны эхэнд хэлэлцүүлэн баталж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ажилласан. Бүсийн үйл ажиллагааг жил бүр Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хороо, бүсийн аймгуудын Засаг дарга ИТХ-д тайлагнаж ажиллаж байсан байна. Хангайн бүсийн хэмжээнд бүс нутгийн хөгжлийн асуудлаар зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаа, түншлэл арга хэмжээг 2000 оноос жил бүр, уулзалт үзүүлэх сургуулийг 10 гаруй удаа зохион байгуулсан байна. Мөн Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн “Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтээр “Бүс нутгийн хөгжлийн академи”, Бүсийн аймгуудын Засаг даргын Тамгын газруудтай хамтран Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг, үнэлгээ хийлгэсэн. Бүсийн бүх аймаг ИТХ-аараа өөрийн аймгийн Засаг даргын “Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, цаашдын зорилт”-	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			ын талаар хэрэгжүүлж буй ажлын тайланг хэлэлцэж тодорхой шийдвэрүүд гаргасан байна. 2005-2010 онуудад Бүсийн хөгжлийг дэмжих сан байгуулах, түүнд хөрөнгө бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын дагуу “Бүсийн хөгжлийн дэмжих сан”-д 110.0 гаруй сая төгрөг төвлөрүүлж Хангайн бүсийн зөвлөгөөнүүд, гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт, сургалт, семинарууд, Хангайн бүсийн түншлэл арга хэмжээ, гадаад арга хэмжээнүүдэд зарцуулаад байна. 2019 оноос хойш ковид цар тахлын улмаас бүсийн хэмжээнд арга хэмжээ зохион байгуулаагүй байна.		
2	3	ТӨСВИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2011-12-23 Дугаар 2015-10 14.2.11. Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах;	Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд зааснаар бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах болон хэвлүүлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, салбарын болон байгууллагын тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, салбартай холбоотой киноны уран бүтээл хийх, төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр, шатахууны зардал, төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100.0 хувь хэмнэх чиглэл баримтлах зэрэг заалтын биелэлтийг ханган ажиллаж байна. Мөн сумын төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий нягтлан бодогч болон санхүүгийн ажилтнуудын ажлын ачааллыг үнэлэх зорилгоор ажлын байрны зураг авалт хийх төлөвлөгөө гаргаад байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
3	4	Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03	Жил бүрийн орон нутгийн төсөвт гамшгаас хамгаалах, эрсдлийг бууруулах арга хэмжээний зардалд 600-1000.0 сая төгрөгийг төлөвлөн тооцож,	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана.	аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж байна.		
4	5	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01 19.1.1. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	“Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн, иргэд, олон нийтийн хяналтыг сайжруулж, тэдний эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, далд хэлбэрийн хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх ажлыг хэвшүүлэх зорилгоор 26 удаагийн аян, нөлөөллийн ажил зохион байгуулж, 6 контент, 51 постер, 4 видео, 16 удаагийн мэдээ, мэдээлэл, хүүхэд хүмүүжлийн эерэг аргатай холбоотой 1 дуу, 5 нэвтрүүлэг бэлтгэн гаргаж, давхардсан тоогоор 525.0 мянган иргэний хандалт авсан ба аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хөтөлбөрийг 91.0 хувийн хэрэгжилттэйгээр үнэлсэн. Хөтөлбөрийн хүрээнд архины хамааралтай, хорихоос суллагдсан, байнгын гэр бүлийн хүчирхийлэлтэй гэр бүл болон дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй залуу гэр бүлийн судалгаа, хагас болон бүтэн өнчин хүүхдийн судалгааны мэдээллийн санг бүрдүүлж, судалгаанд үндэслэн 335 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж, 44 өрхийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн, 115 хүүхдэд хамгааллын хариу арга хэмжээ авч, 4 иргэнийг архины эмчилгээнд хамруулсан байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	6	19.1.2. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Тайлант онд 36 хамтарсан багт 316 гишүүд ажиллаж байгаа бөгөөд хүүхдийн тусламжийн 108 утсанд бүртгэгдэж, шилжүүлсэн 85, илрүүлэн ажилласан 80, нийт 165 тохиолдолд кейс нээн ажиллаж, илрүүлсэн кейсийн шийдвэрлэлт 85.0 хувь, хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлагын шийдвэрлэлт 81.0 хувьтай байна. Аймгийн хэмжээнд хамтарсан багаар дамжуулан анхан шатны эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө мэдээллийг 572 хүүхэд, 462 иргэнд хүргэн ажилласан байна. Хүүхэд болон гэр бүлийн	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		гишүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, эрх ашиг хөндөгдсөн үед нийгмийн ажлын цогц үйлчилгээг анхан шатанд үзүүлэхэд дэмжлэг болгох зорилгоор сум, багийн хамтарсан багт 13.3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Хөөрхөн зүрх” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан “Сэтгэцийн гэмтэлд суурилсан нийгэм-сэтгэлзүйн анхан шатны зөвлөгөө, үйлчилгээг бэлгийн хүчирхийллийн даван туулагч хүүхдэд үзүүлэх нь” танхимын сургалтад 69 албан хаагч, “Галт шувуу” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан “Нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах нь” цахим кейс хэлэлцүүлэгт Арвайхээр сумын 13 багийн Нийгмийн ажилтан хамрагдсан байна.		
7	19.1.5. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Хохирогчийг хамгаалах байр буюу Нэг цэгийн үйлчилгээний төвд орон нутгийн төсвөөс жил бүр 20.0 сая төгрөгийн санхүүжилт олгож байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
8	19.1.6. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:	Нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс нэг цэгийн үйлчилгээний төвд 1, Хүүхдийн ордонд 1, нийт 2 өрөөг стандартын дагуу тусгайлан тохижуулж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

	9	19.1.7. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагаар хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх хүрээнд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх Тэмүүл төв нь Арвайхээр сумын эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг илрүүлэх, амьдарч буй орчин нөхцөлтэй нь газар дээр нь танилцан гэр бүлд нь нөхцөл байдлын үнэлгээ хийн, хүүхдийг эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 289 хүүхдийн судалгааг бүрдүүлэн 60 өрхийн амьдралын нөхцөл байдлын үнэлгээ хийн, 40 өрхөд тусламж үйлчилгээ үзүүлэн, 300 гаруй эцэг эх асран хамгаалагчдад “Хайрлагдсан хүүхэд” сургалт арга хэмжээ, сэтгэл зүйн боловсрол олгох сургалтуудыг тус тус зохион байгуулан, сэтгэл зүйн оношилгоо, дүгнэлт хийн ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	10	19.1.8. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Цагдаагийн газар, Боловсролын газар хамтран “Урамшуулалт эргүүл” хэсэгчилсэн арга хэмжээг Арвайхээр сумын 13 багт 2 сарын хугацаанд зохион байгуулж, Арвайхээр сумын 13 багийн 26 хэсгийн ахлагч, иргэн ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгаалал, архины хор хөнөөл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 53 төрлийн 13000 ширхэг зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг, мэдээ, мэдээллийг давхардсан тоогоор нийт 12132 иргэнд тарааж, зөвлөгөө зөвлөмж өгч, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлээ. Албан байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх “Эцэг, эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, албан хаагчдын гэр бүл, хүүхдийн хүмүүжил, төлөвшилд байгууллага бүрийг идэвх санаачилгатай оролцуулах зорилгоор 2024 оны “Шилдэг эцэг, эхийн	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			зөвлөл” шалгаруулах удирдамжийн дагуу 35 эцэг эхийн зөвлөлийн тайлан ирж, шилдэг эцэг эхийн зөвлөлийг шалгаруулан урамшуулсан.		
5	11	Хоршооны тухай /Шинэчилсэн найруулга/ 2021-05-06 Дугаар 2021.05.06 43.2.1. Хоршоог дэмжих, хоршооны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	АНУ-ын ОУХА-ийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа BEST хөтөлбөртэй хамтран Хоршооны чадавхыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд 19 сумын нийт 230 хоршоо, иргэд, төрийн албан хаагчдад ХХААХҮС-ын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” баталсан А/521 дүгээр тушаалын талаар болон бизнес төсөл хэрхэн бичих зэргээр сургалт зохион байгуулсан. Сумдууд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа тэргүүлэх чиглэлээ батлах, үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодыг дэмжих, Хоршоог хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийг бууруулж, эргэн төлөлтийг сайжруулах чиглэлээр арга хэмжээг авч ажиллах талаар сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарт зөвлөмж хүргүүлсэн. Хоршоо хөгжүүлэх сангийн хяналт үнэлгээг Хүнс, хөдөө аж ахуйн газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албатай хамтран 19 суманд хийсэн. Монгол банкны зээлийн ангиллыг солиулахад 183 иргэн, аж ахуйн нэгж хамрагдаж, 671.8 сая төгрөгийн зөрчил арилгасан. Энэ онд Хоршоо хөгжүүлэх сангаас Арвайхээр, Хархорин, Есөнзүйл, Бүрд сумын 8 хоршоонд 763.0 сая төгрөгийн зээл олгосон.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
6	12	Төрийн хэмнэлтийн тухай 2022-04-29 Дугаар 2022.04.29 10.1. Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 184 дүгээр тогтоолын дагуу “Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компанийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ыг боловсруулсан. Энэхүү журмын хавсралтаар Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх захирал, захирлын албан тушаалын сарын хөдөлмөрийн хөлсийг хөдөлмөрийн	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.	хөлсний доод хэмжээний тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны тогтоолын заалтыг үндэслэн хуулийн этгээдийн нийт хөрөнгийн хэмжээ, ажиллагсдын тоо, тайлант үеийн цэвэр ашгийн хэмжээгээр эрэмбэлж тогтоохоор аргачлалыг боловсруулсан.		
13	13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох; (13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах; 22.1.Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)	Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 97.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 34 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа эрх шилжин ирсэн. Үүнд: Боловсролын яамнаас 46.2 тэрбум төгрөгийн 13, Эрүүл мэндийн яамнаас 2.6 тэрбум төгрөгийн 4, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 9.2 тэрбум төгрөгийн 2, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 150.0 сая төгрөгийн 3, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас 4.2 тэрбум төгрөгийн 3, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас 18.9 тэрбум төгрөгийн 2, Сангийн яамнаас 1.3 тэрбум төгрөгийн 1, Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 3.0 тэрбум төгрөгийн 2, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 4.3 тэрбум төгрөгийн 2, Зам, тээврийн хөгжлийн яамнаас 7.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээ тус тус эрх шилжин ирсэн байна. Эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээ Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд бүрэн хэрэгжиж гэрээ байгуулагдсан бөгөөд хэрэгжээгүй болон төсөв татагдсан төсөл арга хэмжээ байхгүй.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		
14	8.1. Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.	Орон нутгийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас хийлгэж, худалдаж авсан тохиолдол байхгүй.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

	15	14.2. Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ.	Цахим дэлгүүрт 28 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, 11 төрлийн эм эмнэлгийн хэрэгсэл нэмэгдсэн байна. Жагсаалтыг тухай бүр шинэчлэн Төрийн хэмнэлтийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т заасны дагуу хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	16	14.4. Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.	Төсөвт байгууллагуудад цахим дэлгүүрээс худалдан авалт хийхэд тогтмол арга зүйн зөвлөгөө өгч, тайлант онд шинээр 26 байгууллага нэвтрэх эрх авч цахим дэлгүүрээс худалдан авалт хийсэн байна. Цахим дэлгүүрт ерөнхий шаардлага хангасан 1149 бараа байршиж, эдгээрээс бараа худалдан авахаар 2058 захиалагч байгууллага 2077 ерөнхий гэрээ байгуулж, нийлүүлэгч 541 аж ахуйн нэгж бараа бүтээгдэхүүнээ борлуулж байна. Төрийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгддэг эм, эмнэлгийн хэрэгсэл, бичгийн цаас, принтерийн хор, дата зэрэг нэр төрлийн барааг цахим дэлгүүрээс худалдан авч хэвшсэн байна. Мөн 19 сумын Эрүүл мэндийн төв, ЕБС-иуд, СӨББ-уудад цахим дэлгүүрээс худалдан авалт хийхэд тогтмол арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Тайлант онд нийт 82 байгууллага төрийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагддаг байнгын хэрэгцээтэй бараа, материалыг худалдан авсан байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	17	14.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана.	Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах сумдын болон төсөвт 24 байгууллагын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 24.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 521 төсөл арга хэмжээ, байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан 114.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 89 төсөл арга хэмжээг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулсан. Мөн тендерт оролцогчдын ирүүлсэн материалыг үнэлэхдээ төрийн худалдан авах ажиллагааны дэд системийн баазаас татвар, нийгмийн даатгал, боловсролын мэдээлэл, авто тээврийн эзэмшигчийн	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			болон оношилгооны лавлагаа, санхүүгийн тайлан, бүх төрлийн тусгай зөвшөөрөл, шүүхийн шийдвэрийн өр, төлбөрийн талаарх лавлагаа, тендерийн баталгаа зэргийг татан авч үнэлгээнд ашиглаж байна. Эдгээр мэдээлэлд зөрүүтэй болон өр төлбөртэй байгаа тохиолдолд нарийвчилсан үнэлгээ хийхгүй байх зарчмыг баримталж байна.		
18	15.2.1. Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх; (15.2.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана)	Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх талаарх зөвлөмжийг хүргүүлэн ажилласан бөгөөд цахилгаан эрчим хүчний хэрэглээг хэмнэх зорилгоор “ЦДҮС” ТӨХК-ийн Хангай бүсийн салбарын Арвайхээр хэсгээс ид ачааллын үед таслалт хийж, хэмнэлтийн горимд ажиллаж байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь		
19	15.2.2. Нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;	Шинээр барилга байгууламж баригдаж нэгдсэн халаалтын системд холбогдох үед эх үүсвэрийн өргөтгөл, дулааны шугам сүлжээний горимын тохируулга хийж ажиллаж байна. Тайлант онд улсын төсвөөр баригдаж буй 3 барилгад дулааны тоолуур суурилуулсан байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь		
20	15.2.4. Цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх;	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас хэрэгжүүлж буй “Цахим жишиг аймаг” хөтөлбөрт Өвөрхангай аймаг хамрагдаж, “Аймаг, орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн аж, ахуйн нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэх” төслийн хүрээнд Байгууллагын удирдлагын системийн хөгжүүлэлт хийгдэж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. “Төрийн байгууллагын нэгдсэн систем”-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр хүний нөөцтэй холбоотой үйл ажиллагаа, цаг бүртгэлийг удирдан зохион байгуулах, системд бүртгэлтэй төрийн байгууллагуудын нийт албан хаагч хоорондоо бүлэг үүсгэн ажил үүргийн мэдээлэл солилцох, файл дамжуулах, тайлан, судалгаа гаргах, иргэд, аж ахуйн	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

		нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг цахимаар бүртгэх, шийдвэрлэлтийн явцыг хянах, шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн. Тус системд аймгийн хэмжээнд 127 байгууллагын 549 албан хаагч холбогдож, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд цаашид тус системийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж байна. Аймгийн хэмжээнд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хянах, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үнэлгээ, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнг мэдээлэх, тайлагнах мэдээллийн цахим санг шинээр нэвтрүүлж, “Очир ай гүүгэл” ХХК-тай хамтран ажиллаж байна. Цахим мэдээллийн сангийн үйл ажиллагааг хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн бүртгэл, хяналт, зохион байгуулалт, тайлагналтын хүрээнд бүх сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын түвшинд хэрэгжүүлж эхлээд байна.		
21	15.2.7. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх.	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 26 сургалт, 18 уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, төр, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл 2600 гаруй оролцогч хамрагдаж, бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад оролцсон бөгөөд түрээс, шатахуун албан томилолтын зардлыг 1.5 дахин хэмнэж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
22	15.2.5. Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр	Монгол Улсын Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газартай эргэн төлөгдөх нөхцөлөөр байгуулсан гэрээний зээлийн	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;	үндсэн төлбөрийг энэ онд орон нутгийн төсвөөс төлөхөөр төлөвлөсөн бөгөөд 800.0 сая төгрөгийг бүрэн төлсөн болно. Уг зээлийн төлбөрийг орон нутгийн төсөвт төлөвлөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, аймгийн Засаг даргын захирамжаар сарын хуваарийг баталж санхүүжилтийг олгосон. Мөн төсвийн байгууллагуудад төсвийн жилийн дундуур үүссэн өр төлбөрийг хэмнэгдсэн зардлын хэмнэлтээс шилжүүлэх замаар тухай бүрд нь шийдвэрлэж ажилласан.		
7	23	Үндэсний их баяр наадмын тухай /шинэчилсэн найруулга/ 2022-06-28 Дугаар 2022.06.28 5.4. Энэ хуулийн 5.3-т заасан нөхцөлд аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх хугацааг 08 дугаар сарын 10-ны өдрөөс хэтрүүлэхгүй байхаар тогтооно. (5.3.Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан энэ зүйлийн 5.2-т зааснаас өөр өдрүүдэд улс, аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх бөгөөд улс, аймгийн баяр наадмын хугацааг Засгийн газар, сумын баяр наадмын хугацааг аймгийн Засаг дарга тогтооно.)	Аймгийн Засаг даргын 2024 оны А/253 дугаар захирамжаар сумдын баяр наадмыг тэмдэглэх хугацааг тогтоож, зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан. Энэ онд аймгийн тэгш ой тохиосон 9 сум 7 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд, бусад 10 сум 7 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлж, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Дотоод хяналтад авч хяналтаас хасуулах саналтай.)	
8	24	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01 15.7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин сууж	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны “Норматив тогтоох тухай” А/272 дугаар тушаалыг үндэслэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Өвөрхангай аймгийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээний 39 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/405 дугаар “Аттестатчилал зохион байгуулах тухай” захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах,	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршил, аймаг, нийслэлийн саналыг харгалзан хүнс, эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно.	түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгт аттестатчлал зохион байгуулж, цэгийн тоог бууруулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал 2023 оны “Согтууруулах ундаа, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоох тухай” А/470, А/327, А/306 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор цэгийн тоог хэвийн хэмжээнд барьж ажиллаж байна.		
	25	23.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно.	Аймгийн Засаг даргын 2023 оны “Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хязгаарыг шинэчлэн батлах тухай” А/724 дүгээр захирамжаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг батлан Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, улсын нэгдсэн санд бүртгүүлснээр үйл ажиллагаандаа нийтээр дагаж мөрдөн ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
Хэсгийн дундаж: 95.2					
Монгол Улсын Их Хурлын Тогтоол					
9	26	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай 2001-06-14 Дугаар 2001№57 2.3. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлын эх үүсвэрийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, улсын төвлөрсөн төсөвт тусган шийдвэрлэж байх. (Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталсантай холбогдуулан дор	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	

		дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.)			
27	4.7.1.г. Бүс нутагт банк, санхүү, даатгалын тогтолцоог бүрдүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)		
28	4.7.1.е. Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн нийтлэг зорилтыг шийдвэрлэхэд аймаг, нийслэл, хот, тосгоны хамтын ажиллагааг өргөжүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)		
29	4.7.1.ж. Бүсчилсэн хөгжлийн асуудлаар төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллага хоорондын ажлын уялдаа, харилцан мэдээлэл, зохицуулалтыг хангах;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)		
30	4.7.1.з. Бүс нутаг, хот байгуулалтын судалгаа, шинжилгээ, сургалт, сурталчилгааны ажлыг хөхүүлэн дэмжих;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол		

			тул хяналтаас хасуулах саналтай.)	
31	4.7.1.и. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал хэрэгжих орчинтой уялдуулан засаг захиргаа нутаг дэвсгэрийн байгууламжийг боловсронгуй болгох;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
32	4.7.2.а. Бүс нутгийн байгаль орчны даац, чадавхийг бүрэн зохистой ашиглах, орон нутгийн хүн амын хөдөлмөрийн дадлага, чадварыг дээшлүүлэх шаардлагад зохицсон жижиг, дунд үйлдвэрлэлийн сүлжээ бүрдүүлэх	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
33	4.7.2.б. Дэлхийн зах зээлийн болон дотоодын хэрэгцээг харгалзан бүсүүдийн хүрээнд импортыг орлох, гадаад зах зээлд өрсөлдөх чадвар бүхий олон улсын стандартад нийцсэн, экологийн хувьд цэвэр бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
34	4.7.2.в. Алслагдсан, говийн түүнчлэн сул хөгжилтэй бүс нутгийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол	

			тул хяналтаас хасуулах саналтай.)	
35	4.7.2.г. Тухайн бүсийн хүрээнд аймаг, нийслэл, хот, тосгоны хоорондын, салбар хоорондын аж ахуйн хоршилт, хослолыг дэмжин хөгжүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
36	4.7.2.д. Сумын хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
37	4.7.2.е. Бүсүүдэд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага шинээр байгуулах буюу өөрийн салбар, нэгжээ байгуулж ажиллахыг хөхүүлэн дэмжих	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
38	4.7.2.з. Бүсүүдийг хооронд нь болон гадаад улс орнуудтай холбосон хөндлөн гол зам барьж байгуулах үндэсний хөдөлгөөн өрнүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол	

			тул хяналтаас хасуулах саналтай.)	
39	4.7.3.б. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, байгалийн гамшгийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгахтай холбогдсон хяналт, мэдээлэл, тусламжийн бүс нутгийн сүлжээ бүрдүүлэх	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
40	4.7.3.в. Байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амын амьдрах орчны аюулгүй байдлыг хангахтай холбогдсон аймаг, сум дундын ач холбогдол бүхий нийтлэг арга хэмжээг санхүүжүүлэх нэмэлт эх үүсвэрийг бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
41	4.7.3.г. Бүс нутгийн байгалийн баялгийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, нөхөн сэргээх, амьдрах орчинд хал багатай дэвшилтэт арга технологи-нэвтрүүлэх, шилжүүлэх үйл ажиллагааг дэмжин урамшуулах;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
42	4.7.3.ж. Бүс нутгийн хөгжлийн асуудлыг байгаль орчны даац, нөөц баялгийн экологи-эдийн засгийн үнэлгээ, төлбөр, тооцооны үндсэн дээр шийдвэрлэх чадвар бүхий бүсийн байгаль орчны	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол	

		төлөвлөлт, удирдлагын бие даасан тогтолцоог бүрдүүлэх		тул хяналтаас хасуулах саналтай.)	
43	4.7.3.з. Бүсийн хүрээнд тодорхой газар нутгийг гадаадын сонирхогч улс орон, гадаадын хөрөнгө оруулагчдад гэрээний үндсэн дээр урт хугацаагаар түрээслэн ашиглуулж байгаль орчин, хөгжлийн асуудлыг иж бүрэн шийдвэрлэх нөхцөлийг хангах;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)		
44	4.7.4.а. Бүсүүдэд их сургууль, коллежийн салбар, судалгаа, мэдээллийн болон сургалтын төвүүд байгуулахыг дэмжиж тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй уялдсан боловсрол, шинжлэх ухааны шинэ хэв шинж бүхий тогтолцоо бүрдүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)		
45	4.7.4.б. Оношлогоо, эмчилгээний бүсийн болон бүс нутгийн төрөлжсөн төвүүдийг байгуулахын хамт, сум дундын эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засгийн хөшүүргийг боловсруулж хэрэгжүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)		
46	4.7.4.в. Хөдөөгийн хүн амын ядуурлыг бууруулах, ажил эрхлэлтийг дэмжих сум дундын зориулалтын санхүүгийн механизм бий болгох, алслагдсан болон говийн бүс нутагт ажлын байр	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол		

	бий болгосон хөрөнгө оруулагчдыг татварын бодлогоор урамшуулах;		тул хяналтаас хасуулах саналтай.)	
47	4.7.4.д. Алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч, багш, эмч нарт цалин хөлсний нэмэгдэл урамшуулал олгох, амьдралын нөхцөлийг нь сайжруулах, тогтвор суурьшилтай аж төрөхөд нь дэмжлэг үзүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
48	4.7.4.е. Хүн амын хүнсний хэрэглээний нормыг тогтоож, хүнсний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг бүс нутгийн бодлогод тусган хэрэгжүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
49	4.7.4.ж. Мэргэжлийн соёл, урлагийн байгууллагыг хот, хөдөөгийн хүн амд үйлчлэх төрөл, хүрээгээр нь бүсчлэн байгуулж, үндэстэн, угсаатны соёл, ёс заншлыг хадгалж өвлүүлэхийн хамт, үндэстэн хоорондын соёл, урлагийн харилцааг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
50	4.7.4.з. Тухайн бүсийн хүрээнд хот, хөдөөгийн хүн ам амьдрах арга ухаан, хөдөлмөрлөх дадлага, туршлагаа харилцан солилцох, уугуул нутгаа хөгжүүлэх талаар орон нутгийн байгууллага, төрийн бус байгууллагууд	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол	

		хамтран ажиллах явдлыг хөхүүлэн дэмжих.		тул хяналтаас хасуулах саналтай.)	
	51	4.7.5.а. Бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх агуулгаар "Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг"-ыг боловсруулж, шийдвэрлүүлэн хэрэгжүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай" 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
	52	4.7.5.г. Улаанбаатарын болон бусад бүсийн хэмжээнд Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрлийг задлах зохистой чиглэл, хотын оршин суугчдын амьдрах орчны чанар, аюулгүй байдлыг хангах, хотын газрыг үр ашигтай ашиглах, инженерийн шугам сүлжээ, замын байгууламжийг шинэчлэх шаардлагыг бодолцон нийслэл хотын хөгжлийн стратеги, ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хамтын хүч чармайлтыг нэгтгэн зохион байгуулах;	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай" 64 дүгээр тогтоолоор энэхүү тогтоол нь хүчингүй болсон.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Хүчингүй болсон тогтоол тул хяналтаас хасуулах саналтай.)	
10	53	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34 3. Газар хөдлөлтөөс хамгаалах арга хэмжээг хот төлөвлөлтийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх, төвлөрлийг	Улсын төсвийн 14, иргэн, аж ахуйн нэгжийн 38 нийт 52 барилгын архитектур төлөвлөлтийн даалгаварт "Газар хөдлөлт"-ийн холбогдох норм, дүрмийг оруулж тухайн сум, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулан хянан баталж ажилласан. Ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгуудыг буулгаж тухайн суурин дээр нь дараах	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		сааруулж, суурьшлын бүс, дагуул хотыг газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү төлөвлөж хөгжүүлэх арга хэмжээг авах;	барилгуудыг шинээр барихаар төлөвлөсөн. Тухайн барилгын ажлын зураг төсөвт хуучин барилгыг буулгах зураг төсвийг боловсруулан хүлээн авч ажилласан. Үүнд: Аймгийн төвийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн хуучин агуулахын барилгыг буулгаж шинээр лаборатори, конторын барилга, Хүүхдийн төлөө төвийн хуучин барилгыг буулгаж шинээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга, Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн хуучин өргөтгөлийн барилгыг буулгаж шинээр 320 хүүхдийн өргөтгөлийн сургуулийн барилга, Гучин-Ус сумын хуучин бага сургуулийг буулгаж шинээр 250 суудалтай спорт заалны барилга, Өлзийт сумын хуучин эмнэлгийг буулгаж шинээр 15 ортой эмнэлгийн өргөтгөлийн барилга, Хархорин сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн хуучин агуулахыг буулгаж шинээр 320 хүүхдийн сургуулийн барилгуудын угсралтын ажил явагдаж байна. Мөн Арвайхээр хотын шинэ суурьшлын бүсэд 20 га талбайд шинээр 1600 айлын орон сууцны хорооллын барилгажилтын төсөл хэрэгжүүлэхээр хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон дэд бүтцийн зураг төслийг боловсруулуулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан “Хот байгуулалтын кадастр”-ын мэдээллийн цахим санд оруулсан.		
54	7. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн	Аймгийн хэмжээнд 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 16:00 цагт газар хөдлөлтийн зарлан мэдээллийн дуут дохиогоор ажилласан. Зарлан мэдээллийн чанга яригч бүхий дуут цамхаг 3, сирень дохио 19, тээврийн хэрэгсэл дээр суурилсан дуут дохио 25, тусгай дуут дохио бүхий автомашин 6 дуу гаргаж иргэд, олон нийтэд мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийн дагуу сургууль дадлагад оролцож аймгийн хэмжээнд нийт 366 цэг байршилд 43805 иргэн цугларч, дадлага сургуульд амжилттай	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

		түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;	хамрагдсан. Аймгийн хэмжээнд Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн 2214 гишүүн, 825 төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын 12251 ажилтан, алба хаагч, 33 сургууль, 42 цэцэрлэгийн 20238 хүүхэд, 19 сумын 112 багийн 9102 иргэн газар хөдлөлтийн гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд хамрагдсан.		
55	8. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх.	Газар хөдлөлтийн байнгын ажиллагаатай дэд зөвлөл тайлант онд 1 удаа хуралдсан. Зөвлөлийн гишүүдэд газар хөдлөлт сэдвээр сургалт зохион байгуулсан бөгөөд нийт 15 удирдах бүрэлдэхүүн хамрагдаж, тайлант онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 15 заалт бүхий төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газарт хүргүүлж ажиллав. Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 5 заалт, газар хөдлөлтийн гамшгийн дараах нөхөн сэргээх арга хэмжээний 30 заалт тусгагдан хэрэгжилтийг ханган ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		
56	1.5/. Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2017 онд багтаан дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах;	Улсын төсвийн 14, иргэн, аж ахуйн нэгжийн 38 нийт 52 барилгын архитектур төлөвлөлтийн даалгаварт “Газар хөдлөлт”-ийн холбогдох норм, дүрмийг оруулж тухайн сум, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулан хянан баталж ажилласан. Ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгуудыг буулгаж тухайн суурин дээр нь дараах барилгуудыг шинээр барихаар төлөвлөсөн. Тухайн барилгын ажлын зураг төсөвт хуучин барилгыг буулгах зураг төсвийг боловсруулан хүлээн авч ажилласан. Үүнд: Аймгийн төвийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн хуучин агуулахын барилгыг	Хэрэгжих шатанд 70.0 хувь		

			буулгаж шинээр лаборатори, конторын барилга, Хүүхдийн төлөө төвийн хуучин барилгыг буулгаж шинээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга, Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн хуучин өргөтгөлийн барилгыг буулгаж шинээр 320 хүүхдийн өргөтгөлийн сургуулийн барилга, Гучин-Ус сумын хуучин бага сургуулийг буулгаж шинээр 250 суудалтай спорт заалны барилга, Өлзийт сумын хуучин эмнэлгийг буулгаж шинээр 15 ортой эмнэлгийн өргөтгөлийн барилга, Хархорин сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн хуучин агуулахыг буулгаж шинээр 320 хүүхдийн сургуулийн барилгуудын угсралтын ажил явагдаж байна. “Барилга, байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам” 2023 онд өөрчлөгдсөнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны А/694 дүгээр захирамжаар орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. Мөн аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 1990 онд баригдсан хуучин 3 блок барилгад паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргуулахаар “Бүүвэй цагаан барс” ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд гүйцэтгэлийн ажил эхэлсэн.		
11	57	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 2020-05-13 Дугаар 2020 №52 3.1/. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн	“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 хөгжүүлэх үндсэн чиглэлтэй тус тус уялдуулан аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж шаадлагатай эх үүсвэрийг улс, орон	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай: 1/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх;	нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөрт тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Дээрх бодлогын баримт бичигтэй уялдуулан 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулан 5 бодлого, 42 зорилтын хүрээнд 112 арга хэмжээ, 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулан 4 бодлого, 104 арга хэмжээг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.		
12	58	МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2022-11-11 Дугаар 2022 №72 1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах;	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-д тусгагдсан манай аймагт хамаарах улсын төсвөөр хэрэгжүүлж буй барилга угсралтын 41, авто замын 2 төсөл арга хэмжээ нь он дамжин санхүүжиж буй төсөл арга хэмжээ болно. 2023 онд манай аймагт шинээр баригдаж төсөл арга хэмжээ байхгүй.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	59	1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтад "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-д		

		хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах;	тусгагдсан манай аймагт хамаарах шинээр барих барилга угсралтын 25, авто замын 4 төсөл арга хэмжээний зураг төслийг санхүүжилтийн эх үүсвэрийг батлагдсаны дараагаар боловсруулсан.		
	60	1.10. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аймгийн байнгын оршин суугч иргэдэд орон нутгийн нислэгийн тийзийн үнийн хөнгөлөлтийг үзүүлэх.	Өвөрхангай аймаг нь Улаанбаатар хотоос 430 км-ын зайд оршдог бөгөөд иргэд хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ болон хувийн тээврийн хэрэгслээр Улаанбаатар хот болон орон нутагт зорчдог тул аймгийн хэмжээнд орон нутгийн нислэг хийдэггүй.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Орон нутагт хамааралгүй заалт тул хяналтаас хасуулах саналтай.)	
13	61	ОРХОНЫ ХӨНДИЙД "ШИНЭ ХАРХОРУМ" ХОТ БАЙГУУЛАХ ТУХАЙ 2023-01-12 Дугаар 2023 №07 2.1. "Шинэ Хархорум" хот байгуулах газрын байршил, хэмжээг тогтоож, холбогдох хууль тогтоомжийн дагуу тухайн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах;	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар "Аймгийн зарим газар нутгийг улсын тусгай хэрэгцээнд авах санал уламжлах тухай" 21/01 дугаар тогтоолыг баталж Засгийн газарт "Шинэ Хархорум" хот байгуулах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай саналыг хүргүүлсэн. Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор "Шинэ Хархорум" хот байгуулах 189363.19 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. Үүнээс 55828.3 га газар нь Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дэвсгэрт байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	62	2.3. "Шинэ Хархорум" хотыг байгуулах ажлыг удирдан зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох, бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, түүнд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төсөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх.	Орон нутагт хамааралгүй заалт.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Орон нутагт хамааралгүй заалт тул хяналтаас хасуулах саналтай.)	

14	63	ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-05-04 Дугаар 2023_32 1.3. Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, үйл ажиллагааг жигдрүүлэх.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан аймаг, сумдын төрийн байгууллагуудад ёс зүйн дэд хороодыг байгуулж, тус хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд энэ оны жилийн эцсийн байдлаар нийт 119 байгууллагын ёс зүйн дэд хороонд 475 төрийн албан хаагч гишүүнээр ажиллаж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хороо болон Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” болон хууль хэрэглээний талаарх сургалт мэдээллийг 13 байгууллагын 200 гаруй төрийн албан хаагчдад зохион байгуулж, ёс зүйн дэд хороодод арга зүйн зөвлөмж, чиглэлийг тухай бүр өгч ажиллав.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
15	64	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2023-06-30 Дугаар 2023_59 3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай.	Шинэчлэн батлагдсан авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр шинэчлэн баталж, сум, агентлагуудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, үр дүнг тооцож хэвшсэн. Сум, агентлагуудын төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийн дундаж тайлант онд 78.0 хувьтай урд оны мөн үетэй ижил байна. Жил бүр төлөвлөгөөний биелэлтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газраас зарласан аян, арга хэмжээтэй уялдуулан төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, иргэд, олон нийтэд чиглэсэн тодорхой нөлөөллийн аян, арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийттэй хамтран зохион байгуулж ажиллав. Авлигатай тэмцэх газар, аймгийн Прокурорын газартай хамтран ажиллаж, аймгийн төрийн албан хаагчтай холбогдсон авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн энэ оны 10 дугаар сарын байдлаарх буюу сүүлийн 4 жилийн тоон судалгааг гаргаж, төрийн албан хаагчдын авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчилд	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			холбогдож буй шалтгаан нөхцөлийг судалгаанд үндэслэн тогтоож, шаардлагатай сургалт мэдээллийг өгч, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа авч хэрэгжүүлж ажиллав. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах сарыг энэ оны 05 дугаар сард зохион байгуулсан бөгөөд аймаг, сумын төрийн болон төрийн бус 31 байгууллага нийт 380 гаруй албан хаагчид, 1200 гаруй иргэдийг оролцуулав. Хууль, эрх зүйн танин мэдэхүйн болон уриалга бүхий 2 нэвтрүүлгийг бэлтгэн, олон нийтэд сурталчилсан бөгөөд орон нутгийн олон гишүүдтэй цахим хуудсуудаар дамжуулан мэдээлж, 36.902 хандалт авсан байна. Авлигатай тэмцэх газраас жил бүр төрийн байгууллагуудад хөндлөнгийн үнэлгээг (Шударга байдлын үнэлгээ) хэрэгжүүлдэг бөгөөд уг үнэлгээгээр тус аймаг нь 2023 онд 78.8 хувьтай аймгуудын түвшинд 1 дүгээрт 2024 онд 3 дугаарт эрэмблэгдсэн сайн үзүүлэлттэй байна.		
16	65	МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-11-10 Дугаар 2023_93 1.2. Хөдөөд орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг төр, хувийн хэвшлийн түншлэл, улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрээс бүрдүүлэх замаар олон талын оролцоог хамарсан хамтын санхүүжилтээр шийдвэрлэх;	Аймгийн хэмжээнд Хархорин суманд 28 айлын 1 орон сууц, Арвайхээр суманд 157 айлын 5 орон сууц нийт 185 айлын 6 орон сууц ашиглалтад орсон. Тус орон сууцнууд иргэн болон аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдан ашиглалтад орсон байна. 2025 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн 554 айлын 6 орон сууцны барилга угсралтын ажил 30-70 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байна. Энэ оны жилийн эцсийн байдлаар олон улсын төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан болон санхүүжүүлж буй орон сууц, барилга байхгүй. Мөн нийт ашиглалтад орсон болон баригдаж байгаа, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авсан 11 орон сууцны м²-ийн үнэ 2.8-3.5 сая хүртэл үнэтэй байна. Аймгийн хэмжээнд орон сууцны нийлүүлэлт нэмэгдэж байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

	66	1.10. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах;	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 22 төсөл арга хэмжээний ажлын зураг төслийн гүйцэтгэгч байгууллагуудын архитектур төлөвлөлтийн даалгавар, ажлын зураг төслийн даалгаварт хөгжлийн бэрхшээлтэй иргэний Монгол улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт MNS 6056:2003, 6055:2009/; “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04 болон холбогдох хууль тогтоомжийг тусган ажилласан. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ашиглалтад орсон 8, хувийн хэвшлийн хөрөнгөөр ашиглалтад оруулсан 4 төсөл арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний ариун цэврийн өрөөг зураг төсөвт тусган гүйцэтгүүлж хүлээн авсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан гадна налуу замыг стандартын дагуу хийлгэж, барилга байгууламжийг ашиглалтад оруулах 19 удаагийн комиссийн бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлийг оролцуулан хүлээн авсан байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
17	67	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2024-01-12 Дугаар 2024_05 1.6. төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах.	Тайлант онд Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг операторын горимоор хүргэх цэг нээн ажиллуулсан. Ингэснээр аймгийн хэмжээнд Төрийн үйлчилгээ-мэдээллийн төв, 18 сумын Засаг даргын Тамгын газрын оператор, Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн 2 цэгээр дамжуулан төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд цахимаар буюу операторын горимоор хүргэж байна. Төрийн үйлчилгээг цахимаар хүргэх үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бөгөөд иргэдийн цаг, зардлыг хэмнэн, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах боломжийг бүрдүүлж байна. 2024 онд операторын горимоор 33597 үйлчилгээг үзүүлсэн байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

18	68	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2024-01-17 Дугаар 2024_11 1.1. төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, хураамжийн ногдуулалт, түүний зарцуулалтын талаар судалж, дүгнэлт, саналаа 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд ирүүлэх;	Төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, хураамжийн ногдуулалтыг хууль, журамд нийцүүлэн тогтоосон тул үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	69	1.2. төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, хураамж болон тэдгээрийн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомж зөрчсөн төлбөр, хураамжийг хүчингүй болгох арга хэмжээ авах.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 05/07 тогтоолоор Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг заасан хязгаарт багтаан шинэчлэн тогтоосон. Ингэснээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 06 дугаар сарын 27-ний өдрийн 08/05 дугаар тогтоолын хавсралтын зарим заалтыг хүчингүй болгосон. Үүнийг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2024 оны 5 дугаар сард бүртгүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
19	70	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024-04-18 Дугаар 2024_27 2.2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн	Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гуравдугаар бүлэг болох засаглалын бодлого хэсгийн зорилт нэг (Төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, давхардлыг арилгах, үйл ажиллагааны уялдааг хангах замаар үр ашигтай бүтэц бүхий мэргэшсэн чадварлаг, тогтвортой, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлнэ)-ийн хүрээнд “Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон дүгнэж, мэдээллийн санг бүрдүүлнэ”, “Төрийн албаны сонгон шалгаруулалт, хүний нөөцийн томилгоо, сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой шийдвэрийг бүх байгууллагад ил тод, нээлттэй болгоно” гэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай.	Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дөрөвдүгээр бүлэг (Төрийн бүтээмж-цахим засаглал)-ийн орон нутгийн хүний нөөцийн бодлого төлөвлөлт хэсгийн Чадахуйн зарчимд суурилсан ёс зүйтэй, мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний үр нөлөөг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг бууруулахыг зорин дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд: -Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг мөрдөх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. -Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэж, хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно. -Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог чадавхжуулах, ёс зүйн дэд хорооны ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан тогтвортой ажиллах хөшүүрэг болох урамшууллыг олгоно гэж тусгасан.		
20	71	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-05-02 Дугаар 2024_37 2.а. бүх шатны боловсролын сургалтын байгууллага, дотуур байрны гадаад болон дотоод орчны аюулгүй байдлын стандартыг хангуулах, боловсролын байгууллагын барилга, өргөтгөлийн	Аймгийн хэмжээнд дотуур байрнуудын нөхцөл байдал, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, засан сайжруулах ажлын эрэмбэ, дарааллыг боловсруулан, Уянга сумын 2 дугаар сургуулийн 100 хүүхдийн дотуур байрны шинэ барилгыг улсын төсвийн 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар эхлүүлж, барилга угсралтын ажил 40.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол Хархорин сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрны дээвэр, гадна фасад, Төгрөг сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны дээвэр, шал, Бүрд сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны дээвэр, Сант сумын дотуур байрны дээврийн засварыг орон нутгийн төсөв, орон нутгийн	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		ажилд төр, иргэний хамтарсан хөндлөнгийн хараат бус хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;	хөгжлийн сангийн 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн бол орон нутгийн хөгжлийн сангийн 185.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр сумын 1 дүгээр сургууль, Бат-Өлзий, Баян-Өндөр, Богд сумдын дотуур байранд хатуу зөөлөн эдлэлийг шинэчилж, 19 дотуур байрыг төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгосноор дотуур байранд амьдардаг хүүхдүүдийн ая тухтай орчинд амьдрах эрх хангагдаж байна.		
72	2.6. хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн эрхийг хангах хүрээнд тэднийг дэмжих төв ажиллуулж, тохирох орчныг бүрдүүлэх, тусгай сургалтын хэрэглэгдэхүүн бий болгох, эцэг, эхийн оролцоог хангаж, багшийн туслахаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, багш, багшийн туслах, ажилтанд нэмэгдэл хөлс олгох хуулиар тогтоосон арга хэрэгслийг үр дүнтэй хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авах;	2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй 446 суралцагчийн 185 суралцагч ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа бөгөөд хичээл заадаг 105 багшид 10 хувийн нэмэгдлийг сар, улирлаар тооцон тогтмол олгож байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй 350 гаруй багш, ажилтан албан хаагчдыг 6 удаагийн цахим болон танхимын сургалтад хамруулж мэргэжил арга зүйг дээшлүүллээ. Монгол Танака бине оюун ухааны сорил авагчаар 2 албан хаагчийг нэмж бэлтгэж, аймгийн хэмжээнд нийт 7 сорил авагчтай болж, жилийн эцсийн байдлаар 9 хүүхдийг оюун ухааны сорилд хамруулж, дүгнэлт зөвлөмжийг эцэг эх, асран хамгаалагч болон тэдний зөвшөөрлөөр анги удирдсан багш нарт өгч арга зүйн дэмжлэг үзүүлээд байна. Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл, Салбар комисс хамтран Бат-Өлзий, Хужирт сумдад ажиллаж, тус сумдын 4 сургууль, 7 цэцэрлэгийн Дэмжлэгийн багийн 45 гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа 11 багшид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, 5 ангид анги ажиглалт зохион байгууллаа.	Хэрэгжих шатанд 70.0 хувь		

	73	3.в. аймаг, дүүрэг бүрд байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд зориулсан нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, боловсрол олгох, өдөр өнжүүлэх хөгжлийн төв болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асрамж халамжийн төв байгуулах, холбогдох санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх.	Аймгийн хэмжээнд төрөлхийн болон олдмол хөгжлийн бэрхшээлтэй 3585 гаруй иргэн бүртгэлтэй байгаагаас энэ онд нийгмийн халамжийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт 744 иргэн хамрагдаж 2.4 тэрбум, хөнгөлөлт тусламжид 2500 иргэн хамрагдаж 450.0 сая, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 531 хүүхэд хамрагдаж 2.0 тэрбум төгрөг тус тус нийгмийн халамжийн сангаас зарцуулсан байна. Сэргээн засах төвийн харьяа Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын ажил 40.0 хувьтай явагдаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
21	74	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2024-08-27 Дугаар 2024_21 2.3. 3/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
	75	2.4. 4/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан аймаг, орон нутагт хамаарал бүхий 5 бүлэг, 62 зорилт, 117 арга хэмжээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хүрээнд холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 91.2 хувийн хэрэгжилттэйгээр тайлагналаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим санд жил бүрийн 2 дугаар сарын 01-ний дотор байршуулж, баталгаажуулж хэвшсэн.		
Хэсгийн дундаж: 91.4					
Монгол Улсын Их Хурлын Байнгын Хорооны тогтоол					
22	76	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ 3.1/. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний статистик ирүүлэх)	Сүрьеэгийн эрт илрүүлэлтэд хамрагдвал зохих эрсдэлт бүлгийн 8314 иргэний судалгааг шинэчлэн гаргаж эдгээр иргэдийн 72.0 хувийг илрүүлэг, үзлэг, шинжилгээнд хамруулан, сүрьеэгийн 59 тохиолдлыг эрт илрүүлж, эмчилгээ хяналтад авч, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн нарийн мэргэжлийн эмч нарын баг Бат-Өлзий, Богд суманд сүрьеэгийн илрүүлгийг зохион байгуулж, эрсдэлт бүлгийн 113 иргэнийг хамруулахад шинэ тохиолдол бүртгэгдээгүй. 18 суманд дэмжлэгт хяналт хийж, ажлын байранд 360 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт хийж, мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласны үр дүнд сорьц тээвэрлэлт 48.0 хувиар нэмэгдэж, Сант, Есөнзүйл сум сүрьеэгийн шинэ тохиолдлыг илрүүлсэн. Глобаль сангийн дэмжлэгтэйгээр Монгол улсын ДОХ, Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тусламж үйлчилгээний үндсэн тогтолцоог бэхжүүлэх нь хөтөлбөрийн “Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сумын эрүүл мэндийн төвийн түвшинд бэхжүүлэх” дэд хөтөлбөрийн 2024-2026 онуудад хэрэгжүүлэх төслийн хүрээнд 18 суманд 19 олон нийтийн эрүүл мэндийн ажилтныг бэлтгэн, хамтран ажиллах гэрээ байгуулж, энэ оны 4 дүгээр сараас эхлэн ажиллуулж байна. Бэлгийн замаар дамжих халдвар илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд зорилтот бүлгийн 22976 иргэний судалгааг аймгийн хэмжээнд гарган, тайлант хугацаанд 19659 иргэн буюу 85.5 хувь нь хамрагдсан. Үзлэг, шинжилгээгээр бэлгийн	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

			замаар дамжих халдварт өвчний 127 тохиолдол бүртгэгдэн, тандалт судалгааг хийж, хавьтлыг тогтоон, нийт тохиолдлын 74.8 хувийг эмчлэн эрүүлжүүлсэн. Нийт бүртгэгдсэн халдварт өвчнийг бүтцээр нь авч үзвэл 159.8 хувийг тэмбүүгийн өвчлөл эзэлж өмнөх оны мөн үеэс 36.1, трихомоназийн өвчлөл 33.3 хувиар тус тус буурч, заг хүйтний өвчлөл 9.3 хувиар өссөн байгаа ч дээрх 3 өвчлөл улсын дунджаас 5.2-6.3 хувиар бага байна.		
23	77	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ 2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах;	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Аймгийн эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөөнд Бэлгийн замаар дамжих халдварт өвчинтэй, тэмцэх, сэргийлэх чиглэлээр 3 үйл ажиллагааг салбарын хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 04 дүгээр саын 11-ний өдрийн А/133 дугаар тушаалаар батлагдсан “БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тусламж үйлчилгээ үзүүлэх журам”, эмнэлзүй, эмчилгээ, оношилгооны чиглэлээр эрүүл мэндийн байгууллагын эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэг эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарын мэдлэгийг дээшлүүлж чадавхжуулах цахим сургалтыг зохион байгуулсан. Сургалтад БОЭТ, Хархорин сумын Хэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 40 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

	78	2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих.	Иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор энэ онд нийт 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг боловсруулан, орон нутгийн төсвөөс 225.0 сая төгрөгийг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
24	79	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ 3.8. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах.	“Хөөрхөн зүрх” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан “Сэтгэцийн гэмтэлд суурилсан нийгэм-сэтгэлзүйн анхан шатны зөвлөгөө, үйлчилгээг бэлгийн хүчирхийллийн даван туулагч хүүхдэд үзүүлэх нь” танхимын сургалтад 69 албан хаагч, “Галт шувуу” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан “Нийгмийн ажилтнуудийг чадавхжуулах нь” цахим кейс хэлэлцүүлэгт Арвайхээр сумын 13 багийн Нийгмийн ажилтан тус тус хамрагдсан байна. Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагаас бүртгэгдэж, шилжүүлсэн 85, илрүүлэн ажилласан 80, нийт 165 тохиолдолд газрын мэргэжилтнүүдтэй хамтран кейс нээн ажиллаж, илрүүлсэн кейсийн шийдвэрлэлт 85.0 хувь, хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлагын шийдвэрлэлт 81.0 хувьтай байна. Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, түүний ажлын алба нь энэ оны жилийн эцсийн байдлаар 76 хүүхдэд үйлчилгээ үзүүлснээс сэжигтэн 21, хохирогч 6, холбогдогч 39, гэрч 10, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 10 хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх, холбон зуучлах болон боловсрол, эрүүл мэнд, хууль эрх зүй, сэтгэл зүйн үйлчилгээг 68 удаагийн давтамжтай үзүүлж ажилласан.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
25	80	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2020-08-26 Дугаар 2020.08.26 №01 ИЦББХ	Энэ онд Бат-Өлзий сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, Хужирт сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль шинээр үүсгэн байгуулагдаж ашиглалтад орсон бөгөөд эдгээр сургуулиудад аймгийн Мэдээлэл, харилцаа	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		3. Бүх шатны боловсролын байгууллагын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтцийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, бэлэн байдлыг үе шаттай хангуулах	холбооны газраас нийт 10.0 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийг нийлүүлж, Богд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, Хархорин сумын Номын хүрдэн сургуулиуд шинээр шилэн кабельд холбогдсоноор аймгийн боловсролын байгууллагууд 100.0 хувь шилэн кабель, интернет сүлжээнд холбогдлоо. Сүлжээний тоног төхөөрөмж, шилэн кабелийн ашиглалт, хэвийн ажиллагааг Эрдэмнэт болон Мэдээлэл, харилцаа холбооны газартай хамтран хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол хийж, мэдээлэл технологийн дэд бүтцийн тасралтгүй хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.		
26	81	Чиглэл өгөх тухай 2020-12-16 Дугаар 2020 №10 БОХХААБХ 1.1/. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2020 оны 07 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай: 1/ Мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, мах, махан бүтээгдэхүүнийг экспортолдог аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх;	“Өв эко мийт” ОНӨХХК-ийн махны үйлдвэр “Танассан интернэйшнл трейд” ХХК-тай гэрээ байгуулан, малчдаас 38534 толгой хонь худалдан авч, 799.3 мянган тн хонины махыг халал аргаар бэлтгэн, Иран улс руу экспортод нийлүүлсэн. Мөн “Дээжийн өргөө” ХХК Иран улсын төлөөлөгчтэй гэрээ байгуулан, 16135 толгой хонь худалдан авч, 322.7 мянган тн хонины махыг халал аргаар бэлтгэн, Иран улс руу экспортолж байна. Энэ оны намар 7266.6 тн мах үйлдвэрийн аргаар бэлтгэн нийлүүлээд байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь Хяналтаас хасуулах саналтай. (Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон)	
	82	1.5/. Экспортод гаргаж байгаа мах, махан бүтээгдэхүүний тодорхой хувь нь чанар, стандартын шаардлага хангахгүй байгаа тул мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг сайжруулж, оновчтой зохион байгуулалт хийх;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан “Улсын хэмжээнд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 08-00-02/29 тоот удирдамжаар мал төхөөрөх 4 аж ахуйн нэгж, мах боловсруулах 1 аж ахуйн нэгж, нийт 5 аж ахуйн нэгжийн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалтыг хийлээ.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

			Хяналтын хуудсаар үнэлэхэд 2 дунд, 2 их эрсдэлтэй дүгнэгдсэн. Мах боловсруулах үйлдвэрлэл 27.2 хувь бага эрсдэлтэй дүгнэгдлээ. Шалгалтын явцад нийт 558 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчил арилгуулахаар улсын байцаагчдын хамтарсан нийт 93 заалт бүхий 4 албан шаардлага, 1 дүгнэлт үйлдэн хүргүүлж, 8000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл тус тус ногдуулав. Салбарын улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр их эрсдэлтэй үнэлэгдсэн 2 объектын үйл ажиллагааг зогсоов.		
27	83	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-05-25 Дугаар 2021 №05 БСШУСБХ 1.2/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрыг стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн шинээр барих, засварлах, өргөтгөх болон стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг шийдвэрлэх;	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг 34 сургууль өөрийн гал тогоогоор 100.0 хувь үйлдвэрлэн, халуун хоол, ундаар үйлчилж байна. Энэ онд Гучин-Ус сумын цэцэрлэг 27.0 сая төгрөгөөр хүнсний агуулах, Арвайхээр сумын 1, 2, 15 дугаар цэцэрлэг, Бат-Өлзий сумын 3 дугаар цэцэрлэг, Сант сумын цэцэрлэг, Арвайхээр сумын 1 дүгээр сургууль, Баянтээг багийн сургуулиуд нийт 31.0 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, мөн Нарийнтээл сумын сургууль 30.0 сая, Өлзийт сумын сургууль 15.0 сая, Хайрхандулаан сумын сургууль 51.0 сая, нийт 154.0 сая төгрөгийг тус тус орон нутгийн төсвөөс хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, хоол үйлдвэрлэлийн орчин нөхцлийг сайжруулахад зарцуулсан байна. Ингэснээр аймгийн сургууль, цэцэрлэгүүд гал тогооны тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдлаа.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	84	1.9/. ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд мэргэжлийн хяналтын байгууллагаар үнэлгээ хийлгэж, санал дүгнэлтийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, цаашид үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга	Энэ оны жилийн эцсийн байдлаар нийт 22 цэцэрлэг, 15 сургуулийн хоол үйлдвэрлэлийн орчин нөхцөл, хүүхдийн хоол хүнсний хангамж, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний худалдан авалт, хадгалалт, хоол хүнсний чанар хүртээмжид хяналт тавьж, арга зүйн зөвлөгөө дэмжлэг өгч ажиллав. Мөн тогооч, туслах тогооч болон багш, ажилчдад "Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд тавигдах шаардлага, эрүүл ахуй", эцэг эх, асран хамгаалагч, дотуур байрны сурагчдад "Шим	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах;	тэжээлийн боловсрол, зөв зохистой хооллолт,” сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоол үйлдвэрлэлийн ажилчдад “Хоол хүнсний илчлэг норм тооцох аргачлал” сэдвээр сургалт зохион байгуулж нийт 480 гаруй хүн хамрагдав. Хяналт хийхэд хоол хүнсний илчлэг буруу тооцоолох, гал тогоонд мөрдөгддөг бүртгэл хөтлөлт дутуу, түүхий эд материалыг их хэмжээгээр татаж нөөцөлдөг, хүүхдийн хоол хүнсэнд хориглодог хүнсний бүтээгдэхүүн хэрэглэдэг, технологи картыг мөрдөж ажилладаггүй, хоолны нэр төрөл цөөн байх зэрэг зөрчлүүд давтамжтай илэрснийг арилгуулахаар зөвлөмж, чиглэл өгч, 100.0 хувь арилган, эрсдэл буурсан болно.		
85	1.10/.	орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах ажлыг эхлүүлэх;	Сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг аймгийн хэмжээнд ерөнхий гэрээгээр зохион байгуулахаар ажлын тендер зарлахад 2 аж ахуй нэгж материалаа ирүүлсэн бөгөөд тус аж ахуйн нэгжүүд бичиг баримтын зөрчилтэй, Нийгмийн даатгалд төлбөрийн үлдэгдэлтэй шаардлага хангаагүй байна. Одоогоор ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд хүнсний ханган нийлүүлэлтийн тендерийг байгууллага дээрээ зарлан, шалгарсан аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
86	1.11/.	2022 оноос эхлэн хуулийн хэрэгжилтэд шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсөвт бүрэн тусгах, аж, ахуйн нэгж, байгууллагын хандив, олон улсын байгууллага, гадаад орнуудын буцалтгүй тусламжийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх.	Японы Хүүхдийг Ивээх Сангаас хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслөөс зарласан “Сургуульд суурилсан энтрепрайс” хөтөлбөрт Богд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн суралцагчдын “Өглөөний цайг өөртөө” төсөл 110.0 сая төгрөг, Хархорин сумын 2 дугаар сургуулийн “Үйлдвэрлэгч хүүхдүүд” төсөл 53.0 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэгийг тус тус авснаар үйл	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

			ажиллагаагаа чиглүүлэгч багш, ажилтны хамтаар суралцагчид удирдан хэрэгжүүлж байна. Үүнд өглөөний цайг өөртөө төслийн сурагчид зууш, халуун уух зүйлсийг бэлтгэн сургуулийн цайны газраар дамжуулан багш сурагчдад хүргэдэг бол үйлдвэрлэгч хүүхдүүд төслийг хэрэгжүүлэгч сурагчид гар урлалаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулахаас гадна сургуулийн гал тогоогоор дамжуулан чацаргана, аньс зэрэг төрөл бүрийн жимсний халуун хүйтэн шүүс зэрэг уух зүйлийг бэлтгэн борлуулж, орлогыг сургуулийн өөрийн орлогод нийлүүлдэг байна.		
28	87	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19 Дугаар 2021 №8 БСШУСБХ 1.1/. Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: 1/ Биеийн тамир спортын тухай хууль, МУЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг МУЗГ, бүх шатны ИТХ, аймаг, нийслэлийн Засаг дарга, биеийн тамир, спортын Улсын хороо хангаж ажиллах;	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Биеийн тамир, спортын салбарт хамаарах 2 зорилт 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр орон нутгийн бодлогын баримт бичиг, байгууллагын төлөвлөлтөд жил бүр нарийвчлан тусгаж холбогдох үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа. Дээрх бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг өссөн дүнгээр нэгтгэн гаргаж Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	88	1.5/. бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг	Биеийн тамир, эрүүл мэнд хичээлийн шинэчилсэн хөтөлбөрийг турших сургалтад 2 ерөнхий боловсролын сургуулийн бага боловсрол хариуцсан	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		боловсронгуй болгох, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагчдыг спортын секц, дугуйланд хамран суралцуулах бололцоог бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	сургалтын менежер, биеийн тамирын багш нар хамрагдаж, мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлсэн. Мөн аймгийн Боловсролын газраас биеийн тамир, эрүүл мэнд хичээлийн шинэчилсэн хөтөлбөрийн хичээлийн явцтай танилцаж, эцэг эх, сурагчид, багш нартай ярилцлага хийн, биеийн тамирын багш нарт зөвлөгөө зааварчилгаа өгсөн. Аймгийн хэмжээнд 28 биеийн тамир, спортын төрлийн секц, дугуйланд 9784 суралцагч хамрагдаж байна.		
89	1.6/. Биеийн тамирын багш, дасгалжуулагч, арга зүйч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, тэдгээрийг гадаад улсад бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Ерөнхий боловсролын сургуулиудын дунд хөлбөмбөгийн спортыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, биеийн тамирын багш нарыг чадавхжуулах зорилгоор “Хөл бөмбөгийн D зэрэглэлийн дасгалжуулагч бэлтгэх” сургалтыг Монголын хөл бөмбөгийн холбоо, аймгийн хөл бөмбөгийн холбоотой хамтран Арвайхээр суманд зохион байгуулж, нийт 12 сумын 16 биеийн тамирын багш 3 өдөр онол, практикийн хичээлд хамрагдаж, шалгалт өгснөөр 15 багш тэнцэж, "D" зэрэглэлийн дасгалжуулагчийн сертификиад авсан байна. Мөн биеийн тамирын багш нарын онолын мэдлэгийг дээшлүүлж, заах арга зүйг сайжруулах, сурагчдын чанарт ахиц гаргах, ээлжит хичээлийн үр дүн тодорхой хувиар нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан сургалтад ерөнхий боловсролын 33 сургууль, мэргэжлийн боловсролын 1 сургуулийн нийт 80 багш хамрагдаж мэргэжил, ур чадвараа нэмэгдүүллээ.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		
90	1.12/. Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг	Биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээг нэмэгдүүлэх хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар энэ онд Бат-Өлзий суманд сагсан бөмбөгийн 3х3 талбай, Төгрөг суманд 2 сагсны талбай, Богд суманд сагс, волейбол, хөлбөмбөгийн талбай тус тус шинээр ашиглалтад орсон. 2025 онд улсын төсвийн 8.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Сант, Гучин-Ус, Уянга сумын сургуулиудад	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

		нэмэгдүүлэх, жил бүрийн улсын төсвийн төсөлд биеийн тамир спортын салбарын зардлыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах.	тус бүр 250 хүүхдийн хүчин чадалтай спорт заалыг барьж байгуулахаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулагдаад байна.		
29	91	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БОХХААБХ 1.5/. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, таримлын зохистой сэлгээг сонгон нэвтрүүлж, малын тэжээл болон бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, рапсын тариалалтыг нийт тариалсан талбайн 15 хувиас хэтрүүлэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, сэлгэн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор нэг талбайд нэг таримлыг 3 жилээс ихгүй тариалах, хөрс боловсруулалтын ажлыг тариалалтын ажилтай хамтатган хийх зэргийг мөрдөн ажиллаж байна. Энэ онд улаан буудай 6700 га, бусад үр тариа 428 га, төмс 387 га, хүнсний ногоо га, тосны ургамал 5200 га, нийт 19587.6 га талбайд тариалалт хийсэн байна. Энэ нь улаан буудай 34.2 хувь, бусад үр тариа 2.1 хувь, төмс 1.9 хувь, хүнсний ногоо 1.4 хувь, малын тэжээл 28.8 хувь, жимс, жимсгэнэ 4.7 хувь, тосны ургамал 26.5 хувийг тус тус эзэлж байна. Сүүлийн жилүүдэд байгаль цаг уурын нөхцөл байдлаас хамааран улаан буудайн ургац алдах, чанарын шаардлага хангахгүй байдлаас шалтгаалж сэлгэн тариалалтаар тосны ургамлын тариалалт нэмэгдэж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	92	1.9/. Хүнсний хангамж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор усны эх үүсвэр бүхий газарт төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, малын тэжээл, ашигт таримал тариалах, мод үржүүлгийн газар байгуулахад шинээр газар олгох асуудлыг судалж шийдвэрлэх, нийслэл хот, говийн бүсийн болон хүн ам төвлөрсөн томоохон суурин газруудыг түшиглэн өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуй, хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулахад урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, хүлэмжид	Арвайхээр сумын хүлэмжийн цогцолбор аж ахуйд газар авахаар хүсэлт өгсөн 35 иргэнд энэ оны 04 дүгээр сард хөрс бэлтгэх, хүлэмж барих технологийн цогц сургалтыг “Бизнесийн шинэ санаа” ТББ-тай хамтран зохион байгуулсан. Тус цогцолборт 7200 м ² бүхий 60 ш зуны хүлэмж, 2-оос доошгүй өвлийн хүлэмж барих зураглал гаргаж, энэ онд 32 иргэн 120 м ² , 5 иргэн 60 м ² хэмжээтэй хүлэмжийн газрыг тус тус хэмжүүлж авсан бөгөөд, 2 дахь жилдээ 600 м ² талбайд тариалалт хийгдэж байна. Энэ онд тус цогцолборт 600 м ² талбайд тариалалт хийгдэж, сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс үерийн хамгаалалтын шуудуу 700 м, 944 м хамгаалалтын тор татах ажилд 4.4 сая төгрөг зарцуулсан. Мөн тус	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		хэрэглэсэн цахилгааны хөнгөлөлтийн цагийн хугацааг уртасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	цогцолборт хамгаалалтын ойн зурвас байгуулах зорилгоор хаврын тарилтаар 400 ширхэг хайлаас, намрын тарилтаар өрөл, агч, долоогоно, монос зэрэг 4 нэр төрлийн мод бутыг тарьж, сумын Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаас 11.0 сая төгрөг зарцууллаа. Өрхийн тариалан бизнес хөгжил ТББ-аас Төгрөг сумын 1 хоршоонд 60 м ² хүлэмжийн дэмжлэг үзүүлсэн. ХХҮГ-ын ХЭДС-гийн дэмжлэгт Баян-Өндөр сумын 2 иргэн хамрагдаж тус бүр 32 м ² бүхий хүлэмжийг ашиглалтад оруулаад байна. ЖДҮХС-гийн хөнгөлөлттэй 349.5 сая төгрөгийн зээлд 2 аж ахуйн нэгж хамрагдаж, хүлэмж, зоорь барихаар бэлтгэл ажлаа хангаж байна. Энэ онд зуны болон нарлаг хүлэмж 124 м ² , өвлийн хүлэмж 200 м ² тус тус нэмэгдсэн. Аймгийн хэмжээнд 2000 м ² бүхий өвлийн 5 хүлэмж, 14968 м ² бүхий нийлэг хальсан 305 хүлэмж үйл ажиллагаа явуулж байна.		
30	93	"Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БСШУСБХ 1.1/. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай: 1/ төслийн 1, 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажлын зургийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баталгаажуулж, ажлын гүйцэтгэлийг хянан, тодорхой арга хэмжээ авч, ажлыг эрчимжүүлэх;	"Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүжилтээр хэрэгжиж байгаа бага оврын ариун цэврийн цэвэршүүлэх байгууламж төслийн хүрээнд санхүүжүүлсэн 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр оруулалтаар Хужирт, Нарийнтээл, Баян-Өндөр сумдын ерөнхий боловсролын сургуулийн ариун цэврийн байгууламжийн угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Бүрд, Есөнзүйл сумдын 3 сургууль, 2 цэцэрлэг, 2 дотуур байр нийт 7 барилгын ариун цэврийн байгууламжийн ажлын гүйцэтгэгч шалгаран ажлыг эхлүүлсэн боловч тодорхойгүй шалтгаанаас улмаас угсралтын ажлыг гацаасан тул гэрээг цуцлаад байна. Тухайн ажлын төсөвт өртөг нь 729.0 сая төгрөг бөгөөд дутуу орхигдсон болон сайжруулалт хийгдэх шаардлагатай ажлын төсөвт өртгийг дахин хянуулан Барилгын хөгжлийн төвөөр магадлалаар оруулаад байна. Тус ажлын дахин зарлах худалдан авах ажиллагааг Боловсролын яамнаас зохион байгуулна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

94	1.2/. төслийн 3, 4 дүгээр ээлжийн барилга угсралтын ажлыг төлөвлөгөөт хугацаанд чанартай гүйцэтгэн дуусгаж, ашиглалтад оруулах ажлыг удирдан зохион байгуулах;	Гучин-Ус, Төгрөг, Зүүнбаян-Улаан, Сант, Уянга, Баруунбаян-Улаан, Хайрхандулаан, Тарагт, Өлзийт, Баянгол, Хархорин сумдын сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжуудыг бүрэн ашиглалтад оруулаад байна. Хужирт, Бат-Өлзий сумдын ариун цэврийн байгууламжийн угсралтын ажлын явц 95.0 хувьтай байна. 2, 3, 4 дүгээр ээлжийн ариун цэврийн байгууламжууд ашиглалтад орсон.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
95	1.3/. төсөлд нэг маягийн зураг, төсөв ашиглах бол холболтын зураг төсөл, тухайлсан байршилд шинээр зураг төсөв боловсруулан гүйцэтгэхэд ажлын даалгавар, геологи, геодезийн дүгнэлт, байгаль орчны ерөнхий үнэлгээ, техникийн нөхцөлүүдийг хууль тогтоомжийн дагуу шуурхай олгох, мэргэжлийн байгууллагаар хянагдан магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан ажлын иж бүрэн зураг, төсвийг холбогдох байгууллагад 2022 оны 02 сарын 15-ны дотор хүргүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон аймгийн засаг дарга нарт үүрэг болгох;	Нэг маягийн зураг, төсөв ашигласан барилга байгууламжийн ажлын даалгавар, геологи, геодезийн дүгнэлт, байгаль орчны ерөнхий үнэлгээ, техникийн нөхцөлүүдийг хууль тогтоомжийн дагуу гаргаж магадлалын дүгнэлт гаргуулан хүлээн авсан. 2022 онд нийт барилга угсралтын 32 ажлын зургийг хүлээн авч худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажлыг эхлүүлэн нийт ажлын гүйцэтгэл 90.0 хувьтай байна. Энэ онд нийт 22 ажлын зураг төслийг хүлээн авч худалдан авах ажиллагааг зохион байгуулан гүйцэтгэгчийг шалгаруулаад ажил эхлүүлэх гэрээ байгуулсан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
96	1.5/. тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн бүтээн байгуулалтын явцад хяналт тавьж, хариуцсан чиглэлээр үүрэг, зөвлөмж өгч ажиллахыг аймаг, нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгох;	Тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн бүтээн байгуулалтын явцад хяналт тавьж, хариуцсан чиглэлээр үүрэг, зөвлөмж өгч ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
97	1.6/. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд аудит хийлгэн, аудитын дүгнэлтэд үндэслэн шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх.	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн барилга байгууламжийн ажилд Төрийн аудитын газраас хяналт хийж, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

31	98	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-04-13 Дугаар 2022 №04 БОХХААБХ 1.4/. Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох зорилгоор отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд тавигдах мал эмнэлгийн болон бусад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулах талаар онцгой арга хэмжээ авах, зарим эрсдэлтэй бүс нутгийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мал эмнэлгийн хорио цээрийн байнгын болон түр хяналтын цэгийг нэмэгдүүлж, мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлийг сайжруулах;	Аймгийн Мал эмнэлгийн газар, Онцгой байдлын газар хамтран “Бог малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж” ажиллах удирдамжийн хүрээнд Өлзийт, Баян-Өндөр, Хайрхандулаан, Баянгол, Нарийнтээл, Баруунбаян-Улаан сумдад ажиллаж шилжилт хөдөлгөөн хийсэн 1 иргэнд хариуцлагын арга хэмжээ тооцож, сумдын удирдлага, мал эмнэлгийн тасагт мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч удирдлагаар хангаж ажилласан. Мал эмнэлгийн гэрчилгээгүй мал тээвэрлэсэн, худалдаа үйлчилгээ явуулсан 3 иргэнд Зөрчлийн тухай хуулиар 450.0 нэгжээр, хонь, ямааны цэцэг өвчний хорио цээрийн дэглэм зөрсөн 4 иргэнд 200.0 нэгжээр, нийт 9 иргэн 850.0 мян/төг торгууль ногдуулж, бүрэн барагдуулан ажилласан. Сумдууд хорио цээр дэглэм хэрэгжүүлж байх үед хөдөлгөөнт эргүүл байнга ажиллуулсан. Үүнд удирдах ажилтан 37, онцгой байдлын 2 албан хаагч, малын эмч 33, туслах ажилтан 36, нийт 108 хүн, 30 техник хэрэгсэл ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	99	1.5/. Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд огцруулах хүртэл хариуцлага тооцох;	Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг төлөвлөж, шуурхай зохион байгуулж, 2023-2024 онд Биокомбинатад үйлдвэрдэсэн 172, 176 серийн дугаартай вакцин 7 удаагийн татан авалтаар 465.9 мянган тун авч 15 суманд 1051 өрхийн 400825 толгой хонинд тархвар зүйн зураглалын дагуу тарьж байгаа эсэхэд хяналт шалгалтыг хийж, вакцинжуулалтын ажилд 33 ажлын хэсэгт 99 хүн ажилласан байна. 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн дахин 490 мянган тун хонины цэцэг, бог малын мялзан өвчний хам вакциныг 490 мян.толгой хонинд мөн шүлхийн өвчнөөс урьдчилан сэргийлэх үхэр гахайн сүрэгт масс вакцинжуулалт хийгдэж эхлээд байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			Шүлхийн өвчнөөс урьдчилан сэргийлэх үхэр гахайн сүрэгт масс вакцинжуулалт 309.6 мян/толгой мал, амьтан хамрагдана.		
	100	1.6/. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Малын тоо толгойн албан татвараас 19 сумын хэмжээнд нийт 362.9 сая төгрөгийг Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд төлөвлөсөн. Үүнээс Сант, Тарагт, Хайрхандулаан сумд мал угаалгын ванн, Уянга, Зүүнбаян-Улаан сумд тарилгын хашаа барих, Бүрд, Бат-Өлзий сумд мал эмнэлгийн анхан шатны лабораторийн тоног төхөөрөмж, Гучин-Ус, Баянгол сумд халдваргүйтгэлийн дук машин авахаар төлөвлөсөн байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	101	1.7/. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд вакцин болон халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах;	Хонины цэцэг өвчний дэгдэлтийн үед 8 удаагийн татан авалтаар 1321063 толгой мал тухайн өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдаж, 99.9 хувийн гүйцэтгэлтэй, үлдсэн 1716294 толгой хонин сүрэг масс дархлаажуулалтад хамрагдаж 99.5 хувьтай хийгдэж, аймгийн хэмжээгээр 3037354 толгой хонь цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдсан байна. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх масс дархлаажуулалтад 4060500 толгой мал хамрагдахаас 4045641 толгой мал хамрагдаж 99.6 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн. Гоц халдварт өвчний вакцин, халдваргүйтгэлийн бодисыг аймагт нөөцлөх боломжгүй улсын нөөцөөс шаардлагатай үед авч хэрэглэж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
32	102	Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ 1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж	Аймгийн хэмжээнд 1 ахмадын ордон, 10 өргөө, 8 танхим үйл ажиллагаа явуулж, ахмадуудын хөгжил оролцоог хангасан арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Орон нутгийн төсвөөс аймгийн Ахмадын хорооны үйл ажиллагааны зардал, байрны халаалт, дулааны зардал, сумын ахмадын хорооны дарга нарын урамшуулалд 149.2 сая төгрөгийг зарцуулсан ба орон нутгийн төсвийн 55.0 сая	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх;	төгрөгөөр аймгийн Ахмадын өргөөний заалны тайз гэрэлтүүлэг, лед дэлгэц, хөгжим, техник хэрэгсэлийг шинэчилсэн.		
33	103	Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022 №07 ҮББХ 1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээл тариалах газрын асуудлыг шийдвэрлэх, зуны улиралд сүүний илүүдэлтэй аймгуудад сүү цуглуулах цэг болон боловсруулах үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх, импортын хуурай сүүг орлох, хадгалалтын хугацаа урттай сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам батлах тухай” 130 дугаар тогтоолоор техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн сүү боловсруулах үйлдвэр, цехэд сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгохоор заасны дагуу манай аймгаас “Арвижих дөлгөөн” сүүний цех сонгон шалгаруулалтад тэнцсэн. Энэ хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 1-нээс 2024 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл нийт 13 малчин өрхөөс 62.9 тн түүхий сүү авч, 13 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрийн аргаар боловсруулсан бөгөөд тус цехэд сүү нийлүүлсэн малчид нийт 52.0 сая төгрөгийн өвлийн сүүний урамшуулалд хамрагдсан. Журмын дагуу 2025 оны сонгон шалгаруулалтыг ХХААХҮЯ-ны ажлын хэсэг энэ оны 10 дугаар сард газар дээр нь шалгаруулсан бөгөөд Хужирт сумын “Хужирт цагаан” ХХК шалгарч, жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 50-60 малчдаас 175.0 тн түүхий сүү худалдан авч боловсруулан, 30 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлээд байна. “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаас энэ онд сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 1 аж ахуйн нэгж 85.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт хамрагдсан. Аймгийн хэмжээнд энэ онд нийт 14 үйлдвэр, цех, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж, 74.2 тн бүтээгдэхүүн үйлдвэрийн аргаар боловсруулсан бөгөөд энэ нь урд оны мөн үетэй харьцуулахад 14.5 тн-оор өссөн байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

34	104	Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №02 БОХХААБХ 1.2/. Импортлогч улсын хорио цээрийн байгууллагаас тавьж байгаа шаардлагын дагуу хяналт шалгалтыг дотооддоо зохион байгуулж, мах махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий үйлдвэр, бүтээгдэхүүний тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх;	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн Улсын хэмжээнд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 08-00-02/29 тоот удирдамжаар 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 01 дүгээр сарын 15-ны өдрүүдэд Арвайхээр, Хархорин сумдын мал төхөөрөх 4, мах боловсруулах 1, нийт 5 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”-ын дагуу хэрэгжилтийн байдалд хяналт шалгалтыг хийлээ. Дээрх гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 8 дугаар сарын 14-нөөс 09 дүгээр сарын 03-ны хооронд хийж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн “Өв эко мийт” ХХК, “Итгэлт баялаг хүнс” ХХК “Дээжийн өргөө” ХХК-ийн мал төхөөрөх 3 үйлдвэрт үйл ажиллагааны дүгнэлт гаргасан. Хархорин сумын “Далайн одод трейд” ХХК-ийн мал төхөөрөх үйлдвэрийн үйл ажиллагаа 78 хувьтай буюу их эрсдэлтэй байгаа тул дүгнэлтийг цуцалсан шийдвэр хэвээр, үйл ажиллагаа явагдаагүй байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
35	105	Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №03 БОХХААБХ 1.4/. Тусгай хамгаалалттай газар нутагт Нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрх олгосон болон Нийслэлийн нутаг дэвсгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар газар эзэмших эрх олгосон асуудлыг хуульд	Аймгийн хэмжээнд тусгай хамгаалалттай газар нутагт сумдын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрх олгосон шийдвэр гараагүй байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		нийцүүлэн шийдвэрлэж, газрын эрхийг гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах;			
36	106	Чиглэл өгөх тухай 2023-03-28 Дугаар 2023№05 НББХ 1.1.4/. асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйч, дохионы хэлний хэлмэрч, сэтгэл засалчийг ажиллуулах, онлайнаар тус үйлчилгээг авах нөхцөлөөр хангах;	Хохирогчийг хамгаалах байр буюу Нэг цэгийн үйлчилгээний төвийн хүний нөөцийн цалингийн зардал нийт 129.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэхээр аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлж ажилласан. Үүний үр дүнд орон нутгаас 2 ажилтны цалин, нэг цэгийн үйлчилгээний төвийн засварын зардлыг шийдвэрлэж өгөхөөр 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулсан. Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт мэргэжлийн сэтгэлзүйч үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгч ажиллаж байна. Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийн дэргэдэх Мэргэжлийн боловсролын төвтэй хамтран 2 иргэнийг дохионы хэлмэрч бэлтгэх ангид суралцуулж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	107	1.1.9/. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүүхдээс мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлтгэсэн өрөө бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалсан бодлогыг хэрэгжүүлж ажиллах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байцаагч ажиллуулах;	Орон нутгийн төсвийн 7.5 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Цагдаагийн газарт хүүхдээс мэдүүлэг авах өрөөг 2022 онд тохижуулсан бөгөөд 2022 оны 05 дугаар сараас хойш тус өрөөнд хүүхдээс мэдүүлэг авч байна. Аймгийн Цагдаагийн газраас хүүхэд холбогдсон болон хохирсон гэмт хэргийн мэдээ, танилцуулгыг сар бүрээр гаргаж, аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, холбогдох байгууллагуудад хүргүүлж, шалтгаан нөхцлийг судалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй аян, арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Мөн аймгийн хүүхдийн эрхийн хууль эрх зүйн хороонд хүүхэд холбогдсон болон хүүхэд хохирсон хэргийн судалгаа, танилцуулгыг танилцуулж, 3 удаа хурал зохион байгуулагдсан байна. Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байцаагч ажиллуулж байна.		
108	1.1.12/. “Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын бодлого, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж байгууллагуудад хүргүүлэх.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эмэгтэй төлөөлөгчдийн зөвлөгөөнөөр аймгийн “Хүүхэд хамгааллын бодлого”-ын хэрэгжилт үр дүнг танилцуулан, цаашид анхаарах асуудал, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хэлэлцсэн нь хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг чанаржуулах ач холбогдолтой арга хэмжээ болж, үүний мөрөөр 2023-2024 оны үйл ажиллагааны 4 зорилт, 28 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Энэ хүрээнд аймгийн “Хүүхдийн төлөө салбар зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг 2024 оны аймгийн Засаг даргын А/507 дугаар захирамжаар шинэчлэн байгуулж, 19 сумын Засаг даргаар ахлуулсан сумын “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийг арга зүйгээр ханган ажиллаж байна. Мөн хүүхэд гамшиг ослын эрсдэл, хүчирхийлэл, дарамтад өртөх, хүүхэд алга болох, онц ноцтой гэмт хэргийн золиос болох зэрэг тухайлсан кейсийн асуудалд шуурхай зөвлөн тусалж, мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой “Хүүхэд хамгааллын мэргэжлийн зөвлөх баг” нь аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулан 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр “Хүүхдийн төлөө салбар зөвлөл”-ийн дэргэд үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд 19 сумын 176 байгууллага аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл ажиллаж урд оноос 3.5 хувиар өссөн, 108 байгууллага “Хүүхэд, хамгааллын бодлого”-оо батлан хэрэгжүүлж урд оноос 25.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		
109	1.2.1/. хүүхэд хөгжлийн чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, Хүүхдийн номын сан, Хүүхэлдэйн театр, Хүүхдийн урлан	Аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөл, Өсвөрийн парламент, Өсвөрийн санхүүч зэрэг хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагатай хамтран “Галт тэрэг”, “Гурван үгт хаяг”, “Парлементийн боловсрол” зэрэг 5	Хэрэгжих шатанд 70.0 хувь		

		бүтээх төвийн барилга байгууламжийг шинэчлэх зардлыг улсын төсөвт шат дараатай тусгаж, шийдвэрлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг бүсчилсэн хэлбэрээр ажиллуулах, хүүхдийн хөгжил төлөвшилд хүрч үйлчлэх нөхцөл бүрдүүлэх;	удаагийн нөлөөллийн арга хэмжээнд давхардсан тоогоор 1200 гаруй хүүхэд, “Арвайхээр лиг” сурагчдын сагсан бөмбөгийн тэмцээн, “Миний урлан” бүтээлийн аймгийн тавдугаар наадам, “Дэвжээ” тэмцээн, Хүрэл тулга, Усанд сэлэлтийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, “Шатарчин гэр бүл”, “Хэрэглэгчийн төлөө шударга, хариуцлагатай хиймэл оюун ухаан” сэдвийн хүрээнд танин мэдэхүй АХА тэмцээн, Монгол экологи төвтэй хамтран “Youth power Өвөрхангай-2024” байгальд ээлтэй залуусын чуулга уулзалт, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан “Зүрх бүхэнд хайр бий” драмын жүжиг, “Хүүхдийн ордон-Хүслийн жигүүр” хүүхдийн ордны дэргэдэх дугуйлан, сургалтын төвийн тайлант өдөрлөг зэрэг 21 удаагийн үйл ажиллагаанд 12898 хүүхэд хамрагдсан байна. Хүүхдийн ордны дэргэдэх 14 дугуйланд давхардсан тоогоор 425 хүүхэд хөгжлийн үйлчилгээнд хамрагдаж, Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын газрын харъяа 17 сумын 25 дугуйлан, сургалтад 491 хүүхэд, Биеийн тамир спортын улсын хорооны харъяа 18 нэр төрлийн дугуйланд 435 хүүхэд хөгжлийн үйлчилгээнд хамрагдаж, нийт 39 дугуйланд 1351 хүүхэд хамрагдаж байна.		
110	1.2.2/. цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар самуун явдлыг сурталчлах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн үйлдлүүдийг таслан зогсоох, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн яаралтай авах;	“Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан нүүдэлчин ахуй, өв соёл, хөдөөгийн залуучуудын амьдрал, гэр бүлийн халуун, дулаан, эерэг уур амьсгалыг цахим орчноор дамжуулан сурталчилах зорилгоор хөдөөгийн залуу хосыг оролцуулсан “Хөдөөгийн болзоо-1, 2” цуврал контентыг бүтээж, цахим орчинд байршуулснаар 25.0 мянган хандалт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр 2 контент, 5 видео, 28 постер, 25 мэдээллийг бэлтгэн, цахим орчинд байршуулснаар 35.0 мянга, гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжлийн “Зүрх бүхэнд хайр	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

			бий” драмын жүжгийн 3 подкаст, 1 мэдээг орон нутгийн цахим хуудсаар нийтэд түгээснээр 10.6 мянган хүний хандалт тус тус авсан байна. “Залуучуудын хөгжлийн төв”-тэй хамтран “Супер анги” уралдааныг аймгийн хэмжээнд ахлах ангиудын дунд “Цахим орчинд эерэг хандлага түгээе” уриатайгаар зохион байгуулж оролцогчдоос шалгарсан 5 бичлэг цацагдсанаар 20.0 мянган хандалт авч цахим орчинд хүүхдүүд өөрсдөө нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, залилах, хүчирхийлэлд уриалах, садар самуун явдлыг сурталчлах зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хүүхэд хүүхдэдээ эерэгээр нөлөөлсөн, үр дүнтэй ажил болсон.		
	111	1.2.4/. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016-2022 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх, жил бүр хөндлөнгийн хяналт оруулах;	Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын газарт хөндлөнгийн байгууллагаар жил бүр санхүүгийн тайланд аудит хийлгэсэн. 2019-2022 онд аудитын шалгалтаар баримтын бүрдэл дутуу, шууд худалдан авалт хийсэн зэрэг зөрчил илэрч, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснээр зөрчлийг арилгаж ажилласан байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	112	1.2.6/. Хүүхдийн эрхийн байцаагчийн чиг үүргийг боловсронгуй болгох, нийгэмд таниулах ажлыг эхлүүлэх.	Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь хүүхдийн эрхтэй холбоотой зөрчил дутагдлыг илрүүлэх, таслан зогсоох, арилгах замаар хүүхдийн эрхийг зөрчлийг шалган шийдвэрлэж, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
37	113	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-25 Дугаар 2023№05 ТБХ бв/. төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төсөв боловсруулах үе шатанд олон нийтийн оролцоог хангах аргуудыг туршилтын журмаар нэвтрүүлэх, Төсвийн ил тод	Төсвийн төлөвлөлт, хэрэгжүүлж байгаа томоохон төсөл арга хэмжээ ач холбогдолыг ухуулан таниулах, чанартай, хугацаанд нь хийж гүйцэтгэхэд хяналт тавих, төлөвлөх үйл ажиллагаанд иргэдийг идэвхтэй оролцуулах зорилгоор “Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд иргэдийн цахим оролцоо” өдөрлөгт 13 багийн БИНХ-аар 985	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		байдлын олон улсын санаачилга /C1oBa1 1nШайуе Тог E vca1 Tгалзрагелсу/ байгууллагаас гаргасан төсвийн бодлого боловсруулахад олон нийтийн оролцоог хангах зарчмуудыг нэвтрүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны олон сувгаар дамжуулан төсвийн төслийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний санал бодлоо илэрхийлэх боломжийг олгох;	иргэнд, 13 багийн хэсгийн ахлагч 183 иргэн, Арвайхээр сумын ЗДТГ-ын албан хаагч, Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ, харъяа төсөвт байгууллага цэцэрлэг, сургуулийн захирал, эрхлэгч, арга зүйч, Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ, БОЭТ-ийн нийт албан хаагчдад оролцлоо. Үндэсний хэмжээнд явагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтад иргэд саналаа өгөх энэхүү үйл ажиллагаанд Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын иргэд идэвхтэй оролцож нийт 88 төслийн санал, 906 хүн саналаа өгч улсын хэмжээнд 4-р байрт орсон үзүүлэлтэйгээр санал өгөх үйл явцыг өндөрлүүлээ.		
114	бг/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах.	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ач холбогдолыг ухуулан таниулах, чанартай, хугацаанд нь хийж гүйцэтгэхэд хяналт тавих, төлөвлөх үйл ажиллагаанд иргэдийг идэвхтэй оролцуулах зорилгоор “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд иргэдийн цахим оролцоо” өдөрлөгт 13 багийн БИНХ-аар 985 иргэнд, 13 багийн хэсгийн ахлагч 183 иргэн, албан хаагчдад оролцон нийт 88 төсөлд 906 хүн саналаа өглөө. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх 10 төсөл арга хэмжээнд 2024 оны 11 сарын 10-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл цахимаар санал авч, нийт 512 хүн санал өгч, 9 төсөл арга хэмжээ дэмжигдэж, 1 төсөл арга хэмжээг дэмжигдээгүй байна. Мөн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд олон нийтийг төлөөлөх хяналтын зөвлөлийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжаар байгуулж, журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 19/04 дүгээр тогтоолоор баталсан. Дээрх журмын дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар удаашралтай баригдаж байгаа 12 барилга угсралтын	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

			ажилд хяналт шалгалт хийснээс Хархорин сумын цэцэрлэг, Хужирт сумын соёлын төв, Тарагт сумын Засаг даргын Тамгын газар тус тус ашиглалтад орж, Хужирт сумын Эрүүл мэндийн төв, Баруунбаян-Улаан сумын Соёлын төвийн барилга угсралтын ажил гүйцэтгэж буй компанид албан мэдэгдэл хүргүүлээд байна.		
38	115	Засгийн газарт чиглэл өгөх тухай (ЁЗСХБХ) 2023-11-01 Дугаар 2023_10 1.4. Иргэн төрийн албанд анх ороход тавих ёс зүйн шаардлагыг өндөрсгөх, ёс зүйн зөрчил гаргаж байсан хүнийг төрийн жинхэнэ албанд томилохгүй, албан тушаал дэвшүүлэхгүй байх зарчмыг хатуу мөрдөх;	Төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцэн төрийн жинхэнэ албан тушаалд анх томилогдсон иргэнд 6-12 сар хүртэл туршилтын хугацаа хэрэглэж, туршилтын хугацаанд гүйцэтгэсэн ажлын үр дүн, ёс зүйн байдлыг үнэлж дүгнэн болзолыг хангасан тохиолдолд тухайн албан тушаалд жинхлэн ажиллуулж байна. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд шатлан дэвшиж ажиллах, Төрийн албаны тухай хуулийн 26.3 дахь заалтын дагуу шатлан дэвшиж ажиллахаар тусгай шалгалтад бүртгүүлсэн төрийн жинхэнэ албан хаагчдаас сүүлийн 12 сарын хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан эсэх тухай тодорхойлолтыг томилох эрх бүхий албан тушаалтнаас гаргуулан авч, ёс зүйн зөрчил гаргаагүй тохиолдолд тусгай шалгалтад оруулж байна. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд шилжин ажиллах, төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх, зэрэг дэв шинээр болон ахиулан олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулах, үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх, шагнаж урамшуулахад төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан эсэх тодорхойлолтыг томилох эрх бүхий этгээдээс гаргуулан авч, хяналт тавьж ажиллаж байна. Аймгийн хэмжээнд ёс зүйн зөрчил гаргасан төрийн жинхэнэ албан хаагчийг шатлан дэвшүүлсэн, өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулсан зөрчил гараагүй байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Дотоод хяналтад авч хяналтаас хасуулах саналтай.)	

39	116	Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар 2024_06 ЕЗДБХ 1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах;	Дотоод хяналтад авч ажиллав.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	
	117	1.3. Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах.	Дотоод хяналтад авч ажиллав.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	
Хэсгийн дундаж: 93.2					
Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг					
40	118	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл	Аймгийн хэмжээнд 82 байгууллага гадна хаягаа монгол бичгээр бичиж байршуулсан, 57 байгууллага үндэсний бичгээр хэвлэгдсэн ном, хэвлэл тогтмол захиалж, 25 байгууллага монгол бичгийн булан байгуулж, 2 байгууллага албан хаагчдын нэрийн хуудсыг стандартын дагуу хэвлэн хэрэглээ болгосон бол төрийн бүх байгууллагууд албаны хэвлэмэл хуудсыг үндэсний бичгээр захиалан авч, 45 байгууллага сард 2-оос доошгүй албан бичгийг үндэсний бичгээр гаргасан байна. "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг угтан, "Миний монгол бичиг" аян, "Хурдан зөв унших", "Хичээнгүй бичигтэн", "Алдаагүй зөв бичигтэн", "Цахим монгол	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	бичиг", "Шилдэг бүтээлийн уралдаан", "Уран дүрст бичлэгийн уралдаан" зэрэг арга хэмжээг зохион байгуулж, 167 иргэд хамрагдсанаас төрөл тус бүрд шалгарсан 21 иргэнд 930.0 мянган төгрөг, "Амар байна уу?" сэдэвт уралдаанд үндэсний бичгээр бичсэн 92 захидал ирүүлснийг насанд хүрэгчид, ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги гэсэн 2 ангиллаар шилдгүүдийг тодруулж, орон нутгийн төсвөөс 800.0 мянган төгрөг, монгол бичгийн бийрийн бичвэрийн 5 өдрийн сургалтад хамрагдсан 21 байгууллагын 30 багш, 3 сурагчийн сургалтын төлбөрт 5.4 сая төгрөг, төрийн албан хаагчид, иргэд олон нийтийн үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан "Хүмүн бичигтэн" 2 сарын аяны шилдэг байгууллага шалгаруулах уралдаанд шалгарсан байгууллага, хувь хүнд 2.7 сая төгрөг, Архивчдын өдрийг тохиолдуулан архив, албах хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудын дунд зохион байгуулсан ур чадварын уралдаанд үндэсний бичгээр цахимд бичих чадвараар шалгарсан ажилтнуудын урамшуулалд 500.0 мянга буюу нийт 2024 онд үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжихэд 7.6 сая төгрөг зарцуулсан байна.		
41	119	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104 1.16. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний "Жагсаалт батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/370 дугаар тушаалын хүрээнд 22 цэцэрлэг, 15 сургуульд мэдээлэл өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. Мөн хүнсний эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй бүтээгдэхүүний хугацаа, шошго, хадгалалт болон тээвэрлэлтэд онцгой анхаарч хориглосон хүнсний бүтээгдэхүүн борлуулахгүй байх талаар хоолны газар, түргэн үйлчилгээний цэг, дэлгүүрт боршур, гарын авлагыг хүргэж, сургуулийн сурагчид, анги	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			удирдсан багш нарт зохисгүй хоол хүнс, түүний хор уршиг, хүүхдийн хоол хүнсэнд хориглосон хүнсний бүтээгдэхүүний талаар сургалт хийж, болзошгүй эрсдлээс сэргийлэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Энэ онд хүнс тэжээлийн хадгалалт хамгаалалт, хориглох хүнсний бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлийн технологи зэрэг арга зүйн сургалтуудыг танхим болон цахим хэлбэрээр сургууль, цэцэрлэгийн тогооч, бэлтгэгч, нярав нийт давхардсан тоогоор 250 хүнд зохион байгуулж, мэдлэг ойлголтыг нэмэгдүүллээ.		
42	120	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах	Тус аймагт энэ оны бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдийг энэ оны 05, 10 дугаар сард 2 удаа зохион байгуулсан. Тарьц суулгац борлуулах үзэсгэлэн худалдааг Арвайхээр суманд зохион байгуулж мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж 5, Сэлэнгэ аймгаас 1 аж ахуйн нэгж оролцож нийт 20 гаруй нэр төрлийн тарьц суулгац борлуулсанаас гадна тухайн сумандаа мод үржүүлэг эрхэлдэг аж ахуйн нэгжүүд сум сумандаа тарьц суулгац борлуулах ажил явагдсан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд энэ оны 10 сарын 25-ны өдрийн байдлаар Өвөрхангай аймагт бүх нийтээр мод тарих өдрүүдээр нийт 445.120 ширхэг мод, бут тарьсан бөгөөд доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулалт, байгалийн сэргээн ургалтад туслах ажлаар 273.100 ш, төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, айл өрх, албан байгууллагууд 112.352 ш, цөлжилт газрын доройтлыг бууруулах чиглэлээр 56.680 ш, агро ойн аж ахуй, жимсний мод тарих чиглэлээр 21.750 ш мод тарьсан байна. Аймгийн хэмжээнд төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ 2020 оны суурь түвшингээс 85 га-р нэмэгдэж нийт 216.8 га болж нэмэгдсэн бөгөөд Арвайхээр сумын ногоон байгууламж 45 га талбайгаар нэмэгдлээ. Төв суурин газрын ногоон	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг улс, орон нутгийн төсөв, айл өрх, албан байгууллага, хувийн хэвшлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бөгөөд сумдын орон нутгийн хөгжлийн сангаас 1.2 тэрбум төгрөг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон орон нутгийн төсвөөс 1.7 тэрбум төгрөг, хувийн хөрөнгөөр 180.0 сая төгрөг нийт 3.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.		
121	1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох	Энэ жилийн мод тарих өдрүүдээр Арвайхээр суманд мод тарих төвлөрсөн байршил болох “Баян намсрай”, “Залуус” цэцэрлэгт хүрээлэнд 76 байгууллага, аж ахуйн нэгжүүдийн 2500 гаруй ажиллагсад 4000 орчим мод тарилаа. Сүүлийн жилүүдэд манай аймгийн сум бүр 1.5-5 га хэмжээтэй ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж жил бүр иргэдээр мод тариулж байх, мод тарих соёлыг бүх нийтийн үйлс болгож түгээн дэлгэрүүлэх ажлыг хамтарч зохион байгуулж хэвшээд байна. “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд мод тарих арга хэмжээний зардлыг улс, орон нутгийн төсөв, айл өрх, албан байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгөөр санхүүжүүлж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		
122	1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах	Тус аймагт гадаргын усыг говийн бүс нутаг руу шилжүүлэх “Орхон-Онги” төслийн ТЭЗҮ батлагдаж гадаргын ус хуримтлуулах хөв цөөрмийг Нарийнтээл сумын нутагт шинээр байгууллаа. Тарьсан модны усалгаанд гадаргын усыг түлхүү ашиглах бодлого чиглэл баримтлахыг чухалчилж Орхон, Онги, Таац, Арвайхээр сумын Дайрга, Дэлгэрэх гол дагуу мод тарьсан, үржүүлгийн газар байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэд усалгаанд гадаргын ус хуримтлуулж ашиглаж байна. Шинээр байгуулсан ойн зурвас, мод үржүүлгийн газар, ногоон байгууламжид усны хэмнэлттэй технологи дуслын услагаа, намираа услалтын систем ашиглаж шинэ техник, технологи нэвтрүүлэн ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

	123	1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх	ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгээс ирүүлсэн Өвөрхангай аймагт ургах боломжтой мод сөөгийн жагсаалт, сум байгалийн бүс, бүслүүр, ургах орчноор нь тодорхойлсон зөвлөмжийг аймаг, сумын мод тарих төлөвлөгөөнд тусгасан. Тус аймагт мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг хангай, тал хээр, говийн бүсчлэлээр төрөлжүүлж тухайн бүс нутгийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, агро техникийн зөвлөмж, орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж ажиллах аргачлал зөвлөмжөөр хангаж ажиллаж байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
	124	2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 оны бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрийг Өвөрхангай аймагт энэ оны 05, 10 дугаар сард 2 удаа зохион байгууллаа. Энэ жилийн бүх нийтээр мод тарих өдрийг төв суурин газрын айл өрхүүдийг оршин суугаа хашаандаа мод тариулах, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Өрх бүр хашаандаа мод тарьцгаая” уриалга өрнүүлэн зохион байгууллаа. Энэ оны 10 сарын 25-ны өдрийн байдлаар тус аймагт 445120 ш мод бут тарьсан байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
43	125	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43 1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;	Аймгийн хэмжээнд “Эрүүл чийрэг Өвөрхангайчууд-2024” уриалга гарган иргэдийг идэвхтэй амьдралын хэв маягт уриалсан олон талт арга хэмжээг сар бүр төлөвлөн зохион байгуулж ажиллалаа. Энэ хүрээнд “Өвөл цагийн арга хэмжээ”, “Биеийн тамир, спортын бүтээлч сар аян-2024”, “Эрүүл Монгол хүн”, “Бүх нийтийн гүйлт-2024”, Олон Улсын Олимпийн өдөр, Тамирчдын баярын өдөр зэрэг томоохон арга хэмжээг спорт заал, усан бассейн, фитнес клубүүдтэй хамтран зохион байгуулж иргэдэд зориулсан үнэ төлбөргүй сургалтуудыг зохион байгууллаа. Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд өглөөний дасгал, алхалт, гүйлт, фитнес,	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			спиннинг, нийтийн бүжиг, хийн дасгал, шугаман бүжиг, зумба, иог, агаарын иог, софт волейбол, граунд гольф, дартс, ширээний теннис, уран нугаралт, хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастик зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдээр давхардсан тоогоор 8250 иргэн тогтмол хичээллэж байна. Биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг эрчимжүүлж, тогтмолжуулах ажлын хүрээнд уралдаан тэмцээн, арга хэмжээг хамтран зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч ажилласнаар тайлант онд ажилтан, албан хаагчдын дунд болон байгууллагуудтай хамтран нийт 15 удаагийн арга хэмжээ зохион байгуулж 3108 хүн хамруулсан байна. Аймгийн хэмжээнд 30 спортын холбоо, клуб, дэвжээ үйл ажиллагаа явуулж байгаагаас тайлант онд 24 спорт холбоотой гэрээ байгуулж, тив, дэлхий, улс, бүсийн чанартай 91 удаагийн уралдаан тэмцээнд 1353 тамирчныг оролцуулж, 482 медаль хүртсэн. Спортын холбоодтой хамтран аймгийн аварга, улс, бүсийн чанартай 49 удаагийн уралдаан тэмцээн зохион байгуулж, 10.339 тамирчныг хамруулж, 69.8 сая төгрөгийн төсвийн дэмжлэг үзүүлсэн.		
44	126	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159 3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 159 дүгээр зарлигийн хэрэгжилтийг хангаж, Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэх ажлын хүрээнд төрийн бүх байгууллагууд, төрийн бус, иргэний нийгмийн 70 гаруй байгууллага, 1000 гаруй айл өрх Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хоймортоо эрхэмлэн залж, үр хүүхэд, хойч үедээ таниулан сурталчилж байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
	127	4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт	Аймгийн Хөгжимт драмын театр, Аймгийн Төв номын сан, Аймгийн музей, Эрдэнэзуу музей, 18 сумын соёлын төв зэрэг соёл, урлагийн салбарын 22 байгууллага Эзэн Богд Чингис хааны эш хөргийг албан өрөөндөө хүндэтгэн залсан. Чингис хааны суу	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.	алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээх чиглэлээр нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 3000 гаруй иргэдийг хамруулсан.		
45	128	Хархорум хотыг сэргээн байгуулах тухай 2022-12-20 Дугаар 2022_230 1.1. Орхоны хөндийн түүхэн дурсгалт газарт төр захиргаа, соёл боловсрол, аялал жуулчлалд түшиглэсэн байгаль орчинд ээлтэй, орчин үеийн шийдлийг тусгасан Хархорум хотыг байгуулах асуудлыг судалж, хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох судалгааг хийж, төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн барих; (Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амын төвлөрлийг сааруулах, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах болон төрт есныхоо үнэт өвийг бэхжүүлэх, түүх соёлоо сэргээх үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэяэ)- т чиглэл болгосугай:)	Орон нутагт хамааралгүй	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. (Орон нутагт хамааралгүй заалт тул хяналтаас хасуулах саналтай.)	
Хэсгийн дундаж: 88.0					
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж					
46	129	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09	Энэ онд ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгуудыг буулгаж тухайн суурин дээр нь дараах барилгуудыг шинээр барихаар төлөвлөсөн. Тухайн барилгын ажлын зураг төсөвт хуучин барилгыг буулгах зураг төсвийг боловсруулан	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх,	хүлээн авч ажилласан. Үүнд: Аймгийн төвийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн хуучин агуулахын барилгыг буулгаж шинээр лаборатори, конторын барилга, Хүүхдийн төлөө төвийн хуучин барилгыг буулгаж шинээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга. Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн хуучин өргөтгөлийн барилгыг буулгаж шинээр 320 хүүхдийн өргөтгөлийн сургуулийн барилга, Гучин-Ус сумын хуучин бага сургуулийг буулгаж шинээр 250 суудалтай спорт заалны барилга, Өлзийт сумын хуучин эмнэлгийг буулгаж шинээр 15 ортой эмнэлгийн өргөтгөлийн барилга, Хархорин сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн хуучин агуулахыг буулгаж шинээр 320 хүүхдийн сургуулийн барилгуудын угсралтын ажил явагдаж байна. Мөн Хархорин сумын 5 дугаар цэцэрлэг нь 2013 онд ашиглалтад орсон бөгөөд “Газар хөдлөлтийн бүс нутагт төлөвлөх норм ба дүрэм” /БНБД22-01-01*/2006-ын 2 дугаар хавсралтын дагуу 9 баллын газар хөдлөлттэй бүс нутагт баригдсан бөгөөд бетон суурьтай, тэнхлэгээрээ 22.4x12.2 м хэмжээтэй 2 давхар барилга юм. Тухайн барилга нь Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 49.0 хувь буюу дунд эрсдэлтэй гэсэн үнэлгээтэй гарсан. Иймд тухайн цэцэрлэгийн үйл ажиллагааг тус сумын Орхон сургуулийн В байр буюу цогцолбор сургуулийн байранд хэвийн үйл ажиллагааг хангасан. Тухайн цэцэрлэгийн засвар үйлчилгээ болон дахин төлөвлөлтийн асуудлыг шийдвэрлээгүй байна.		
130	3. Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тогтмол	Газар хөдлөлтийн гамшгийг иргэд олон нийтэд таниулах ажлын хүрээнд “Газар хөдлөлтийн тухай ойлголт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдвээр Гамшгаас хамгаалах, алба, мэргэжлийн анги, Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, иргэд олон нийтэд		Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооцдог байх,	танхимын сургалтуудыг зохион байгуулан ажиллалаа. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний заавар, зөвлөмж нийт давхардаагүй тоогоор 45 пост албаны фэйсбүүк, пэйж хуудсаар дамжуулан 19 сумдын фэйсбүүк, пэйж хуудас, зарын узель, Арвайхээр, Уянга сумдын мэдээллийн электрон самбар зэрэгт байршуулан давхардсан тоогоор 157934 иргэний хандалт авч сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, багц мессежийг аймгийн хэмжээнд 8500 иргэнд хүргэж ажиллав. Мөн орон нутгийн Соёмбо, Хас телевиз, Ноён-Уул -87,9 фм богино долгионы радио, UNN болон Uv-live цахим сайтуудаар хэвлэлийн бага хурал 1 удаа, шууд ярилцлага 1 удаа, 4 төрлийн шторк өдөрт 20 удаагийн давтамжтайгаар 2800 удаа иргэд олон нийтэд хүргэж ажилласан.		
47	131	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05 1.9. Хяналтгүйгээр худалдаалж байгаа ахуйн хэрэглээний хийг тусгай зөвшөөрөл бүхий хүнсний дэлгүүр, аж ахуйн нэгжээр дамжуулан худалдаалах болон ахуйн хэрэглээний хийг насанд хүрээгүй хүүхдэд худалдаалахыг хориглох шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх.	Аймгийн Онцгой байдлын газраас аймагт үйл ажиллагаа явуулж байгаа шатахуун түгээх станц, авто хийгээр цэнэглэх станц, хий цэнэглэх станцын барилга, байгууламжид төлөвлөгөөт бус хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллав. Хяналт шалгалтын хүрээнд гамшгаас хамгаалах тухай хууль, галын аюулгүй байдлын тухай хууль, төрийн хяналт шалгалтын тухай хууль, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм нормативын, баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг Барилга хот байгуулалтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Ашигт малтмал газрын тосны орон нутаг дахь төлөөлөгчийн газруудтай хамтарсан ажлын хэсгийг байгуулж, ажиллав. Хяналтаар 5 зөрчлийг илрүүлэн газар дээр нь арилгав. Аймгийн хэмжээний хүнсний дэлгүүрүүдэд насанд хүрээгүй хүүхдэд ахуйн газ худалдахгүй байх талаар заавар, зөвлөмжийг хүргүүлж ажиллаа. Газ, цавуу, будаг шингэлэгч,	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

			бензин, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис зэргийг хэрэглэдэг 12 хүүхэд аймгийн Цагдаагийн газрын хяналтад байдаг бөгөөд 5 хүүхдийг аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сэтгэц наркологиын тасагт хэвтүүлж, эмчилгээ хийлгэсэн байна. Мөн орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр “UV Live” “ӨВ-Зар” “Өвөрхангай аймгийн нэгдсэн бүлгэм” зэрэг группын админуудтай хамтран ажиллаж урьдчилан сэргийлэх чиглэлээр 14 төрлийн зурагт постерыг олон нийтийн сүлжээнд байршуулан түгээж давхардсан тоогоор 13.000 орчим иргэнд хүргэсэн байна.		
48	132	Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40 2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх	Бат-Өлзий суманд улсын төсвийн 6.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5090м цэвэр усны шугам сүлжээ, цэвэр усны гүний худгийн 2 барилга, усан сан, хоногт 100 м.куб бохир зайлуулах чадалтай цэвэрлэх байгууламж, 3557м ариутгах татуургын шугам, 2445м гадна дулаан хангамжийн шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэсэн. Уянга суманд улсын төсвийн 6.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хүн амын усан хангамжийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэж 2 худаг гаргаж 2000 метр цэвэр усны шугам, 2680 м бохир усны шугамын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хужирт суманд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 3.2 тэрбум төгрөгөөр сумын нэгдсэн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн. Үүнд 50м гүнтэй цэвэр усны гүний худаг гаргаж, 3120 м урттай бохир усны шугам тавих, захиргаа, уурын зуухны барилга байгууламжийн ажил хийгдэж ашиглалтад орсон. Аймгийн хэмжээнд нийт 8 сум цэвэр бохирын шугам сүлжээнд холбогдсон бөгөөд нийт 3272 айл өрх, 413 ААН-ын ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулаад байна. Арвайхээр сум ОНХС-ын 700 гаруй сая төгрөгийн хөрөнгө	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			оруулалтаар айл өрхүүдийн 00-г шинэчлэх, хөрсний бохирдлыг бууруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх ажлын хүрээнд 300 гаруй айл өрхийн нүхэн жорлонг шинэчилж эко 00 болгон шинэчилсэн.		
133	2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвшүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих	Усны зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор энэ оны жилийн эцсийн байдлаар шинээр 17 аж ахуйн нэгжийг тоолууржуулж, 28 айл өрхийг тоолууржуулсан. Мөн 12 аж ахуйн нэгж байгууллагын ус ашиглуулах дүгнэлтийг гаргаж, усны хэмнэлттэй хэрэглээг төлөвшүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, газрын доорх усны шугам хоолой бүрийг тоолууржуулах, шугам сүлжээний алдагдлаас сэргийлэх талаар заавар, зөвлөмж хүргүүлж байна. Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулдаг “Ноос-Ирээдүй” ХХК үйлдвэрлэлд ашигласан усаа механик, хими, биологийн цэвэрлэгээтэй /500-700 м3/хоног/ урьдчилсан цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдэн гарсан бохир усаа “Онги-Ус суваг” ОНӨААТҮГ-ын бохир усны төвийн шугаманд нийлүүлж байна. Цэвэрлэх байгууламжийн технологи: Механик, анхдагч тунгаагуур, тогтворжулагч 3 сан /125 м3 *3 ш/, өөх тос хамагч, айро тек, 3 танк /2 агаартай, 1 вакум, агаарын конденсатор, нүүрсэн шүүлтүүр, умбуур баригч, халдваргүйжүүлэгч усан сан/ БОАЖЯ, БНСУ-ын "Хүрээлэн буй орчны аж үйлдвэр технологийн институт", "Та та" ХХК хамтран хэрэгжүүлж буй Өвөрхангай аймгийн Уянга сум дахь “АУМ-АЛТ” ХХК-д уурхайн хаягдал усыг цэвэрлэх байгууламжийг суурилуулж ашиглалтад оруулсан. Тус бага оврын цэвэрлэх байгууламж нь уул уурхайн үйл ажиллагаанаас гарах бохир усыг электролизын аргаар цэвэрлэх өндөр технологийн горимтой, өдөрт 10 тонн усыг цэвэрлэж байгальд нийлүүлэх хүчин чадалтай төхөөрөмж юм.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

49	134	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03 3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах.	Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсрол олгох сургалт нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулж, эко клубүүдийн үйл ажиллагааг дэмжин ажиллалаа. Арвайхээр сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуультай хамтран 2024 оны 03 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд "Өвөрхангай аймгийн ан амьтад, нэн ховор, ховор амьтдын тухай" танин мэдэхүйн сургалт хийж, гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулсан. Тус үйл ажиллагаанд ерөнхий боловсролын 5 дугаар сургууль, Мэргэд, Тэмүүлэл эрдэм сургуулийн дунд ахлах ангийн 500 орчим сурагчид хамрагдлаа. Дэлхийн байгаль хамгаалах өдрийн хүрээнд "Хушин ойгоо хамгаалъя" зорилтот үйл ажиллагааг Бат-Өлзий суман дахь Сум дундын Ойн анги, Зүүнбаян-Улаан, Уянга сумдын Байгаль орны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид, Ар өлт, Булган хангай нөхөрлөлтэй хамтран зохион байгууллаа. Байгальд ээлтэй хандлага, зөв дадал, ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, туршлага солилцох, сурагчдын идэвх санаачилгыг өрнүүлэн өсвөрийн байгаль хамгаалагчдыг бэлтгэх зорилгоор ЕБС-ийн "Эко клуб"-ийн сурагчдын дунд "Youth Power Uvurkhangai" байгальд ээлтэй залуусын чуулганыг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Хужирт суманд зохион байгуулж, 19 сумын 33 сургуулийн 90 гаруй сурагчид хамрагдсан. "Мөнх криетив дата" ХХК-тай гэрээ байгуулж МНТВ, UNN телевизүүдээр дамжуулан цаг үеийн мэдээллийг тухай бүр дамжуулан байгаль орчны хууль тогтоомж, мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
----	-----	--	---	---	--

50	135	Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-02 Дугаар 2022_01 3.4. Тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган га атар газар олгох ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;	Энэ онд улаан буудай 6700 га, бусад үр тариа 428 га, төмс 387 га, хүнсний ногоо 278.1 га, малын тэжээл 5658 га, тосны ургамал 5200 га, нийт 18651.1 га талбайд тариалалт хийсэн. Баян-Өндөр сум 300 га, Бүрд сум 30 га, Өлзийт сум 116 га, Бат-Өлзий сум 8 га, Зүүнбаян-Улаан сум 60 га, Уянга сум 100 га, Хужирт 160 га, Хархорин сум 127.4 га, Нарийнтээл 5 га, Сант 1 га талбайг эргэлтэд оруулахаар газрын асуудлыг шийдвэрлэн, 10 сумын 907.4 га атаршсан талбайг эргэлтэд оруулсан. Энэ нь урд оноос улаан буудай 886 га, малын тэжээл 1421 га, тосны ургамал 2756 га талбайгаар тус тус өссөн дүнтэй байна. Аймгийн хэмжээнд 6000 гаруй га атаршсан газар байгаа тул атар газар эргэлтэд оруулах санал санаачилга гараагүй.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	136	3.8. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчлэн, кластераар хөгжүүлэх, хот суурин, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгч 35 иргэн, аж ахуй нэгжүүдийн дунд уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, төрөөс баримталж буй бодлого чиглэл, "Цагаан алт" хөтөлбөрийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, бусад албаны хүмүүс оролцож мэдээлэл хийсэн. ХХААХҮС-ын А/28 дугаар тушаалаар батлагдсан ЖДҮХС-ийн урт хугацаатай хөнгөлөлттэй зээлэнд хөнгөн үйлдвэрлэлийн зориулалтаар 3 аж ахуйн нэгжийн 351.0 сая төгрөгийн хүсэлт Дэд хорооны хурлаар хэлэлцэгдэж, 2 аж ахуйн нэгж санхүүжилтээ авсан. "Ноос-Ирээдүй" ХХК Төгрөг сумын хонины ноосыг Япон улсад шинжлүүлэн микроныг тогтоолгож, цаашид 18 сумаас хонины ноосы дээж авах малчдаа сонгох ажил эхлээд байна. Мал төхөөрөх, зарим үйлдвэр, цехүүд дайвар бүтээгдэхүүнээ Улаанбаатар хотын Эмээлт зах руу үнэ тохиролцон ачуулж байна. "Итгэлт хүнс трейд" ХХК хонины бөөр, зүрхийг татаж, гүзээг хатааж, гүзээний нунтаг хийж зах зээлд нийлүүлж байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

	137	3.10. Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулах	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/149 дүгээр тушаалын дагуу “ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ” сэдэвт 3 сарын аян зохион байгуулсан. Аяны хүрээнд сум бүрийн хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа 603 иргэн, аж ахуйн нэгжүүдэд хүнсийг зөв сонгон хэрэглэх, аюулгүй орчинд үйлдвэрлэх, иргэдийг соён гэгээрүүлэх 25 удаагийн сургалт, сурталчилгаа болон "Дэлгэрэх хүнс" ХХК, "Итгэлт хүнс" ХХК, "11 маркет" хүнсний дэлгүүрүүдэд үзүүлэх сургууль зохион байгуулсан. Хүнс, худалдаа, үйлчилгээний салбарын чиглэлээр "Хөгжлийн шийдэл" ТББ-н (BEST) хөтөлбөртэй хамтран 15 удаа уулзалт, сургалт, хэлэлцүүлгийг танхимаар зохион байгуулж, 728 иргэн, аж ахуй нэгжийг хамруулсан. "Хүнсний аюулгүй байдал" аяны хүрээнд сумдын хүнсний худалдаа, үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр нийт 603 иргэн, аж ахуй нэгжүүдэд хяналтын албатай хамтран сургалт, мэдээлэл өгсөн. Дээрх аяны хүрээнд хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 10 гаруй аж ахуй нэгжүүдэд заавар, зөвлөгөө өгч ажилласан байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
51	138	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2022-11-25 Дугаар 2022_03 1.3. Үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол Монгол Улсын хөгжлийн бодлогод нийцүүлэн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох ажлыг цахим хэлбэрээр сонгон шалгаруулалтын журмаар /нээлттэй болон хязгаарлагдмал/ зохион	Аймгийн хэмжээнд ашигт малтмалын 64 тусгай зөвшөөрлийг 52 аж ахуйн нэгж эзэмшиж байна. Дээрхи 200632.7 га талбайг эзлэх бөгөөд аймгийн нийт газар нутгийн 3.19 хувийг эзлэж байна. Ашигт малтмал газрын тосны газраас ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбайг ялган санал авахаар ирүүлээгүй болно.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		байгуулах тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээг тухайн сум дүүргийн нутаг дэвсгэрийн 15 хувиас хэтрүүлэхгүй байх;			
Хэсгийн дундаж: 91.0					
Монгол Улсын Засгийн газрын тогтоол					
52	139	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө	Төрийн бүх байгууллагууд албаны хэвлэмэл хуудсыг үндэсний бичгээр захиалан авч, 45 байгууллага сард 2-оос доошгүй албан бичгийг үндэсний бичгээр гаргасан. Аймгийн хэмжээнд нийт 65 ширхэг албан бичгийг үндэсний бичгээр хөтлөн, туршсан байна. Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх сургалтыг 62 байгууллага нийт 1528 албан хаагчийг хамруулан зохион байгуулсан ба монгол бичгээр хэвлэмэл хуудас хөтлөх, цахимд монгол бичгээр бичих сургалтад архив, бичиг хэргийн 170, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн захирал, эрхлэгч 70, нийт 240 ажилтан хамрагдсан. Аймгийн хэмжээнд 82 байгууллага гадна хаяг болон өрөө тасалгааны хаягаа монгол бичгээр бичиж, 2 байгууллага албан хаагчдын нэрийн хуудсыг стандартын дагуу хэвлэн хэрэглээ болгосон байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.			
53	140	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139 3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг “Удирдлагын академи”-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.	Тайлант онд Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан тусгай шаардлага болон ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр зохих шалгуурыг хангасан 1 албан хаагч эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад, 6 албан хаагч ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 21 төрийн жинхэнэ албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 13 албан хаагч, чиглүүлэх богино хугацааны сургалтад 5 албан хаагч тус тус хамрагдав.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
54	141	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай 2022-08-24 Дугаар 2022_314 2. “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027)”-ийг 1 дүгээр хавсралт, “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2022-2030 он)”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр “Хос шаглаа” уран хатгамалчдын үзэсгэлэн, уралдаан, “Айраг эвент” зэрэг арга хэмжээг зохион байгуулан 3.0 сая төгрөг зарцуулж орон нутгийн онцлог бүхий соёл урлагийн чанар хүртээмжид ахиц гарсан. Орон нутгийн онцлогтой Бүх нийтийн соёлын боловсролын аймгийн нэгдсэн төлөвлөгөөг гарган “Хүмүүн бичигтэн”, “Нэг өрх-Нэг угийн бичиг”, “Нэг ном-Эрхэм үйлс” зэрэг арга хэмжээг зохион байгуулж, 4.9 сая төгрөг зарцуулсан. Соёлын бүтээлч сар аяны хүрээнд зохион байгуулагдсан орон нутгийн театруудын бүсчилсэн уралдаанд хангайн бүс буюу Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаадын болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт, салбарын болон аймаг, нийслэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган төрийн бус, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагууд болон иргэдийг татан оролцуулж, батлагдсан төсвийн багцын дүнд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	аймгуудын театрын уран бүтээлчдийн нэгдсэн тоглолтыг тоглож, уралдаанд 7 номинацид байр эзэлж амжилттай оролцсон. Мөн аяны хүрээнд 120 арга хэмжээг зохион байгуулж, 50400 иргэнд соёл, урлагийг сурталчлан таниулсан. Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, сэргээн засварлахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Түүх соёлын дурсгалт газрын хадгалалт хамгаалалт” сэдэвт Монгол-Японы соёлын өвийн симпозиумыг зохион байгуулсан. Аймгийн Хөгжимт драмын театр нь “Арвайн дэг” аймгийн бүжгийн аварга шалгаруулах анхдугаар уралдааныг зохион байгуулж, 1471 хүүхэд, багачуудыг оролцуулан, 18.0 сая төгрөг зарцуулсан. “Шамбалын орон” уран зургийн галларейг түшиглэн “Бидний ертөнц” уран зургийн үзэсгэлэнг гаргаж 50 гаруй иргэнд үзүүлсэн.		
55	142	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн “Ажлын чиглэл батлах тухай” 82 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд төрийн байгууллагын гүйцэтгэх зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор хариуцуулан гүйцэтгүүлж болох ажлын чиглэлийг баталсан. Энэ хүрээнд “Өвөрхангайд үйлдвэрлэв” худалдааны төвийн чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх аймгийн Засаг даргын шийдвэр гарч, үүний дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/10 дугаар тушаалаар сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, сонгон шалгаруулалтыг 2 удаа нээлттэй	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.	зарласнаар МҮХАҮТ-ын аймаг дахь салбар танхим шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу аймгийн Улаан загалмайн хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, хүмүүнлэгийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг орон нутгийн төсөвт тусгаж, жил бүр гэрээ байгуулан санхүүжүүлж байна. Энэ онд хүмүүнлэгийн үйл ажиллагааг орон нутагт тасралтгүй зохион байгуулж, гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллахад зориулж, аймгийн Улаан загалмайн хороонд 22.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Төрийн бодлого шийдвэр, түүний хэрэгжилтийг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэж ажиллах хүрээнд хэвлэл мэдээллийн 13 байгууллагатай гэрээ байгуулж үйл ажиллагааны гүйцэтгэлд улирал бүр дүгнэлт хийж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 60.0 сая төгрөг зарцуулсан.		
56	143	Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-09 Дугаар 2022_402 1.3. Цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Энэ онд орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төсөлд цэцэрлэгийн барилга төлөвлөлгүй баталж, магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан ажил байхгүй.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

144	1.4. орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулахад норм нормативыг мөрдүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг авч, хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Орон сууцны барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулах шаардлага үүсээгүй байна.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	
145	2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн байршилд “түр цэцэрлэг” байгуулан ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион	Шинээр хийгдэж байгаа Хужирт, Нарийнтээл сумдын “Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд цэцэрлэг, сургуулийн барилгыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм дүрм стандартын дагуу тусган ажилласан. Шинээр хийгдэхээр төлөвлөгдсөн барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг төлөвлөлтийн дагуу тусган баталгаажуулж тухай бүр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай зөвшилцөн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд орон сууцны хороолол, цогцолбор барилга баригдаагүй байна. Арвайхээр хотын шинэ суурьшлын бүсэд 20 га талбайд шинээр орон сууцны хорооллын барилгажилтын төсөл хэрэгжүүлэхээр 1600 айлын орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд 200 хүүхдийн цэцэрлэг, 640 хүүхдийн сургуулийн барилгыг төлөвлөж хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан “Хот байгуулалтын кадастр”-ын мэдээллийн цахим санд оруулсан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.			
	146	3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Энэ онд шинээр хийгдэж байгаа Хужирт, Нарийнтээл сумдын “Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” Арвайхээр хотын шинэ суурьшлын бүсийн 20 га талбайд шинээр 1600 айлын орон сууцны хорооллын барилгажилтын төсөл хэрэгжүүлэхээр хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд цэцэрлэг, сургуулийн барилгыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм дүрм стандартын дагуу тусган ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	147	4. Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, шаардагдах зардлыг жил бүрийн улс, нийслэл, орон нутгийн төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудал гараагүй байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
57	148	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419 3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг,	Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд дэвшүүлсэн хот хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах, олон нийтэд сурталчлан таниулах, орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны А/501 дүгээр захирамжаар байгуулсан. Шинэ сэргэлтийн бодлого дахь “Хот, хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд нийслэлээс орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./	үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих зорилгоор “Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 16/02 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.		
149	4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Нээлттэй Өвөрхангай хөтөлбөр нь аймгийн эдийн засаг-нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, иргэдийг орон нутагт ажиллаж, амьдрах таатай орчин бүрдүүлэх замаар аймгийн хүн амыг арваас доошгүй хувиар нэмэгдүүлэх зорилго тавьсан. Энэ зорилгын хүрээнд 4 зорилт 49 арга хэмжээг тусгасан. Аймгийн хэмжээнд тайлант хугацаанд Улаанбаатар хот болон бусад орон нутгаас 0-15 насны 476, 16 наснаас дээш 670, нийт 1146 иргэн шилжин ирсэн байна. Энэ хүрээнд Арвайхээр суманд 119 өрхийн 342 иргэн шилжин ирсэн бөгөөд СӨБ-д 45, ЕБС-д 78 хүүхэд шилжин ирж суралцаж байна. Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Өвөрхангай аймгийн эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө		Хэрэгжих шатанд 70.0 хувь	

			оруулагчдыг татах замаар орон нутагт ажлын байрыг бий болгож, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор GROWING UVURKHANGAI хөрөнгө оруулалтын чуулганыг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Улаанбаатар хотноо Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын их танхимд зохион байгуулсан. Тус чуулганд төр засгийн төлөөллүүд, томоохон бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүд, эрдэмтэн судлаачид болон БНХАУ-ын Гүйжөү муж, ОХУ-ын Красноярск хязгаар, Бүгд Найрамдах Солонгос Улс, Франц улсаас төлөөлөгчид урилгаар оролцсон бөгөөд нийт 250 гаруй гадаад, дотоодын зочид оролцсон.		
58	150	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448 1.12. Гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг	1.12. Орон нутгийн төсөвт төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 40-100 хувиар тооцож олгохоор, мөн төрийн үйлчилгээний ажилтнуудын үндсэн цалинг ажлын чанар, үр дүнд үндэслэн дахин нэмэгдүүлэх нөхцөл эрх зүйн хувьд бүрдсэн. Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн улирлын урамшууллыг тооцон олгож байна. 1.13. Аймгийн ОНХС-ийн төсөл арга хэмжээг эрэмбэлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2021 оны А/221 дүгээр захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй байнгын комисс байгуулсан. Удирдлага мэдээллийн системд мэдээллийг журамд заасан хугацаанд бүрэн зөв байршуулах талаар сумдуудад үүрэг чиглэл өглөө. Мөн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд олон нийтийг төлөөлөх хяналтын зөвлөлийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжаар байгуулж, журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 19/04 дүгээр тогтоолоор баталсан. Дээрх журмын дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар удаашралтай баригдаж байгаа 12 барилга угсралтын ажилд хяналт	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

	дарга нарт; 1.14.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.15.нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох, орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.16.нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.17.гадаад зээлийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Монгол Улсын 2023 оны төсөвт тусгасан дүнгээр бүрэн төлж барагдуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	шалгалт хийснээс Хархорин сумын цэцэрлэг, Хужирт сумын соёлын төв, Тарагт сумын Засаг даргын Тамгын газар тус тус ашиглалтад орж, Хужирт сумын Эрүүл мэндийн төв, Баруунбаян-Улаан сумын Соёлын төвийн барилга угсралтын ажил гүйцэтгэж буй компанид албан мэдэгдэл хүргүүлээд байна. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх 10 төсөл арга хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл цахимаар санал авч, нийт 512 хүн санал өгч, 9 төсөл арга хэмжээ дэмжигдэж, 1 төсөл арга хэмжээг дэмжигдээгүй байна. 1.14. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулсан бөгөөд аж ахуй нэгжүүд нийгмийн хариуцлагын хүрээнд 600.0 сая төгрөгийн хандив, тусламж үзүүлж хамтран ажилласан. 1.15. Тайлант онд 326 иргэнд 33.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг арилжааны 4 банкаар олгосон. Үүнээс 3 хувийн хүүтэй 13.9 тэрбум төгрөгийн зээлийг 140 иргэнд олгосон байна. Эх үүсвэрийн зөвшөөрөл хүссэн 212 иргэний 22.7 тэрбум төгрөгийн зээл олгогдохоор судлагдаж байна. Мөн 9 аж ахуйн нэгж байгууллагад 1.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. 1.17. Монгол Улсын Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газартай эргэн төлөгдөх нөхцөлөөр байгуулсан гэрээний дагуу Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр 2011 онд байгуулсан “Хот байгуулалтын салбарын төсөл	
--	--	--	--

			МОН-2301” хүрээнд Арвайхээр, Хархорин сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийг сайжруулж, орон сууцны 1000 айлын гадна дулаан, цэвэр ус, хэрэглээний шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн 2017 онд байгуулсан “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388 төсөл-нэмэлт санхүүжилт”-ээр Өвөрхангай аймгийн төвд 3000 м3/хоногийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, Хужирт сумын төвд 310м3/хоногийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн гэрээт ажлыг ашиглалтад оруулсан. Зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрт энэ онд 800.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс төлсөн болно.		
59	151	2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49 Х-1.2. Шүгэл үлээх үйл ажиллагааг бүх талаар дэмжих хөдөлгөөн зохион байгуулж, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн дэмжлэг авах;	Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт болон “Шүүр” ажиллагааны хүрээнд аймгийн хэмжээнд Төрийн албаны тухай хууль тогтоомж, Авлигын эсрэг хууль тогтоомжийг зөрчиж хууль бусаар томилогдсон албан тушаалтныг илрүүлэх 5 судалгаа нэгтгэн, аймгийн Засаг даргын 2024 оны 1/124 дүгээр албан бичгээр хүргүүлэв. Албан даалгаварын хүрээнд Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хяналт шалгалтын хүрээнд нийт 143 байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалын 908 албан хаагчийг, Авлигын эсрэг хууль тогтоомжийн хүрээнд 56 байгууллагын 427 албан хаагчийг тус тус хамруулсан. Үүнээс дээрх хууль тогтоомжийг зөрчиж хууль бусаар томилогдон ажиллаж байгаа 22 байгууллагын 27 төрийн албан хаагчийн зөрчлийг илрүүлж, шүүр ажиллагааны хүрээнд 24 зөрчлийг бүрэн арилгуулсан. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд болон сумдын төсөв, санхүүгийн асуудал хариуцсан албан тушаалтнуудын дунд аймгийн Прокурорын газар, Санхүүгийн хяналт, дотоод	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			аудитын албатай хамтран нийт 48 байгууллагын 200 гаруй албан тушаалтанд 2 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав. Авлигын эсрэг иргэд, төрийн бус байгууллагын оролцоог хангах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан” ТББ-ын аймаг дахь салбартай хамтран “Захиргааны ерөнхий хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан саналыг авсан эсэх, мөн зүйлийн 62.2-т заасан хэлэлцүүлгийг хийсэн эсэхэд хяналт, үнэлгээ хийж, үр дүнг тайлагнах зорилгоор аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон аймгийн Засаг даргын эрх хэмжээний хүрээнд гарсан захиргааны хэм хэмжээний актад хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт хийлгүүлж ажиллав.		
	152	Х-1.3. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Агентлаг байгуулах тухай” 499 дүгээр тогтоолоор Төрийн цахим үйлчилгээний хэлтэс байгуулагдаж, орон нутагт төрийн цахим үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байна. Тус хэлтсийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах техник хэрэгсэл, ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд 8.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн. Аймгийн хэмжээнд төрийн цахим үйлчилгээг операторын горимоор үзүүлэх үйлчилгээ жигдэрч, аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төв, Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, 18 сумын Засаг даргын Тамгын газрын оператор ажилтнаар дамжуулан тайлант онд 33597 цахим үйлчилгээг үзүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
60	153	Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_63	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээнд малын тоо толгойг албан татвараас нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэхээр тусгагдсан. Энэхүү ажлын хүрээнд сумдад чиглэл хүргүүлэн ажилласан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	үйлдвэрийн сайдын “Үржлийн малд үзлэг, ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ажлын төсвийн хуваарь батлах тухай” 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/136 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн “Үржлийн малд үзлэг, ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох тухай” А/340 дүгээр захирамжаар Уянга сумын сарлагт үзлэг ангилалтын ажлыг “Шунхан улаан цохио” ХХК хийж гүйцэтгэж, 2000 сарлаг хамрагдаж, 715 сарлагийг ээмэгжүүлэн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулаад байна. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/381 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/847 дугаар захирамжийн дагуу Уянга сумын сарлаг үхэрт явуулсан үржил селекцийн ажилд хянан магадлагаа хийхээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй хамтран ажилласан. Тус сумын 17 малчин өрхийн 170 сарлаг үхэрт үзлэг, ангилалт хийж, 50 үхрээс цусны дээж, 2 малчин өрхийн 10 үнээнээс сүүний дээж авсан. Мөн 2 үхэрт нядалгын гарцыг тодорхойлж, махны химийн найрлага тодорхойлохоор махны дээж авах ажлыг зохион байгуулсан.		
61	154	Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68 7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг	Алсын хараа 2050, “Хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших хөдөлгөөнийг дэмжих төрийн бодлогыг хэрэгжүүлэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нэгдсэн мэдээлэл өгөх зорилго бүхий https://huduu.mn системийг ашиглалтад оруулан, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагууд болон бусад үйлдвэрлэл,	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	үйлчилгээний газруудын нэгтгэсэн нээлттэй мэдээллийг нэг дороос авах боломжийг бүрдүүлж байна. Мөн хотоос хөдөө рүү шилжин суурьшигчдыг дэмжих бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээлэл, аймгийн эдийн, засаг нийгмийн үзүүлэлт, аймаг, орон нутгийн танилцуулга, ажлын байрны сул орон тооны сонгон шалгаруулалтын зар мэдээллийг https://huduu.mn/ovorkhangai цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулж байна. Тус сайтад мэдээ, мэдээлэл байршуулах шинэчлэх ажлыг аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс хариуцан ажиллаж байна. Тайлант онд Huduu.mn цахим хуудсанд 190 мэдээ, 38 ажлын байрны зар, 32 арга хэмжээний талаарх мэдээллийг оруулж, Өвөрхангай цэсэд 1754 иргэн зочилсон байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас хэрэгжүүлж буй “Цахим жишиг аймаг” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн иргэдэд зориулсан “Go Uvurkhangai” аппликэйшн нь аймаг орон нутгийн талаар бүхий л мэдээллийг цаг алдалгүй гар утаснаасаа авах боломжийг бүрдүүлж байна. Мөн И-Монгол академи УТҮГ-тай хамтран нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээг дахин загварчлах, шинээр нэвтрүүлэх үйлчилгээний процессын шинжилгээг хийж, тайлант хугацаанд 10 үйлчилгээг цахим үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia системд туршилтаар нэмж, угсрах ажил хийгдэж байна. Ингэснээр нутгийн захиргааны байгууллагаас үзүүлдэг 77 үйлчилгээг e-mongolia системд нэвтрүүлэх юм. Тайлант онд төрийн үйлчилгээний хүсэлт, бүртгэлийн систем https://service.e-mongolia.mn/-д 1118 хүсэлт ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь шийдвэрлэн ажилласан.	
--	--	---	---	--

62	155	Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2023-04-05 Дугаар 2023_119 2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	“Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам”-ын 4 дэх заалтын дагуу нийт 25 иргэнээс 28.737.734 төгрөгийн мөнгөн төлбөрийн орлогыг төвлөрүүлж түүний орон нутагт үлдэх 50 хувь болох 14.250.000 төгрөгийг аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/748 дугаар захирамжаар Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс болон батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, орон нутгийн хамгаалалт, цэргийн бэлтгэл албаны сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, цэргийн штабын албан хэрэгцээний зардалд тус тус зарцуулсан. Цэргийн дүйцүүлэх албаны орлогын 50 хувийг Сангийн яамны Төрийн сангийн 100900000704 тоот дансанд 14.487.734 төгрөгийг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр шилжүүлсэн. Тайлант онд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 95 дугаар тогтоолын дагуу 14.230.000 төгрөгөөр тогтоосон мөнгөн төлбөрийн хэмжээг мөрдөн ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.)	
63	156	Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-04-05 Дугаар 2023_120 2.3. “Хот хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүсчлэл тогтоох схем, арга зүй, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийн төв боомтуудын тусгайлсан орон зайн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол	Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Өвөрхангай аймгийн эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах замаар орон нутагт ажлын байрыг бий болгож, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор GROWING UVURKHANGAI хөрөнгө оруулалтын чуулганыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, төр засгийн төлөөллүүд, томоохон бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүд, эрдэмтэн судлаачид болон БНХАУ-ын Гүйжөү муж, ОХУ-ын Красноярск хязгаар, Бүгд	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн дарга нарт;	Найрамдах Солонгос Улс, Франц улсаас төлөөлөгчид нийт 250 гаруй гадаад, дотоодын зочид оролцсон. Мөн бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт Бүсчилсэн хөгжлийн бодлогыг нэгдүгээр бүлгээр эрэмблэн, бүс нутагт амьдрах таатай нөхцөлийг бий болгож, тээвэр логикийн оновчтой сүлжээг байгуулан, хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор 7 зорилтыг хэрэгжүүлэх 28 заалтыг төлөвлөн, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцэн батлаад байна.		
	157	3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай.	Аймаг, орон нутагт шинжлэх ухаан, инноваци, технологийг хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн онцлогтой мал аж ахуйн биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох, үүлдрээр баталгаажуулах судалгааны ажил, “Шинэ санаа, шилдэг бүтээл” үзэсгэлэнг зохион байгуулан, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, грантыг сонгон шалгаруулах, шилдэг гарааны бизнес эрхлэгч залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ, гарааны бизнес эрхлэх, хөгжүүлэхэд чиглэсэн санхүүгийн дэмжлэг олгохоос өмнөх болон олгосны дараах аж ахуй эрхлэлтийн сургалт, аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааны ажил, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг тодорхойлох “Хөрөнгө оруулагчдын чуулга, уулзалт”, салбар бүрт эрдэм шинжилгээ, судалгааны ажил зэрэг 17 арга хэмжээг тусган хэрэгжүүлж, улсын болон орон нутгийн төсвөөс 115.0 сая төгрөг зарцуулсан байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
64	158	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2023-04-12 Дугаар 2023_131	Тус тогтоолын дагуу 11 байршилд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээг Хужирт-Бат-Өлзий чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлыг гүйцэтгэгч компаниудтай байгуулан ажиллаж байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		2. Батлагдсан солбицол бүхий талбайд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Өвөрхангай аймгийн Засаг дарга А.Ишдоржид даалгасугай.			
	159	3. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах болон зам барилгын ажлын явцад түүх, соёлын дурсгалт эд зүйл илрэх тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад нэн даруй мэдээлэх, зам барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж, орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номин, Өвөрхангай аймгийн Засаг дарга А.Ишдорж нарт тус тус үүрэг болгосугай.	Аймгийн нутаг дэвсгэрт Хужирт-Бат-Өлзий чиглэлийн 49 км хатуу хучилттай авто зам, барилга угсралтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахаар батлагдсан талбайгаас замын барилгын ажлын явцад түүх, соёлын эд зүйлс илэрсэн тохиолдол гараагүй байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
65	160	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023-06-21 Дугаар 2023_241 2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Шинэчлэн гарсан энэхүү тогтоолоор төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн сүлжээ болон хэмжээнд өөрчлөлт орсон. 2023, 2024 онуудад Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төсвийн тодотгол хийж цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллыг гарган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит Хуралдаанаар батлуулсан болно.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Дотоод хяналтад авч хяналтаас хасуулах саналтай.)	

66	161	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-07-05 Дугаар 2023_266 3. Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ашиглалттай холбогдон гарах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, засвар үйлчилгээг хариуцаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Энэ онд ерөнхий боловсролын сургуулийн 15, цэцэрлэгийн 17, дотуур байрны 19, нийт 51 ариун цэврийн байгууламжийн ажлыг эхлүүлэхээс Зүүнбаян-Улаан сумын 3, Хархорин сумын 4, Сант сумын 3, Баянгол сумын 2, Баруунбаян-Улаан сумын 5, Өлзийт сумын 3, Арвайхээр сумын 1, Нарийнтээл сумын 1, Гучин-Ус сумын 3, Төгрөг сумын 4, Уянга сумын 3, Хужирт сумын 2, Бат-Өлзий сумын 6, Тарагт сумын 3, Хайрхандулаан сумын 1, нийт 44 ариун цэврийн байгууламжийг улсын комисс хүлээн авч ашиглалтад бүрэн ороод байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
67	162	Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278 2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1."Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам)	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 34 төсөл арга хэмжээнээс орон нутагт худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрх нь шилжин ирж худалдан авах ажиллагааг зохион байгуулан 33 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, урьд оноос шилжин хэрэгжиж байгаа 38, нийт 71 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дээрх төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д заасны дагуу гүйцэтгэлийн материалыг хянан баталгаажуулан publicinvestment.gov.mn цахим системээр дамжуулан энэ оны 11 дүгээр сарын байдлаар 65 төсөл арга хэмжээний 43.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж Сангийн яамны publicinvestment.gov.mn цахим системд 483.6 тэрбум төгрөгийн 100 төсөл арга	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

			хэмжээг байршуулан, албан бичгээр холбогдох яамдуудад хүргүүллээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнг Сангийн яамны хөрөнгө оруулалт удирдлагын publicinvestment.gov.mn цахим системд байршуулж хэвшсэн бөгөөд орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийг дээрх цахим системд холбохоор Сангийн яаманд хүсэлт хүргүүлээд байна. Гүйцэтгэл цахимжнаар цаг хугацаа хэмнэх, бүрдүүлдэг цаасан материал цөөрсөн зэрэг давуу талууд ихтэй байна. Иргэд, олон нийт дээрх цахим сайтаар дамжуулан улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд санал өгөх, хяналт тавих, явц, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг цаг алдахгүй авах нөхцөл бүрдээд байна.		
68	163	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2023-07-19 Дугаар 2023_279 2.5.Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, аймгийн төвийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн аюулгүйн нөөцөд 150 тонн өвс, 50 тонн тэжээл бэлтгэхээс 670 боодол өвс, 16500 боодол ногоон тэжээл буюу 425.9 тонн өвс, ногоон тэжээл бэлтгэсэн. Аймгийн Онцгой комиссын 2024 оны 01 дүгээр хуралдааны шийдвэр, Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/31 дүгээр захирамжаар өвөлжилт хүндэрсэн 17 суманд 14250 боодол өвс, ногоон тэжээлийг 8.0 мянган төгрөгөөр аймгийн аюулгүйн нөөцөөс олгоод байна. Төв суурин газрын хүн амын махны үнийг тогтворжуулах, махны нөөц буурах үед үүсэх үнийн зохиомол хөөрөгдлөөс хамгаалах, улирлын нөөц бүрдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 150.0 сая төгрөгийн санхүүжилтээр махны нөөц бэлтгэх тендер зарлан, Арвайхээр сумын “Итгэлт хүнс баялаг” ХХК шалгарч, 20.0 тн хонины махны нөөц бүрдүүлсэн. Нөөцийн махыг Арвайхээр сумын баг тус бүрийн 13 хүнсний дэлгүүрүүдээр дамжуулан борлуулсан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

69	164	Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2023-08-16 Дугаар 2023_294 3.Аймаг, сум, чөлөөт бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг аймаг, сумын Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нарт үүрэг болгосугай.	Аймаг, сум, чөлөөт бүсийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй болон тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргаагүй.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
70	165	Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2023-08-23 Дугаар 2023_304 2. Цэргийн дүйцүүлэх алба хаах арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/552 дугаар захирамж, Цэргийн штабын 2023 оны “Сургалт бэлтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Цэргийн албыг 2023-2025 онд биеэр дүйцүүлэн хаах 45 иргэнтэй “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл” шатны сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл 14 хоногийн хугацаатай Зэвсэгт хүчний 113 дугаар тусгай салбарын материаллаг баазыг түшиглэн зохион байгуулж явууллаа.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.)	
71	166	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023-08-30 Дугаар 2023_312 4. Аймгийн Засаг даргын тамгын газрын орон тоог нэмэгдүүлсэнтэй холбогдон гарах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан зохицуулж, цаашид	Засгийн газрын тогтоолоор аймгийн Засаг даргын Тамгын газрын орон тоо нэмэгдэж, түүнтэй холбоотой цалин хөлс болон бусад зардлын тооцоог төсвийн тодотголоор шийдвэрлэсэн. Мөн 2024 оны төсөвт тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан, цаашид жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Дотоод хяналтад авч хяналтаас	

		жил бүрийн төсвийн төсөлдөө тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай		хасуулах саналтай.)	
	167	5. Худалдан авах ажиллагааны газар байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу зохион байгуулж, албан хаагчдыг орон тоо, цалингийн сан, эд хөрөнгийн хамт Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн ажиллуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Орон нутгийн өмчийн газраас Худалдан авах ажиллагааны үйл ажиллагааг салгаж газар болгож байгаатай холбоотой бүтэц, орон тоо, бусад урсгал зардлын тооцоог 2024 оны төсвийн жилээс эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж, орон тоо, бүтцийг батлан зардлыг тооцон төсвийг батлуулж, санхүүжилтийг олгож байна. Аймгийн Худалдан авах ажиллагааны газрыг 8 орон тоотой буюу жилийн төсвийг 262.5 сая төгрөгөөр батлан үйл ажиллагаа явагдаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Дотоод хяналтад авч хяналтаас хасуулах саналтай.)	
72	168	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321 2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	“Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх орон нутгийн зөвлөлийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулж, 2024 онд хэрэгжүүлэх 5 зорилтын хүрээнд 72 үйл ажиллагааг төлөвлөн, салбар дундын оролцоотойгоор 84.0 хувийн гүйцэтгэлтэй олон талт арга хэмжээнүүдийг хэрэгжүүллээ. Аймгийн хэмжээнд хүн амын идэвхтэй хөдөлгөөний талаарх мэдлэг, хандлага, дадал, хооллолтын байдал, архи тамхины хэрэглээ, боловсролын байгууллагын агаар дахь нянгийн үзүүлэлт, Арвайхээр сумын агаарын бохирдлыг хүн амын өвчлөлтэй харьцуулан судалсан нь, Шүд цооролтын тархалтыг амны хөндийн эрүүл ахуйн дадалтай холбон судалсан нь зэрэг 6 судалгааг хийж, судалгааны үр дүнг НЭМҮТ-ийн эрдэм шинжилгээний болон ХӨСҮТ-ийн талбарын тархвар судлалын хуралд хэлэлцүүлж, цаашид салбарын болон орон нутгийн удирдлагуудад танилцуулж, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Архи, тамхины болон амны хөндий, сүрьеэгийн чиглэлээр 123 үе тэнгийн сургагч, 20 сайн дурын	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			ажилтныг тус тус бэлтгэн, ажиллуулж, үр дүнг тооцон ажиллаж байна. Дээрх бэлтгэгдсэн үе тэнгийн хүүхдүүдтэй хамтран сагсан бөмбөгийн өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Электрон Тамхинаас Татгалзая -Тамхи бидний сонголт биш уриан дор зохион байгуулж, 34 багийн 306 сурагчийг хамруулсан. Аймгийн бие тамир, спортын газраас 6770 иргэнийг бие бялдарын түвшин тогтоох сорилд хамруулж, дүгнэлт хийн, хувь хүнд нь тохирсон дасгал хөдөлгөөн, хооллолтын жорыг өгч, зөвлөсөн Тайлант онд “Эрүүл чийрэг Өвөрхангайчууд-2024” уриалгын дор 16 сум, 15 байгууллагатай хамтран зохион байгуулсан нийтийн биеийн тамирын 98 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 47.729 иргэн хамрагдлаа.		
73	169	“Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2023-08-30 Дугаар 2023_322 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр “Шүд угаах цаг”-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Сумдын эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн шүдний тусламж үйлчилгээ үзүүлэх байдлыг үнэлэхэд шүдний тусламж үйлчилгээг үзүүлэх өрөө тасалгаа, багаж тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бэлэн байдлыг хангасан, мэргэжлийн хүний нөөцтэй эрүүл мэндийн байгууллага 6, шүдний тусламж үйлчилгээ үзүүлэх чадамжгүй 12 сумын эрүүл мэндийн төв байв. Үнэлгээний дүнд үндэслэн шүдний тусламж үйлчилгээг үзүүлэх өрөө тасалгаа, багаж тоног төхөөрөмжгүй, мэргэжлийн хүний нөөцгүй 12 сумын эрүүл мэндийн төвийг, хувийн хэвшлийн шүдний эмнэлэгүүдтэй хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулан 0-18 насны хүүхдүүдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, 1988 хүүхдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээнд хамруулахад цоорлын тархалт 76.5 хувь байна. Эдгээр үзлэг, эмчилгээнд хамрагдсан хүүхдүүдийн 527 буюу 41.2 хувийг эрүүлжүүлж, 1100	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			буюу 78.2 хувийг эрдэсжүүлэх эмчилгээнд хамрууллаа. “Шүд угаалтын аймгийн аварга шалгаруулах” анхдугаар тэмцээнийг ерөнхий боловсролын сургуулийн 4-7 дугаар ангийн сурагчдын дунд 2 үе шаттайгаар зохион байгуулж 1500 гаруй хүүхэд хамрагдсан байна. Мөн шүдний эрүүл мэндийн сургалтыг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн эмч, нийгмийн ажилтан, арга зүйч, эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудын төлөөлөл 76 хүнийг амны хөндийн сургагчаар бэлтгэсэн байна. Шүд, амны хөндийн эрүүл мэндийн сургалт, зөвлөгөөг цэцэрлэгийн 7800 гаруй хүүхэд, сургуулийн 1-12 дугаар ангийн 16089 сурагчид хүргэн, урьдчилан сэргийлэх үзлэгт 19927 суралцагч хамрагдснаас өвчлөл 30 гаруй хувьд нь илэрсэн ба хүүхдийн шүдийг эмчлүүлж, эрүүлжүүлэхийг эцэг эхчүүдэд үүрэг болгож, шүдээ эрүүлжүүлж, эмчлүүлэх, цагаан идээ, агаар усаар биеэ чийрэгжүүлэх зөвлөгөөг хүргэсэн байна.		
74	170	Журам батлах тухай 2023-09-13 Дугаар 2023_344 2. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Төв суурин газрын хүн амын махны үнийг тогтворжуулах, махны нөөц буурах үед үүсэх үнийн зохиомол хөөрөгдлөөс хамгаалах, стратегийн улирлын нөөц бүрдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 150.0 сая төгрөгийн санхүүжилтээр 20.0 тн хонины махны нөөц бэлтгэдэг. Мөн Хархорин сумын “Их гурван гүрэм” ХХК-д 41.2 тн, иргэн С.Жамъянсүрэнд 70 тн зэрэг улаанбуудайн тариалан эрхлэгч нартай үр үржүүлгийн гэрээ байгуулж, үржүүлж үрийн нөөц бүрдүүлээд байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
75	171	Улсын нөөцөөс бараа материал гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай 2023-12-13 Дугаар 2023_449 3. Улсын нөөцөөс олгох тэжээлийг оновчтой хуваарилах, зориулалтын	Улсын нөөц болон аймгийн аюулгүй нөөцөөс олгосон малын тэжээлийн хувиарлалтыг оновчтой зохион байгуулан малын тэжээл тарааж, малчдын мэдээллийг малчин өрх бүрээр сумдаас авч нэгтгэн гүйцэтгэлийн тайланг Онцгой байдлын ерөнхий газарт хугацаанд нь хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.

		бусаар зарцуулах, худалдаалахаас урьдчилан сэргийлж, хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт 2024 оны I улиралд багтаан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засагдарга нарт даалгасугай.			
76	172	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-13 Дугаар 2023_456 1.2. улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэхээр гэрээ нь хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах;	Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 456 дугаар тогтоолын дагуу Хархорин сумын Аврах гал унтраах ангийн барилгын санхүүжилт 499.8 сая төгрөг, Төгрөг сумын Эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил дууссан боловч санхүүгийн жилд багтаан материалаа бүрдүүлж амжаагүй тул 250.3 сая төгрөг, Хархорин сумын 2 дугаар сургуулийн спорт заалны барилгын ажил удаашралтай явагдаж гэрээнд заасан хугацаандаа ашиглалтад ороогүй тул 103.7 сая төгрөг, нийт 853.8 сая төгрөгийг аймгийн барьцаа хөрөнгийн дансанд авсан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	173	1.3. төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулсны үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор энэ тогтоолын 1.2-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх.	Аймгийн хэмжээнд энэ онд Төгрөг сумын Эрүүл мэндийн төвийн барилга, Хархорин сумын 2 дугаар сургуулийн спорт заал ашиглалтад орж санхүүжилтийг олгоод байна. Хархорин сумын Аврах гал унтраах ангийн барилгын ажлыг гүйцэтгэгч компани нэмэлт санхүүжилт шийдвэрлэгдсний дараа ажил хийнэ гэсэн шалтгаанаар энэ онд ажил хийгээгүй тул барьцаа дансанд байршуулсан 499.8 сая төгрөгийг Сангийн яамны дансанд буцаан төвлөрүүлэхээр шийдвэрлээд байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
77	174	Аргачлал шинэчлэн батлах тухай (Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн	Энэ онд орон нутгийн хөгжлийн санд анх 13854.9 сая төгрөг хуваарилагдсан ба улсын төсвийн тодотголоор 14480.7 сая төгрөг болж нэмэгдсэн, жилийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулалд		

		сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал) 2023-12-20 Дугаар 2023_457 2. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2024 оны төсвийн жилээс эхлэн энэ тогтоолын 1-д заасан аргачлалын дагуу тооцон хуваарилж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	1075.5 сая төгрөг, мөн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрт 272.2 сая төгрөгийг сумдад шууд хуваарилсан. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын 60.0 хувийг хүн ам, нутаг дэвсгэр, ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээнд үндэслэн итгэлцүүрээр хуваарилж, үлдсэн 40.0 хувь буюу 5253.1 сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилан төлөвлөгөөт санхүүжилтийг олгосон.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
78	175	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_458 2. Төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.(Өвлийн аялал жуулчлалын 2024 оны төлөвлөгөө) Төлөвлөгөө батлагдсанаас хойш хэрэгжилтийг тайлагнах	Аялал жуулчлалын гол бүс нутаг Орхоны хөндийн Улаанцутгаланд 2024 оны 12 дугаар сарын 7,8-ны өдрүүдэд “KHARAKHORUM ICE FESTIVAL 2024” эвент арга хэмжээг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын дэмжлэгтэйгээр Mongolia Expeditions, Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Биеийн тамир, спортын газар, аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газруудтай хамтран зохион байгууллаа. Мөсөн хананд авиралтын KHARAKHORUM ICE FESTIVAL цомын аварга шалгаруулах мэргэжлийн тамирчдын уралдаан мөн сонирхогчдын хурдны төрлийн авиралтын шилдгүүдийг тодруулсан бөгөөд тэмцээнд Франц болон Хятад улсаас тамирчид ирж оролцлоо. “KHARAKHORUM ICE FESTIVAL 2024” эвент арга хэмжээг зохион байгуулахад орон нутгийн мэргэжлийн холбоодыг дэмжин хамтран ажиллаа. Үүнд: Аймгийн авто спорт холбоотой хамтран сонирхогчдын богино зайн бартаат замын уралдаан, Мөсөн шагай харвааны холбоотой хамтран багийн мөсөн шагай харваа, Сурын холбоотой хамтран мөсөн сурын харваа зэрэг тэмцээнүүдийг тус тус зохион байгуулж шилдгүүдийг тодрууллаа. Орон нутгийн мэргэжлийн холбоодын зохион байгуулсан	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			тэмцээн уралдаанд оролцохоор Дундговь, Архангай, Булган аймаг, Улаанбаатар хотоос баг тамирчид ирж оролцсоноороо онцлогтой боллоо.		
79	176	Мах бэлтгэхэд зориулан олгох зээлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_461 4. Мах бэлтгэн нийлүүлэлт, борлуулалт болон чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн улсын хэмжээнд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 08-00-02/29 тоот удирдамжаар 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 01 дүгээр сарын 15-ны өдрүүдэд Арвайхээр, Хархорин сумдын мал төхөөрөх 4 аж ахуйн нэгж, мах боловсруулах 1 аж ахуйн нэгж, нийт 5 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын хэрэгжилтийн байдалд хяналт шалгалтыг хийлээ. Дээрх мал төхөөрөх 4 аж ахуй нэгжид гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 8 дугаар сарын 14-ний өдрөөс 09 дугаар сарын 03-ны өдрийн хооронд хийсэн. Хяналт шалгалтаар бага эрсдэлтэй үнэлэгдсэн “Өв эко мийт” ХХК, “Итгэлт баялаг хүнс” “Дээжийн өргөө” ХХК-ийн мал төхөөрөх 3 үйлдвэрт үйл ажиллагааны дүгнэлт гаргасан. Хархорин сумын “Далайн одод трейд” ХХК-ийн мал төхөөрөх үйлдвэрийн үйл ажиллагаа 78.0 хувьтай буюу их эрсдэлтэй байгаа тул дүгнэлтийг цуцалсан шийдвэрийг хэвээр үлдээж, үйл ажиллагаа явагдаагүй байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
80	177	2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарлах тухай 2023-12-27 Дугаар 2023_481 4. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулах, холбогдох тооцоо, судалгаа хийх, санал өгөх чиглэлээр	Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, төрийн захиргааны бусад албан хаагчдыг оролцуулсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын талаарх хэлэлцүүлгийг Арвайхээр хотноо 2024 оны 01 дүгээр сард зохион байгуулсан. Бүсчилсэн хөгжлийн урьдчилсан хэлэлцүүлэг 2024 оны 01 дүгээр сарын 27-нд Улаанбаатар хотноо	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагад даалгаж, нутгийн өөрөө удирдах байгууллага, улс төрийн нам, эвсэл, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад уриалсугай.	зохион байгуулагдаж орон нутгаас аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрдэм шинжилгээний байгууллагын судлаач, Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын төлөөлөл нийт 35 хүн оролцож, тус хэлэлцүүлгээс гарсан саналыг 2024 оны 02 дугаар сарын 1,2-нд “Монголын эдийн засгийн чуулган, бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөнөөр хэлэлцэж дараах тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Үүнд: -ХАА, хөнгөн хүнсний үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх, -Байгаль, түүх соёл, археологи, рашаан сувилалд түшиглэсэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх -Худалдаа, тээвэр логистикийн салбарыг хөгжүүлэх Дээрх чуулганд орон нутгийн зүгээс 58 хүний төлөөлөл оролцлоо. Мөн 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулганд орон нутгаас аймгийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн хөгжлийн төв болох 5 сумын удирдлага, албан хаагч нар оролцож, тус чуулганд Хангайн бүсийн танилцуулгыг аймгийн Засаг дарга, аймгийн танилцуулгыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга танилцуулж ажилласан.		
81	178	Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-27 Дугаар 2023_483 2.8. Иргэд орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон сууцны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бүс нутгийг тодорхойлж, шаардлагатай газрыг чөлөөлж, олгох арга хэмжээ авч ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	Иргэд орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Арвайхээр сумын 13 дугаар багийн шинэ суурьшлын бүсэд 20 га талбайд 1600 айлын орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 25/01 дүгээр тогтоолоор батлуулсан. Мөн Арвайхээр сумын 13, 5 дугаар багуудад орон сууцны дахин төлөвлөлт хийж нийт 293 айлын 9 орон сууцны барилга 10-80 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		(А.Энхманлай), аймгийн Засаг дарга нарт;			
	179	2.9. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон нутгийн иргэдийн амьдрах тав тухтай орчныг бий болгох зорилгоор цаашид хот суурин болж хөгжих боломжтой сумдад орон сууц барих талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;	Орон нутагт иргэдийн амьдрах тав тухтай орчныг бий болгох зорилгоор шинээр хийгдэж байгаа Хужирт, Нарийнтээл сумдын “Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд орон сууцны барилгажилтыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм дүрм стандартын дагуу тусган ажилласан. Арвайхээр сумын 13 дугаар багийн Шинэ суурьшлын бүсэд 20 га талбайд 1600 айлын орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 25/01 дүгээр тогтоолоор батлуулсан. Мөн энэ онд Хархорин суманд 28 айлын 1 орон сууц, Арвайхээр суманд 157 айлын 5 орон сууц ашиглалтад орсон. Арвайхээр сумын хэмжээнд орон сууцны нийлүүлэлт сайжирч байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
	180	2.10. Орон нутаг дахь төрийн үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;	Энэ онд орон нутгийн төсвийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баруунбаян-Улаан, Өлзийт сумдад төрийн албан хаагчдын орон сууцны барилга барихаар зураг төслийг гүйцэтгэсэн. Тухайн төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгарсан бөгөөд хүйтний улирал эхэлсэнтэй холбоотойгоор 2025 онд гүйцэтгэхээр гэрээ байгуулаад байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
82	181	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай 2024-01-17 Дугаар 2024_21	“Шинэ Хархорум” хот байгуулахаар улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж, өмчилж байгаа газрын нарийвчилсан судалгааг гаргаж Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан улсын тусгай хэрэгцээний газартай давхцалтай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж, өмчилж байгаа газрын нарийвчилсан судалгааг гаргаж, “Шинэ Хархорум” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн газрыг шилжүүлэх, чөлөөлөх, нөхөх олговор тооцох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), холбогдох аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	газарт хүргүүлсэн. Нийт 107 аж ахуйн нэгжийн эзэмшил 19601 га газар, 538 иргэний эзэмшил 2286.7 га газар, 1585 иргэний өмчилсөн 117 га газар тусгай хэрэгцээний газартай давхацсан байна. Дээрх өмчлөл, эзэмшилд олгосон газрын суурь үнэлгээг Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын дагуу тооцоход 89.7 тэрбум төгрөг болж байна. Газрыг шилжүүлэх, чөлөөлөх, нөхөх олговор тооцох ажил эхлээгүй.		
83	182	Фестиваль зохион байгуулах тухай 2024-01-25 Дугаар 2024_41 3. Фестивалийг зохион байгуулахад зохих дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд 55 хүний бүрэлдэхүүнтэй оролцож нутгийн онцлог соёлын өв болох Уянгын гэрийн мод эрээлэх, сийлбэрлэх, уламжлалт “Эсгий ширмэл ширдэг ширэх”, “Зүймэл, даавуу урлал хийх”, “Арьс шир, суран эдлэл хийх”, “Дээс томох” “Монгол гутал, гөлөм хийх” зэрэг урлалын төрлөөр оролцсон. Мөн иргэдэд зориулан “Монгол уран бичвэр”, “Сийлбэрлэх, эрээлэх урлал”, “Уяа зангилаа, суран сүлжмэл”, “Уран зураг” “Шар сүүний чихэр хийх” зэрэг боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэн, бариа заслын үйлчилгээ үзүүлсэн. Отогт зочилсон бүх зочид гийчдэд “Адуу маллах арга ухаан”, “Гүүний үр сүү гаргах” зан үйлийг танилцуулж, хуруудах, дэмбээдэх, аравдах зэрэг уламжлалт тоглоом болон Төв халхын уртын дуу болон ардын дуу, Хоолойн лимбэ, Үндэсний хөгжим, бүжиг зэрэг онцлог үзүүлбэр бүхий язгуур урлагийн тоглолтыг толилуулсан. Ардын язгуур урлагийн тоглолтод 26	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.)	

			ардын авьяастан, өвлөн уламжлагч нар, уламжлалт гар урлалын үзэсгэлэнд 10 урлаачийн 7 нэр төрлийн 54 бүтээл, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаанд 2 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч тус тус оролцож, 4.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн. “Гүүний үр сүү гаргах” зан үйл, ардын язгуур урлагийн тоглолтыг 15 удаа толилуулж 4500 гаруй дотоод гадаадын иргэдэд, гар урлалын үзэсгэлэнг 3 өдөр дэлгэж 3000 гаруй иргэдэд, боловсролын хөтөлбөрт 900 гаруй хүнийг хамруулан нийт 10.0 мянга гаруй иргэнд үйлчилсэн. Тус арга хэмжээнд 38.8 сая төгрөг зарцуулсан.		
84	183	Морин хуурын улсын чуулгыг өргөтгөх, морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_59 6. Энэ тогтоолын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг жил тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд тус тус даалгасугай. (5.“Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээ”-г хавсралт ёсоор баталсугай.)	“Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх” аймгийн хөтөлбөрийг боловсруулан Хөгжимт драмын театрын уран сайхны зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Үүний үр дүнд морин хуур хөгжмийн сургалтыг эрчимжүүлэх зорилгоор 25 хүүхдийн бүрэлдэхүүнтэй Аймгийн Хөгжимт драмын театрын дэргэдэх Өсвөрийн морин хуурын чуулга байгуулагдаж, “Монгол аялгуу” анхны тоглолтоо хийн 500 гаруй үзэгчдэд хүргэж, 4.0 сая төгрөгийн орлого олсон. Мөн Өсвөрийн морин хуурын чуулгын удирдаач багш Монгол Улсын Консерваторт удирдах ур зүйн 3 хоногийн дадлага, сургалтад хамрагдаж ур чадвараа нэмэгдүүлсэн. Өсвөрийн морин хуурын чуулгагт дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг хүссэн Аймгийн Засаг даргын 1/552, 1/553 тоот албан бичгүүдийг Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт, Өсвөрийн морин хуур чуулгыг бэхжүүлэх чиглэлээр чуулгын дүрмийг боловсруулан аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст тус тус хүргүүлсэн. Өсвөрийн морин хуурын чуулга “Соёлын бүтээлч сар-2024” аяны нээлт, Монголын эмэгтэйчүүдийн Холбоо үүсч хөгжсөний 100 жилийн хүндэтгэлийн тоглолтод	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			оролцож, Хөдөлмөрийн баатар Н.Жанцанноровын "Монгол аялгуу", "Цагаан суварга" бүтээлүүдийг тоглон 800 гаруй үзэгчдэд хүргэж, морин хуурын өвийг сурталчилсан. Мөн Хархорин суманд өсвөрийн морин хуур чуулгын "Монгол аялгуу" контентыг хийж цахим орчинд түгээн 120 мянга гаруй хандалтыг авсан. Аймгийн Хөгжимт драмын театрт хамтран Соёлын төвийн хөгжим, бүжгийн багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, чадавхжуулах зорилгоор танхимын сургалтыг 5 өдрийн турш зохион байгуулж 14 сумын 8 хөгжмийн багш, 13 бүжгийн багшийг хамруулж, уг багш нар сум, орон нутагтаа морин хуурын сургалтыг хичээллүүлэн, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулсан.		
85	184	Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_62 2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай. (1.Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан зудын эрсдэлийг бууруулах, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд	Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан зудын эрсдэлийг бууруулах, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Цаг үеийн шинжтэй, бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.)	

		гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.)			
185	3.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай: 3.1. Мал аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдал, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор “Малчдадаа тусалъя аян”-ыг үндэсний хэмжээнд зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Мал аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдал, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилготой “Малчдадаа тусалъя аян”-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн ханган ажиллав.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Цаг үеийн шинжтэй, бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.)		
186	3.3. Цасанд боогдсон зам, давааг чөлөөлөх, шар усны үерт өртөж болзошгүй малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян), аймгийн Засаг дарга нарт, шаардлагатай хүн, хүч, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт;	Цасанд боогдсон зам, давааг чөлөөлөх, шар усны үерт өртөж болзошгүй малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, шаардлагатай хүн, хүч, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлж ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Цаг үеийн шинжтэй, бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.)		

	187	3.8. Орон нутгийн төсвийн давсан орлогыг малчдад туслах арга хэмжээнд зарцуулах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт.	Цасанд боогдсон зам, давааг чөлөөлөх болон малчдад өвс тэжээл, хүнс хүргүүлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг хурдан шуурхай шийдвэрлэж аймгийн гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас 600.0 сая төгрөгийг төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Төсвийн хуваарьт өөрчлөлт орсны дагуу санхүүжилтийг шийдвэрлэж ажилласан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Дотоод хяналтад авч хяналтаас хасуулах саналтай.)	
86	188	Өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-28 Дугаар 2024_76 2. Тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс худалдан авах тэжээлийн буудай болон малын тэжээлийн үнэ, татан авах зардлын тооцоо, аймгуудад олгох хуваарийг гаргаж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Аймгийн хэмжээнд хаваржилт хүндэрсэнтэй холбогдуулан Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/101 дүгээр тушаалаар манай аймагт 900 тонн тэжээлийн буудай хувиарлагдсаны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан суман дахь хөтөл салбараас татан авахад шаардлагатай тээврийн болон шуудайлах зардалд аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалаас 172.3 сая төгрөгийг зарцуулсан. Дээрх тэжээлийн буудайг 17 суманд хуваарилан малчдад олгосон.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Цаг үеийн шинжтэй, бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.)	
87	189	Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77 3. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн	Тайлант хугацаанд суурь болон төрөлжсөн мэдээллийн сан шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах талаарх хүсэлт гаргаагүй бөгөөд журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”)			
88	190	Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82 2.Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.)	Уг тогтоолоор орон нутагт ажилласны нэмэгдлийг төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар бодож олгохоор төсөвт тооцон тусгасан. Орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцох үндсэн цалингийн хэмжээг тодорхойлохдоо Засгийн газрын тогтоолоор баталсан төрийн захиргааны болон төрийн улс төрийн албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг баримтлан тооцсон. Мөн орон нутагт ажилласны нэмэгдлийг тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны, үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэн хэрэгжүүлж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Дотоод хяналтад авч хяналтаас хасуулах саналтай.)	
89	191	Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024-02-28 Дугаар 2024_83 3.Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1.“Төрийн захиргааны	Тасралтгүй, тогтвор суурьшилтай ажиллаж буй төрийн захиргааны албан хаагчдад олгох тэтгэмжийн зардлыг 2024 оны төсөвт тусган батлуулсан. Энэ оны 4 дүгээр сараас эхлэн шалгуур хангасан төрийн захиргааны албан хаагчид 6 сарын тэтгэмжийг олгож эхэлсэн бөгөөд нийт 459.7 сая төгрөгийг олгосон байна. Цаашид жил бүрийн төсөвт тооцон суулгана.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Дотоод хяналтад авч хяналтаас хасуулах саналтай.)	

		албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.)			
90	192	Тусгай зориулалтаар 2024 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай 2024-03-06 Дугаар 2024_89 2. Тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааг тухайн жилд агнах, барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарт багтаан, холбогдох хуульд нийцүүлэн зохион байгуулахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Тусгай зориулалтаар 2024 онд агнах барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2024 оны 89 дүгээр тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 01/1339 дугаар албан бичиг, аймгийн Засаг даргын 2024 оны А/274 дүгээр захирамжийн дагуу Өвөрхангай аймагт 2024 онд "Тусгай зориулалтаар угалз 5, тэх 8, халиун буга 3, бор гөрөөс 2, саарал чоно 2 тоо толгой агнуулахаар нээлттэй дуудлага худалдааг 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 07 дугаар сарын 17-ны өдрийн хооронд цахимаар амжилттай зохион байгуулж дууссан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай)	
91	193	Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай 2024-04-03 Дугаар 2024_136 2. Энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдсан байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, сум, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. ("Улсын хэмжээнд 2024 онд иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар болон төрийн	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай" 136 дугаар тогтоол, "Улсын хэмжээнд 2024 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай" 137 дугаар тогтоолоор манай аймгийн хэмжээнд нийт 955 нэгж талбар буюу 821.89 га газрыг иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулахаар тусгагдсан. Энэ оны 11 дүгээр сарын байдлаар 466 нэгж талбарын 232.24 га газрыг олгосон. Шинээр газар эзэмших тухай хүсэлт цахимаар 472 иргэн илгээсэн бөгөөд 32 иргэнд газар олголт хийгдэж сумын Засаг даргын захирамж гарсан. 35 нэгж талбарыг дуудлага худалдаагаар, 13 нэгж талбарыг төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн. Төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт газар олголт хийгдээгүй.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		байгууллагад эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт"-ыг 1 дүгээр хавсралт, "Аж ахуйн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт"-ыг 2 дугаар хавсралт, "Улсын тусгай хамгаалалттай газарт ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт"-ыг 3 дугаар хавсралт)			
92	194	Жагсаалт батлах тухай 2024-04-17 Дугаар 2024_162 3. Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Монгол Улсын засгийн газрын 2024 оны "Жагсаалт батлах тухай" 162 дугаар тогтоолоор батлагдсан ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолтыг Сангийн сайдын 2023 оны 66 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу ногоон худалдан авах ажиллагааны зорилт болон орон нутгийн зах зээлээс нийлүүлэгдэх боломжтой байдлаар тухайн бараа, ажил, үйлчилгээний онцлогт нийцүүлэн боловсруулж хүргүүлсэн. Үүнд 16 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, төрийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хэрэглэгддэг байнгын хэрэгцээтэй принтерийн хор, А4-ийн бичгийн цаас, ажлын хувцас, эко саван, ажлын ширээ, сандал, компьютерийн дэлгэц, принтер, хөнгөн блок зэрэг нэр төрлийн бараа байна. Захиалагч байгууллагуудад худалдан авах барааны тавигдах шалгуур үзүүлэлтийг эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хаягдал багатай ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх чиглэлээр шалгуур үзүүлэлтийг тухайн бараа, ажил, үйлчилгээний онцлогт нийцүүлэн тусгаж хэвшихийг зөвлөмж болгон ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

93	195	“Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 2024-04-24 Дугаар 2024_166 3.“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий ач холбогдол, үр нөлөөг харьяа нутаг дэвсгэртээ сурталчлан таниулах, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулж, идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сум, багийн Засаг дарга нарт даалгаж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зөвлөсүгэй.	Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, “Шинэ хоршоо-чинээлэг малчин” төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд Улаанбаатар хотод “Шинэ хоршоо-чинээлэг малчин” хөдөлгөөний нээлтийн арга хэмжээнд 19 сумын малчин, төрийн албан хаагч, арилжааны банкны ажилтан нийт 160 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцсон. Мөн 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Арвайхээр суманд “Шинэ хоршоо-хөдөлгөөн”-ий Хангайн бүсийн нээлтийн арга хэмжээг Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан. Уг арга хэмжээнд Архангай, Баянхонгор аймгаас тус бүр 90, Өвөрхангай аймгаас 226, зохион байгуулагчид, МҮОНРТ зэрэг, нийт 450 орчим төрийн болон төрийн бус байгууллага, хоршооны гүшүүд, малчдын төлөөлөл оролцсон. Монгол Улсын Засгийн газраас Архангай аймагт 2024 оны 06 дугаар сарын 6-7-ны өдрүүдэд шинэ хоршоодыг чадавхжуулах Хангайн бүсийн сургалтад 80 хоршоологч малчин хамрагдсан, аймгийн хоршоологчдын мэдээллийг шинэчилж, Энэ оны 11 дүгээр сарын байдлаар шинээр 396 хоршоо байгуулагдаж, 31.0 тэрбум төгрөгийн зээлд хамрагдсан байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
94	196	Журам шинэчлэн батлах тухай 2024-04-24 Дугаар 2024_168 1. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай	Засгийн газрын 2024 оны 168 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх, журам”-ыг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
95	197	Зүй бусаар хорогдсон малын сэг зэм устгах, мал, амьтны халдварт	“Хариуцлагатай малчин-эрүүл мал” аяны хүрээнд төлөвлөгөөт халдваргүйтгэлд 1635 хашаа хороо 1148800 м², зoorь агуулах 6 цэгийн 1200 м², Худаг уст	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2024-04-24 Дугаар 2024_173 1.Хүн, мал, амьтны халдварт өвчин дэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг зохих журмын дагуу устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт тус тус даалгасугай	цэг 87 цэгийн 13751 м², нийтийн эзэмшлийн талбай 75 цэгийн 45560 м², тээврийн хэрэгсэл 372, мал амьтны тоног хэрэгсэл 3200 м² бүхий 91 ширхэг, түүхий эд бүтээгдэхүүн хадгалах цэг, махны үйлдвэр 22 цэгийн 18600 м², голомтын бүсийн 32820 м², устгалын талбай 91 цэгийн 248700 м², шувуу гахайн байр 2 цэгийн 1000 м², бэлчээр 25300 м² тус тус халдваргүйтгэл хийгдсэн. Тайлант онд нийт төлөвлөгөөт 1195220 м² талбай халдваргүйтгэхээс 1553919 м² талбайг ариутгаж, гүйцэтгэл 130.0 хувьтай хийгдсэн байна. Гоц халдварт өвчний халдваргүйтгэлд голомтын бүсийн 61700 м² талбай, сэжигтэй бүсийн 19616, машин техник 308 м², нийт 84684 м² талбайд халдваргүйтгэл хийгдсэн.		
198	2.Малын сэг зэмийг устгах, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвтөө зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, иргэд, малчидтай орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээр дамжуулан байгуулах гэрээт ажлын хөлсийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зохих журмын дагуу гаргахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад тус тус даалгасугай	“Малын сэг зэм устгах арга хэмжээ”-ний хүрээнд тэмээ 16, адуу 3747, үхэр 3000, хонь 40088, ямаа 36129, амьтан 114, нийт 83094 малын сэг, зэмийг булж устгасан байна. Сэг зэм устгал 96.63 хувьтай хийгдсэн. Энэ зун 5 суманд үер усны аюул болон аянганд цохиулсан 449 хонь, 589 ямаа, нийт 1038 малыг булж устгасан. “Малын сэг зэм устгах арга хэмжээ”-ний хүрээнд 19 сум 63 багийн 45 цэгт тэмээ 16, адуу 3747, үхэр 3000, хонь 40088, ямаа 36129, амьтан 114, нийт 83094 мал, амьтны сэг зэмийг булж устгаж, 96.3 хувьтай хийгдсэн. Уг арга хэмжээнд Малын эмч 37, сумдын ЗДТГ-аас 195, сумаас 298, нийт 530 хүн ажилласан. Суудлын автомашин 63, ковш 20, экскаватор 20, ачааны машин 95, нийт 190 техник хэрэгсэл ХХҮГ-аас нийтийг хамарсан ажлын хүрээнд 171 хүн ажлуулж, 40.0 сая төгрөг зацуулсан. Мөн сумдын ЗДТГ-аас 50.6 сая төгрөг зарцуулсан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

			Сэг, зэм устгалын ажилд энэ онд нийт 136.1 сая төгрөг зарцуулсан.		
96	199	Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2024-05-01 Дугаар 2024_187 4.6.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 онд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэх газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, газар эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тухай бүр нь дүгнэлт гаргаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т тус тус даалгасугай	Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Нарийнтээл суманд 3 нэгж талбарын 9.9 га, Есөнзүйл суманд 12 нэгж талбарын 59.47 га, Уянга суманд 13 нэгж талбарын 24.5 га газрыг мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэхээр төлөвлөж байна. Энэ онд Бүрд суманд 2 нэгж талбарын 10.0 га, Хархорин суманд 28 нэгж талбарын 127.6 га, Арвайхээр суманд 7 нэгж талбарын 22.0 га газар төлөвлөснөөс Бүрд суманд 2 нэгж талбарын 10.0 га, Хархорин суманд 4 нэгж талбарын 20.0 га, Арвайхээр суманд 3 нэгж талбарын 10.5 га газрыг хоршоодод эзэмшүүлээд байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
97	200	Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цаг, үйлчилгэний цогцолбор барьж байгуулах тухай 2024-05-01 Дугаар 2024_189 2.. Энэ тогтоолын хавсралтад заасан байршилд эзэмшүүлэх газрыг аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлэх ажлыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан	Тус тогтоолын хавсралтад Хархорин, Хужирт, Хайрхандулаан, Өлзийт сумдын нутаг дэвсгэр тусгагдсан байна. Үүнээс Хархорин, Хужирт сумдад байгуулах байршлын цэг нь улсын тусгай хамгаалалттай газарт хамаарч байгаа тул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас шийдвэрлэхээр ажиллаж байгаа. Хайрхандулаан сумын нутагт байгуулах байршлын цэг нь сумын төвийг улсын чанартай А0302 чиглэлийн хатуу хучилттай авто замтай холбосон шинэ авто замын трасстай давхцсан байна. Өлзийт сумын нутагт	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймаг, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	байгуулах байршлын цэгийг эзэмшүүлэх газрыг 2025 оны сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан.		
	201	4.Олон улс, улсын чанартай авто зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэгийн цэвэрлэгээ, арчлалт, хог хаягдлын асуудлыг зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай	Энэ онд улсын чанартай авто зам дайран өнгөрдөг сумдуудын түр буудаллах цэг, ариун цэврийн байгууламжийн орчин дахь хог хаягдлыг улирал бүр цэвэрлэж Арвайхээр сум зөөлөн хуванцар-2.8 тн, лааз-1.7 тн, төмөр-19.5 тн, ундааны сав-7.1 тн, гялгар 0.4 тн, корданин цаас 6.5 тн ангилан ялгаж пресслэсэн бөгөөд 24 тн хатуу хуванцар дахин боловсруулж хайлуулан 1910 ширхэг хашааны шон бэлтгэсэн. Хужирт сум 3.2 тн хуванцар, 1.6 тн гялгар, 0.7 тн лааз, Хайрхандулаан сум 0.9 тн, Хархорин 20 тн, Тарагт сум 0.6 тн, Уянга сум 15 тн дахивар хог хаягдлыг ангилан ялгах төвд үйл ажиллагаа явуулдаг “Эко цэнэ”, “Цэмцгэр” төвүүд болон Улаанбаатар хот руу нийлүүлээд байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
98	202	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196 3. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	“Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглах эрх орон нутагт үүсээгүй байгаа бөгөөд эрхлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллаж байна.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	

99	203	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215 4.. Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Docx)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Төрийн байгууллагуудын албан бичиг солилцооны дундын систем (DocX)-д төрийн 43 байгууллага холбогдож, үйл ажиллагаандаа ашиглаж, тус системээр албан бичиг солилцож хэвшээд байна. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллага, сумдын Засаг дарга нарт үүрэг чиглэл өгч, арга зүйгээр хангаж ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
100	204	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2024-05-22 Дугаар 2024_228 2.Энэ тогтоолын хавсралтаар баталсан солбицол бүхий талбайд тухайн авто замын засварын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат, Өвөрхангай аймгийн Засаг дарга И.Доржсүрэн, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав нарт тус тус даалгасугай	Улаанбаатараас Арвайхээр чиглэлийн хатуу хучилттай авто замын шинэчлэл засварын ажлыг хийж гүйцэтгэх тендер зарлагдаж, гүйцэтгэгч шалгараагүй.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	
	205	3.. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах болон зам барилгын ажлын явцад түүх, соёлын эд зүйлс илрэх тохиолдолд холбогдох эрх бүхий	Улаанбаатараас Арвайхээр чиглэлийн хатуу хучилттай авто замын шинэчлэл засварын ажлыг хийж гүйцэтгэх тендер зарлагдаж гүйцэтгэгч	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	

		байгууллагад нэн даруй мэдээлэх, зам барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж, орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номин, Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат, Өвөрхангай аймгийн Засаг дарга И.Доржсүрэн, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав нарт тус тус үүрэг болгосугай	шалгараагүй тул ажил эхлэхээр гэрээ байгуулж, хяналт тавин ажиллана.		
101	206	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаарыг батлах тухай 2024-07-24 Дугаар 2024_10 2. Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2025 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн “Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн хязгаар”-ыг ирүүлсэн. Үүний дагуу орон нутгийн төсвийн орлого, зардлыг хязгаарт нийцүүлэн 2025 оны төсвийн төслийг боловсруулан хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
102	207	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2024-08-07 Дугаар 2024_28 3.1. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, “Атар-4	Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/635 дугаар захирамжаар аймгийн аюулгүй нөөцөд 150 тн өвс, 100 тн тэжээл, сумын аюулгүй нөөцөд нийт 950 тн өвс, (нэг сум 50 тн өвс) 760 тн тэжээл, (нэг сум 40 тн тэжээл), малчдын түвшинд 25047 тн өвс, 8349 тн гар тэжээл, 16968 тн хужир шүү бэлтгэхээр төлөвлөсөн. Аймгийн аюулгүй нөөцөд 206 тн өвс, 100 тн тэжээл, сумдын аюулгүй нөөцөд 634 тн өвс, 330 тн тэжээл, малчдын түвшинд 21509 тн өвс, 2346 тн сүрэл, 3716 тн ногоон тэжээл,	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг зарлах тухай" Засгийн газрын 2019 оны 476 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд атар газрыг тариаланд шилжүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах;	7732 тн гар тэжээл, 14292 тн хужир шүү бэлтгэсэн байна. Аймаг, сумын аюулгүй нөөцөд бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн 69.0 хувийг, малчдын түвшинд бэлтгэвэл зохих нийт өвс, тэжээлийн 90.0 хувийг бэлтгэсэн дүнтэй байна. Төв суурин газрын хүн амын махны үнийг тогтворжуулах, махны нөөц буурах үед үүсэх үнийн зохиомол хөөрөгдлөөс хамгаалах, улирлын нөөц бүрдүүлэх зорилгоор 2025 оны орон нутгийн төсвөөс 150.0 сая төгрөгийн санхүүжилтээр 20.0 тн хонины махны нөөц бэлтгэх тендерт "Итгэлт хүнс баялаг" ХХК шалгаран, гэрээ байгуулаад байна. Аймгийн хэмжээнд 6000 гаруй га атаршсан газар байгаа учраас атар газар эргэлтэд оруулах санал санаачилга гараагүй.		
208	3.2.Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;	Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/635 дугаар захирамжаар аймгийн аюулгүй нөөцөд 150 тн өвс, 100 тн тэжээл, сумын аюулгүй нөөцөд нийт 950 тн өвс, (нэг сум 50 тн өвс) 760 тн тэжээл, (нэг сум 40 тн тэжээл), малчдын түвшинд 25047 тн өвс, 8349 тн гар тэжээл, 16968 тн хужир шүү бэлтгэхээр төлөвлөсөн. Аймгийн аюулгүй нөөцөд 206 тн өвс, 100 тн тэжээл, сумдын аюулгүй нөөцөд 634 тн өвс, 330 тн тэжээл, малчдын түвшинд 21509 тн өвс, 2346 тн сүрэл, 3716 тн ногоон тэжээл, 7732 тн гар тэжээл, 14292 тн хужир шүү бэлтгэсэн байна. Аймаг сумын аюулгүй нөөцөд бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн 69.0 хувийг, малчдын түвшинд бэлтгэвэл зохих нийт өвс, тэжээлийн 90.0 хувийг бэлтгэсэн дүнтэй байна. Аймаг дундын отрын бүс нутаг Чилэнгийн бүсэд мал оруулахгүй өнжөөх бодлого барьж байгаа бөгөөд цагийн байдал хүндэрвэл өвөлжих, хаваржих 3 сумын 10000 малын захиалга хүргүүлсэн. Хөх дэлийн отрын бүс нутагт хуучин өвөлжиж, хаварждаг 12 малчин өрхийн 10000 орчим мал өвөлжихөөр байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

209	3.3. Улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, холбогдох төрийн байгууллагын зөвшөөрөл, гэрээний дагуу босоо чиглэлд отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах;	Энэ жилийн хувьд гадны аймаг сумдад мал өвөлжүүлэхгүйгээр аймаг дотроо отор нүүдэл хийхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Аймаг дундын отрын бүс нутаг Чилэнгийн бүсэд мал оруулахгүй өнжөөх бодлого барьж байгаа бөгөөд цагийн байдал хүндэрвэл 3 сумын 10000 малыг оруулах захиалга өгсөн. Хөх дэлийн отрын бүс нутагт хуучин өвөлжиж, хаварждаг 12 малчин өрхийн 10000 орчим мал өвөлжинө.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
210	3.4. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хэрэгжүүлэх төслийг орон нутгийн хөгжлийн болон бэлчээр ашиглалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан мал аж ахуйн салбарын үндсэн хөрөнгө, бүтээн байгуулалтын чиглэлд хандуулах;	“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд энэ оны 11 дүгээр сарын байдлаар шинээр 396 хоршоо шинээр байгуулагдаж Улсын бүртгэлд бүртгүүлсэн. Нийт 19 сумын 215 хоршоо 36.0 тэрбум төгрөгийн зээлд хамрагдсан. Аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн хэмжээнд малчны хөрөнгө оруулалтын зээлд авсан малчин өрхийн зээлийн асуумж, өвөлжилт хаваржилтын бэлэн байдлын үнэлгээ хийгдсэн. Аймгийн хэмжээнд энэ онд нийт 396 хоршоо байгуулагдаж, 215 хоршоо 36.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаад байна. Нийт 215 хоршооны 800 гаруй өрхөд, 36.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгож, малчин өрхөд малын тэжээл тариалах, малын үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлсэн байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
211	4. Энэхүү тогтоолд заасан арга хэмжээг батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.	Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх зорилгоор “Өв агро гурил” ОНӨХХК-д хаврын тариалалтад зориулж 130.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж намар хөнгөлттэй үнээр ногоон тэжээл авахаар гэрээ хийсэн. Үүний хүрээнд 1 боодол ногоон тэжээлийг 12000 төгрөгөөр тооцож, 15000 боодлыг нийлүүлэхээр болсон. Энэ онд 9000 гаруй боодол ногоон тэжээлийг аймгийн нөөцөд татан аваад байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

103	212	Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох 2024-08-28 Дугаар 2024_52_1 2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн Засаг даргын 2024 оны А/669 дүгээр захирамж, Цэргийн штабын 2024 оны “Сургалт бэлтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Цэргийн албыг 2024-2026 онд биеэр дүйцүүлэн хаах 45 иргэнтэй “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл” шатны сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл 14 хоногийн хугацаатай Зэвсэгт хүчний 113 дугаар тусгай салбарын материаллаг баазыг түшиглэн зохион байгуулж явуулсан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
104	213	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024-09-04 Дугаар 2024_66_1 3. Батлагдсан солбицол бүхий талбайд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгохыг Өвөрхангай аймгийн Засаг дарга И.Доржсүрэнд даалгасугай.	Тус тогтоолын дагуу 11 байршилд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээг Хужирт-Бат-Өлзий чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлыг гүйцэтгэгч компаниудтай байгуулан ажиллаж байна. Тухайн нутаг дэвсгэрт авто зам, барилга угсралтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахаар батлагдсан талбайгаас ажлын явцад түүх, соёлын эд зүйлс илрээгүй.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
105	214	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_86-1 1.1.Тухайн нутаг дэвсгэрийнхээ нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг нэгдсэн сүлжээнд холбох, хяналт тавих чиг үүрэг бүхий “Теле камерын хяналтын дэд төв”-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулах ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт;	Гудамж, зам талбайн хяналт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Камерын хяналтын дэд төв” ажиллаж байгаа бөгөөд сүлжээний инженер хариуцан аймгийн Цагдаагийн газартай хамтран ажиллаж байна. Тус төв нь хяналтын 21 дэлгэц, 1 серверийн өрөө нийт 36м2 талбайд үйл ажиллагаагаа явуулж, Арвайхээр сумын гудамж, зам талбайн 80 цэгийн 198 камерыг хянаж байна	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

215	1.3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа камерын стандартад нийцүүлэх, мэдээлэл холбоо, сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан “Теле камерын хяналтын дэд төв”-д холбох боломжийг судалж, шийдвэрлэхийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт;	Уянга сумын Засаг даргын Тамгын газрын нөөц хөрөнгөөс 20.0 сая төгрөгийг шийдвэрлүүлж Уянга сумын Таац, Жаргалант багийн төвийн (нэг дор байрладаг) 2 цэгт 3 ширхэг 360 эргэдэг стандарт шаардлагад нийцсэн Hikvision маркийн 4MP хүчин чадал бүхий хяналтын камерыг суурилуулж, ашиглалтад оруулсан. Арвайхээр сумын 8 дугаар багийн “Арвин” хүнсний дэлгүүрт Hikvision маркийн 4MP хүчин чадалтай, 200.0 мянган төгрөгийн 2 ширхэг камерыг, тус сумын 13 дугаар баг Пүрэвдоржийн гудамжны 909 байр буюу “Арцат 2 хотхон”-д MS маркийн 4 мегапиксель хүчин чадал бүхий 8 ширхэг, 960.0 мянган төгрөгийн үнэ бүхий камерыг, тус сумын 5 дугаар баг 127 байрны дотор 3, гадна 4 ширхэг Seetong маркийн камерыг 1.7 сая төгрөгөөр хувийн хэвшлийн байгууллага, хувь хүнээр хийлгүүлсэн. Цаашид дээрх хяналтын камеруудыг аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн “Телекамерын хяналтын дэд төв”-д холбох ажлыг үе шаттай хийнэ. Арвайхээр сумын 5-р баг Петровис колонкын уулзварын гэрлэн дохиог шинэчлэх хөрөнгийн аймгаас шийдвэрлүүлж суурилуулсан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
216	2. Теле камерын хяналтын төвүүдийн үйл ажиллагаа болон энэ тогтоолын 1.3-т заасан ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байхыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.	Өвөрхангай аймгийн хэмжээнд “Ногоон бүс” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд камержуулах ажилд энэ онд нийт 735.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгасан. Энэ оны 10 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 12 сумын тендер болон шууд худалдан авалтаар 598.9 сая төгрөгийн төсвөөр гудамж, зам, талбайд 203 камерыг шинээр суурилуулж, гүйцэтгэл 100.0 хувь хийгдсэн. Харин Баянгол суманд тендер зарлаж, “Өвөрхангай цахим сүлжээ” ХХК нь гэрээ байгуулан ажлын гүйцэтгэл хийгдэж байна. Богд, Уянга сумдад тендер зарласан шалгаруулалт хийгдээгүй байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

	217	4. Теле камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлээс хамгаалах шаардлагатай арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Теле камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлээс хамгаалах шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө боловсруулаад байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
106	218	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбилцлыг батлах, эрх олгох тухай 2024-09-25 Дугаар 2024_101_1 2. Энэ тогтоолын хавсралтад заасан солбилцол бүхий талбайд авто замын барилгын ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд түгээмэл тархцатай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох, эрх олгосон хуулийн этгээдийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Өвөрхангай аймгийн Засаг дарга И.Доржсүрэнд даалгасугай	Арвайхээр-Мандалговь чиглэлийн авто замын эхний үе шат (Өвөрхангай) 2.61 км авто зам, хоёр түвшний уулзвар барих барилга угсралтын ажлын гүйцэтгэгч шалгарч төсөл хэрэгжиж буй Тарагт сумтай ашигт малтмал олборлосны нөөц төлбөр авахаар гэрээ байгуулж ажиллаж байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
	219	3. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах болон замын барилгын ажлын явцад түүх, соёлын эд зүйлс илрэх тохиолдолд эрх бүхий байгууллагад нэн даруй мэдээллэх, авто замын барилгын ажил дууссаны	Арвайхээр-Мандалговь чиглэлийн авто замын эхний үе шат (Өвөрхангай) 2.61 км авто зам, хоёр түвшний уулзвар барих барилга угсралтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахаар батлагдсан талбайгаас замын барилгын ажлын явцад түүх, соёлын эд зүйлс илрээгүй.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж, орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Өвөрхангай аймгийн Засаг дарга И.Доржсүрэн нарт үүрэг болгосугай			
107	220	Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай 2024-10-02 Дугаар 2024_109_1 2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Ёс зүйн дэд хороо байгуулах тухай” А/05 дугаар тушаалаар аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд Ёс зүйн дэд хороог байгуулсан. Аймгийн засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь зөвхөн байгууллагын хүрээнд төдийгүй аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллага, сумдын удирдлагуудын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг хүлээж байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай” А/28 дугаар тушаалаар дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг баталсан. Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

			зүйн хэм хэмжээнд нийцүүлэн байгууллагын дотоод журмын төслийг боловсруулж байна.		
108	221	Журам батлах тухай “Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам” 2024-10-09 Дугаар 2024_120_1 2.. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг (Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам) үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай. (3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т тус тус даалгасугай)	Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тайлант онд төлөвлөгдсөн худалдан авах ажиллагаанд төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагаа төлөвлөгдөөгүй.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
109	222	Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах зарим газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай 2024-10-23 Дугаар 2024_131_1 2.2.Энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдсан байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг баримталж, Газрын	Аймгийн хэмжээнд шинээр газар эзэмших тухай хүсэлт цахимаар 472 иргэн илгээсэн бөгөөд 32 иргэнд газар олголт хийгдэж сумын Засаг даргын захирамж гарсан. 35 нэгж талбарыг дуудлага худалдаагаар, 13 нэгж талбарыг төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн. Төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт газар олголт хийгдээгүй.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, Засгийн газрын 2024 оны 136 дугаар, 74 дүгээр тогтоолууд болон энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, сум, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.			
110	223	ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2024-11-13 Дугаар 2024_163 2.2.Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	Дотоод хяналтад авч ажиллав.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	
Хэсгийн дундаж: 92.5					
Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
111	224	2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 05-нд хуралдуулж, хурлаар салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		ҮИИ.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	хэлэлцэн, 11 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажилласан. Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт өгөх, эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар болон Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компани (ЭБЦТС ТӨХК)-ийн Өвөрхангай салбар, Бат-Өлзий, Хархорин, Хужирт сумдын 209 албан хаагчдад хуулийг сурталчилах сургалт зохион байгуулсан. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын барилга байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбай хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, жирэмсэн эх зэрэг бүхий л хүнд хүртээмжтэй, стандартын шаардлагыг хангаж буй эсэхэд үнэлгээ хийж, 36 байгууллагын дэд бүтцийн хүртээмж сайжирсан. Аймгийн хэмжээнд төрөлхийн болон олдмол хөгжлийн бэрхшээлтэй 3585 гаруй иргэн бүртгэлтэй байгаагаас энэ онд нийгмийн халамжийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт 744 иргэн хамрагдаж 2.4 тэрбум, хөнгөлөлт тусламжид 2500 иргэн хамрагдаж 450.0 сая, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 531 хүүхэд хамрагдаж 2.0 тэрбум төгрөг тус тус нийгмийн халамжийн сангаас зарцуулсан байна.		
112	225	2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 63 дугаар тэмдэглэл 2021-12-08 Дугаар 2021_63 ХҮ.3.1.3. Орон нутгийн түвшинд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өсөлтийн шалтгааныг судалж, холбогдох зохицуулалт, арга хэмжээ авахад санаачилга гарган ажиллахыг бүх аймгийн засаг дарга нарт;	Аймгийн хэмжээнд бэлтгэвэл зохих өвс тэжээлийн аюулгүй байдал, нөөцийн хэмжээ, шатах тослох материал болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд орон нутаг дахь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчаас холбогдох төрийн байгууллагуудтай хамтарсан хяналтыг тус тус зохион байгуулж, байгууллага бүрд зөвлөмж өгч, арга зүйгээр ханган ажилласан. Мөн Хэрэглэгчийн эрхийг	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

			хамгаалах хууль тогтоомжийн хүрээнд иргэд, олон нийтээс ирүүлсэн гомдол мэдээллийн дийлэнх хувь нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, орон нутаг дахь арилжааны банкуудын үйл ажиллагаатай холбоотой байгаа бөгөөд дүрэм, журмын шаардлага нь иргэдийг чирэгдүүлж байгаад дүгнэлт хийн, холбогдох байгууллагуудад тухай бүрд шаардлага, зөвлөмж хүргүүлж ажилласан байна.		
113	226	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11 XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	И-Монгол академи УТҮГ-тай хамтран нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээг дахин загварчлах, шинээр нэвтрүүлэх үйлчилгээний процессын шинжилгээг хийж, тайлант хугацаанд 10 үйлчилгээг цахим үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia системд туршилтаар нэмж, угсрах ажил хийгдэж байна. Ингэснээр нутгийн захиргааны байгууллагаас үзүүлдэг 77 үйлчилгээг e-mongolia системд нэвтрүүлэх юм. Мөн Арвайхээр сумын 13 багийн Засаг даргын оршин суугаа газрын хаягийн тодорхойлолтыг цахим үйлчилгээний нэгдсэн портал (https://e-mongolia.mn/)-д 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлж, иргэдэд цахимаар үйлчилгээ үзүүлж хэвшсэн бөгөөд системд Арвайхээр сумын багуудыг тухайлсан нэршлээр оруулж өгсөн ба иргэд өөрийн оршин суугаа багийн нэршлийг мэдэхгүй улмаас энэ онд 120 гаруй хүсэлтийг харьяа биш багтаа гаргасан байсныг И-Монгол академи УТҮГ-т хүсэлт гаргасны дагуу өөрчлүүлж, дахин харьяа биш хүсэлтийн тоо багассан болно. Тайлант онд нийт төрийн үйлчилгээний хүсэлт, бүртгэлийн систем https://service.e-mongolia.mn/ -д 1118 хүсэлт ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. Мөн Өвөрхангай аймаг нийгмийн даатгалын тэтгэвэр авагч 26000 гаруй иргэдийн хувийн хэргийг	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			цахимжуулах, мэдээллийн сан үүсгэх программ хангамжийг нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Тус ажил хийгдсэнээр иргэд, тэтгэвэр авагчдын тэтгэврийг цахимаар шалгаж, тогтоох, цахим хяналт шалгалтыг сайжруулах, тэтгэврийн хувийн хэргийг зөөвөрлөж, шилжүүлэх шаардлагагүй, нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод, түргэн шуурхай болгох ач холбогдолтой.		
114	227	2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2022-03-02 Дугаар 2022_14 XIY.7.4. Мах, хүнсний ногооны нийлүүлэлт, борлуулалтад байнгын хяналт тавьж, үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох, зохиомлоор хомсдол бий болгох, борлуулалтын хэмжээг хязгаарлах зэрэг хууль тогтоомж зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 3.Мэндсайхан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (Т.Гантулга), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 414 цэг салбаруудаас 7 хоног бүр хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг авч нэгтгэн, хүн амын хүнсний хангамжийн хоногийн нөөцийн тооцоог хийж, тухай бүрд нь хүнсний хангамжийн цахим системд оруулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлэн ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг нийт 69 удаа сумдаас авч, хоногийн нөөцийн тооцоог хийхэд нөөц хангалттай байгаа бөгөөд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээ 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар мах 520.0 тн 70.2 хоног, гурил 510.0 тн 53.6 хоног, гурилан бүтээгдэхүүн 16.0 тн 0.9 хоног, төрөл бүрийн будаа 275.0 тн 57.8 хоног, хуурай сүү 57.0 тн 35.4 хоног, өндөг 2.0 тн 1 хоног, ургамлын тос 74.0 тн 33.7 хоног, төмс 126.0 тн 11 хоног, хүнсний ногоо 42.0 тн 1.7 хоног, элсэн чихэр 100.0 тн 31.47хоног, давс 55.0 тн 116.7 хоног, савласан ус 84.0 тн 0.4 хоногийн тус тус нөөцтэй байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
115	228	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 XX.5. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, стандартын талаар Барилга, хот	Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажилласан. Энэ онд аймгийн авто замын сангийн 489.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр сумын 5 дугаар	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав;	багийн Гэндэнгийн гудамжны 2 талын 1500 м явган хүний зам, орон нутгийн хөгжлийн сангийн 398.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хас банкны уулзвараас Хаан банк хүртэлх 2 талын 750 м явган хүний зам, Төв хаан банкны уулзвараас “Петровис” шатахуун түгээх станц хүртэлх баруун талын 850 м явган хүний замыг тус тус бүрэн шинэчилж ашиглалтад оруулсан. Мөн энэ онд ашиглалтад орсон 185 айлын 6 орон сууцны зураг төслийн ерөнхий төлөвлөгөөнд ногоон байгууламжийн норм дүрмийг тусган баталсан.		
229	XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын 16 насанд хүрсэн иргэн бүрт тоон гарын үсгийг иргэний хүсэлтээр оршин суугаа газрын харъяалал харгалзахгүйгээр иргэний үнэмлэхийн санах ойд байршуулж эхэлсэн бөгөөд 2022 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн тоон гарын үсгийг гар утасны апплекшинаар дамжуулан иргэдэд олгож байна. Тайлант онд аймгийн хэмжээнд тоон гарын үсэг авбал зохих иргэдийн 83.0 хувьд буюу 65974 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, тоон гарын үсэг олгоод байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

		Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.			
116	230	2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33 XIII.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжиж ажиллах; 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг	Салбар комисс тайлант онд 24 удаагийн хурал зохион байгуулж, 357 хүүхдийн асуудлыг хэлэлцэн, 328 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлсон. Үүнээс 91 хүүхдэд байнгын асаргаа шинээр тогтоож, 162 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэврийг 57 хүүхдэд тогтоосон байна. Хөгжлийн бэрхшээлээ тодорхойлуулсан 328 хүүхдээс сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 45, ерөнхий боловсролын сургуульд 177, насан туршдаа суралцахуйн нэгжид 5, Политехникийн коллежид 1 хүүхэд тус тус суралцаж байна. Боловсролын үйлчилгээнд хамрагдах насанд хүрээгүй 0-2 хүртэлх насны 25 хүүхэд байгаа бол боловсролын үйлчилгээнд хамрагдах шаардлагатай 75 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдээ боловсролын үйлчилгээнд хамруулах чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа. Хурлаар хэлэлцсэн хүүхэд бүр нарийн мэргэжлийн эмч нарын хяналтад байгаа бөгөөд эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Тайлант онд 9,18,36 сартай нийт 4406 хүүхдэд хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үзлэг хийхээс 3183 хүүхдэд үзлэг хийгдсэн. Үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс 9 сартай нийт 4 хүүхдийн онош батлагдан БОЭТ-өөс ЭХЭМҮТ-рүү илгээсэн. Дауны хам шинжтэй хүүхдийг харьяа эрүүл мэндийн төвийн хяналтад авсан байна. 18 сартай 2 хүүхдэд хөдөлгөөний хоцрогдол илэрч хөдөлгөөн засал эмчилгээнд хамруулсан, 9 сартай 20 хүүхэд, 18	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт тавьж ажиллах.	сартай 2 хүүхдэд суурь эмгэг илэрсэн бөгөөд рахит-7, цус багадалт-7, хоол тэжээлийн дутагдал-8 хүүхдэд илэрсэн. Дээрх хүүхдүүдээс шинжилгээ авч эмчилгээнд хамруулан, Д аминдэм, төмрийн бэлдмэл, бичил тэжээлийн холимог өгч эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө мэдээлэл өгч хяналтад аван давтан үзлэгийг товлосон байна.		
231	XIII.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, хөгжлийн үйлчилгээг сайжруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 4.1. байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа эцэг, эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагчийн эрүүл мэндийн даатгалын болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож улсын төсвөөс төлөх боломжийг судлан саналаа шаардагдах зардлын тооцооллын хамт танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.2. Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр болон эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь заалтын хүрээнд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар нь тулгуур эрхтний бэрхшээлтэй 4 иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байна. Монгол улсын засгийн газрын 2023 оны 06 сарын 21-ний өдрийн 237 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг сард 325.0 мянган төгрөг, асаргааны тэтгэмжийн хэмжээг сард 275.0 мянган төгрөгөөр тус тус тогтоон энэ оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгож байна. Тайлант онд хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн халамжийн тэтгэвэр авч буй 744 иргэнд 2.4 тэрбум, асаргааны тэтгэмж авч буй 1094 иргэнд 3.3 тэрбум, амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж авч буй 1091 иргэнд 2.3 тэрбум, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж авч буй 2500 иргэнд 450.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь		

		хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийн хэмжээг 288,000 төгрөгөөр үргэлжлүүлэн олгох болон цаашид уг хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт; 4.3. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд шаардлагатай хүний нөөцийн судалгааг хийж, дутагдалтай байгаа мэргэжилтнийг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар бэлтгэх, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.4. хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтний урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийг хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих чиглэлийн богино хугацааны сургалтад хамруулж, энэ чиглэлээр хөдөлмөр эрхлэх, цаашид мэргэжил эзэмшихэд нь			
--	--	--	--	--	--

		холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.6. хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийг үнэлэх Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.7. эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчгүй, байнгын асаргаа шаардлагатай сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн асрамжийн газрыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байгуулах асуудлыг судалж, шаардагдах санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.8. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн эрүүл мэнд, сэргээн заслын цогц тусламж, үйлчилгээг өргөжүүлж, мэргэжил, арга зүй, хүний нөөц, эм хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр,			
--	--	---	--	--	--

		нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.9. харьяалах нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн болон нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт, 4.10. бага орлоготой, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй өрхийн орон сууцны хангамж, нөхцөлийг судлан сайжруулах шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.			
117	232	2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2022-06-22 Дугаар 2022_34 XII.10.Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа геологийн судалгааны ажлын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгав: 1. Геологийн салбарыг тэргүүн ээлжид хөгжүүлэх стратегийн	Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр энэ онд хийгдсэн геологи, судалгааны ажил байхгүй. Хувийн хэвшлийн хөрөнгөөр энэ онд Нон феррос майнинг монголиа, Эвт дэлгэр ханга, Си Эй Ай Эл, Ургах шигтгээ, Имперо майнинг, Баян хөх толгой ХХК-иуд эрэл хайгуулын үйл ажиллагааг Нарийнтээл, Хайрхандулаан, Тарагт сумдын нутагт явуулсан бөгөөд Тарагт сумаас бусад сумд байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг батлаж ажилласан байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		бодлогыг баримталж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг төрийн удирдлагаар хангаж хот, суурин газар, бүс нутгийн хэмжээнд геоэкологи, газрын доорх ус, газар хөдлөл, хөрсний гулсалтын геологи орчинг тодорхойлох, эрдэс баялгийн салбарт дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах тааламжтай орчинг бүрдүүлэх, олборлох салбарыг ашигт малтмалын найдвартай нөөцөөр хангах зорилгоор улсын төсвийн санхүүжилтээр өөрийн аймгийн нутаг дэвсгэрт гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх; 2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу тухайн судалгааны ажлын үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах; 3. Аймаг, сумын Засаг даргын тамгын газраас төсөл хэрэгжүүлэгч тухайн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтарч улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа судалгааны ажлын зорилго, үр дүнгийн талаар орон нутгийн иргэдэд таниулах, сурталчлах арга хэмжээг жил тутам зохион байгуулж байх.			
118	233	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42 ХҮ.3. Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ,	Эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 52600 иргэн буюу нийт хүн амын 45.5 хувийг хамрууллаа. Хүйсээр нь авч үзвэл 45.6 хувь эрэгтэй, 54.3 хувь нь эмэгтэй байна. Илрүүлэг үзлэгт хамрагдсан 18-60 насны иргэдэд ходоод, бөөр, шээсний замын үрэвсэл, улаан хоолойн сөөргөө өвчин, 61-ээс дээш насныханд ходоод, бамбай булчирхайн үрэвсэл, даралт ихсэх өвчин зонхилон илэрч байна. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв,	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийг дэмжих төв болон Чинмэнд хувийн хэвшлийн эмнэлэгт эрт илрүүлэгт хамрагдсан 6090 хүнээс 17.6 хувь нь эрүүл, 82.4 хувь нь ямар нэгэн өвчлөлтэй бөгөөд 1 хүн дундажаар 2-3 өвчтэй байгаа нь хүн амын дунд өвчлөл өндөр байгааг харуулж байна. Дурангийн шинжилгээгээр 1471, хэт авиан шинжилгээгээр 3491 эмгэг өөрчлөлтийг тус тус илрүүлж, онош баталгаажуулах шинжилгээ, нарийн мэргэжлийн эмчид илгээж, эмчилгээ, хяналтыг шийдвэрлүүлсэн. Иммунологийн шинжилгээгээр хепатитийн В,С вирусийн халдварын 468, бэлгийн замаар дамжих халдварын 101 тохиолдлыг илрүүлж, онош баталгаажуулах арга хэмжээг авч, нарийн мэргэжлийн эмчийн хяналт, эмчилгээнд хамрууллаа.		
119	234	2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54 Х.12.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга	Салбарын 44 цэцэрлэг, 32 сургуулийн 120 нэгж талбар бүхий газар эзэмших эрхийг Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 182 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тогтоолын дагуу үнэлж 5,818.848.860 төгрөгөөр бүртгэлд тусгасан байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.			
120	235	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	“И-Монгол академи” УТҮГ болон аймгийн Засаг даргын Тамгын газраас энэ онд 6 удаагийн цахим сургалтыг аймаг, сумын төрийн байгууллагын удирдлага, архив, бичиг хэргийн ажилтнуудад зохион байгуулж, албан бичиг солилцооны дундын систем “DocX”-д холбох, ашиглах талаарх мэдээллийг өгч ажилласан. Тус сургалтуудад давхардсан тоогоор нийт 260 гаруй төрийн албан хаагчид хамрагдсан. Тайлант хугацаанд албан бичиг солилцооны дундын систем (DocX)-д төрийн 43 байгууллага холбогдож, үйл ажиллагаандаа ашиглаж, тус системээр албан бичиг солилцож хэвшээд байна. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллага, сумын Засаг дарга нарт үүрэг чиглэл өгч, арга зүйгээр тогтмол ханган ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
121	236	2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл 2023-01-18 Дугаар 2023_4 VIII.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион	Аймгийн Засаг даргын захирамжаар нийт 7 авто машиныг шаардлагатай байгууллагуудад балансаас балансад шилжүүлсэн. Үүнд: Орон нутгийн өмчийн газрын балансад бүртгэлтэй 2 тээврийн хэрэгслийг Зэвсэгт хүчний 256 дугаар анги, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, Нарийнтээл сумын Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй Toyota prius маркийн тээврийн хэрэгслийг аймгийн Гэр бүл хүний хөгжлийн төвд, Бат-Өлзий сумын Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй Toyota Probox маркийн тээврийн хэрэгслийг Дотоодын цэргийн 833 дугаар тусгай салбарт, Тарагт сумын Эрүүл мэндийн төвийн	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	балансад бүртгэлтэй фургон маркийн тээврийн хэрэгслийг Орон нутгийн өмчит “Хархорин -Ус суваг ХХК-д, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй Тоёота кровн маркийн тээврийн хэрэгслийг Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газарт, Хархорин сумын Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй SUZUKI JIMNY маркийн автомашиныг Гучин-Ус сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тус тус шилжүүлж, хүлээлгэн өгсөн. Дуудлага худалдаагаар нийт 15 тээврийн хэрэгсэл худалдагдсанаас 9 тээврийн хэрэгслийн үнэ хуулийн хугацаанд төлөгдөж, хөрөнгө худалдсаны орлого дансанд 30.2 сая төгрөг төвлөрүүлсэн. 2 ба түүнээс дээш удаагийн дуудлага худалдаагаар худалдагдаагүй нийт 15 тээврийн хэрэгслийг акталж данснаас хасах, 3 тээврийн хэрэгслийг хоёрдогч түүхий эд болгон худалдахаар шийдвэрлэсэн.		
122	237	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6 XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	Төрийн байгууллагууд өөрсдийн нөөц боломжоор болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн 2 судалгаа, түүний тайлан үр дүнг Үндэсний судалгааны нэгдсэн платформ болох https://sudalgaa.gov.mn/ -д байршуулав. Үндэсний судалгааны нэгдсэн платформд Баянгол омгийн хонь, тээлийн улаан ямаа, монголын хоолойн тэмээн судалгаа, Өвөрхангай аймгийн төрийн алба хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгааг тус тус байршуулсан. Тайлант хугацаанд 1650 гаруй хандалт авч, судалгаатай холбоотой санал хүсэлт иргэдээс ирүүлээгүй байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

123	238	2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2023-03-01 Дугаар 2023_10 XVI.4.2. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Нарийнтээл, Хайрхандулаан, Баруунбаян-Улаан, Сант, Богд, Баянгол 6 сумын 6 голомтод 44 өрхийн 503 хонь, 527 ямаа, нийт 1030 толгой мал бог малын мялзан өвчнөөр өвчилсөн. Өвчин гарсан сумдад аймгийн Засаг даргын захирамжаар хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоож, хэрэгжүүлж ажилласан. Энэ үеэр сумын онцгой комиссыг хуралдуулж, үүрэгжүүлэн, пост эргүүлийг гаргаж, хяналтыг эрчимжүүлж, ажиллан дэгдэлтийг намжаасан. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх масс дархлаажуулалтад 4060500 толгой мал хамрагдахаас 4045641 толгой мал хамрагдаж 99.6 хувийн гүйцэтгэлтэй, шүлхийн өвчнөөс урьдчилан сэргийлэх үхэр, гахайн сүргийн масс дархлаажуулалтад 302348 толгой мал амьтан хамрагдаж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
124	239	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11 XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний дагуу салбар хорооны 2024 оны төлөвлөгөөг батлуулж, сум, агентлаг, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жендэрийн үндэсний хорооноос жил бүр үндэсний хэмжээнд зохион байгуулдаг “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ” аянд 9 сум, 12 байгууллага идэвхтэй оролцож, аяны хүрээнд дээрх сум, байгууллагууд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж, иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүллээ. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, шийдвэр, тэдгээрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд анхаарч, сургалт мэдээллийн ажлыг тогтмол зохион байгуулж байна. Энэ оны жилийн эцсийн байдлаар 9 сум, 16 байгууллагын 320 гаруй ажилтан албан хаагч, иргэдэд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь, ажлын байрны дарамт ба ажлын байран дахь бэлгийн дарамт, жендэрийн мэдрэмжтэй манлайлал зэрэг сэдвээр сургалт	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		нөлөөллийн ажил зохион байгуулаад байна. Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аяны хүрээнд сумдын салбар зөвлөлүүдийг арга зүйгээр ханган тогтмол мэдээллийг түгээж энэ хүрээнд нийт 15 сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж 135 байгууллагын 2850 ажилтан албан хаагч, Политехник коллежийн болон Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн 540 сурагчдыг хамрууллаа. Мөн “Охид эмэгтэйчүүд хаана ч аюулгүй -Шалтаг бүү тооч” аяны уриаг гудамж талбайн самбар болон 64 эрүүл мэндийн байгууллага, сургуулиудад байршуулж, олон нийтэд сурталчиллаа. Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулснаар 373 эмэгтэй хамрагдаж, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 32 эмэгтэйг эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг, шинжилгээнд хамруулж, нөхөн үржихүйн эрхтний үрэвсэл, өөрчлөлтэй хүмүүсийг эмчлэн эрүүлжүүлсэн.		
240	XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт тус бүр 2 улаан хоолой, ходоодны уян дуран улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэн хэвийн ажиллаж байна. Энэ оны 11 дүгээр сарын байдлаар 3868 иргэн улаан хоолой, ходоодны дурангийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна. Дурангийн шинжилгээгээр 1471 эмгэг өөрчлөлтийг илрүүлж, онош баталгаажуулах шинжилгээ, нарийн мэргэжлийн эмчид илгээж, эмчилгээ, хяналтыг шийдвэрлүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

125	241	2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар тэмдэглэл 2023-03-22 Дугаар 2023_13 IV.2. Нийслэл Улаанбаатар хот, аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, чөлөөт бүсийн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтэд газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан хяналт тавих, газар олголтыг нээлттэй, ил тод болгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 137 дугаар “Монгол Улсын иргэнд 2024 онд газар өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” тогтоолоор манай аймгийн хэмжээнд нийт 727 иргэнд 38.27 га газрыг өмчлүүлэхээр тусгагдсан. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, Хот байгуулалтын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Авто замын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалт зөрчигдсөн, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайтай давхцуулсан зэрэг асуудлаар төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбараас 3530 нэгж талбар бүхий 199.49 га газрын өмчлүүлэх боломжгүй болсон. Энэ онд аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт иргэнд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гараагүй.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
126	242	2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17	Хүний эрхийн Үндэсний Комиссоос аймгийн Засаг даргад тайлант онд 2 зөвлөмж, 1 шаардлага ирүүлсэн бөгөөд зөвлөмж, шаардлагын хүрээнд тодорхой ажил зохион байгуулан, хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Үүнд:	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов	1.Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг тус аймагт 2024 оны 04 дүгээр сард “Хяналт шалгалт, зөвлөн туслан, сургалт мэдээллийн чиглэл”-ээр тус тус ажилласан бөгөөд хяналт шалгалтын хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссын гишүүний 2024 оны 07/24 дүгээр зөвлөмж ирүүлсэн. Зөвлөмжид дурдсан нийт 10 асуудлын хүрээнд салбар байгууллагуудад хамаарах болон аймгийн хэмжээнд анхаарах асуудлаар тус тус сум, агентлагуудад албан бичиг хүргүүлэн, мөн тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан. Зөвлөмж нь богино хугацаанд хэрэгжих 1, дунд хугацаанд хэрэгжих 5, урт хугацаанд хэрэгжих 4, нийт 10 зөвлөмжөөс богино хугацаанд шийдвэрлэх 1 асуудлыг бүрэн хэрэгжүүлж, дунд болон урт хугацаанд шийдвэрлэгдэх 9 асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхээр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаад байна. 2.Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын гишүүний 2024 оны 02/28 дугаар “Хурдан морь унаач хүүхэд”-ийн асуудлаар ирүүлсэн 11 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн. 3.Хүний эрхийн Үндэсний Комиссоос энэ онд тус аймгийн Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан, 2024 оны 07/21 дүгээр өдрийн албан бичгээр нийт 9 асуудлын хүрээнд албан шаардлага ирүүлсэн. Уг шаардлагын хүрээнд богино болон урт хугацаанд шийдвэрлэх, эрчимжүүлэх шаардлагатай ажлуудыг тодорхойлон, богино хугацаанд хийгдэх 5 заалтыг бүрэн хэрэгжүүлж, дунд болон урт хугацаанд хэрэгжих, хөрөнгө мөнгө шаардсан 4 ажлыг ирэх жилийн буюу 2025 оны улс болон орон нутгийн төсөв, бодлогын баримт бичгүүдэд тусгуулж, шаардлагатай ажлуудыг	
--	--	---	---	--

			хийсэн бөгөөд уг шаардлагыг бүрэн буюу 100 хувь биелүүлж, тус тус зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.		
127	243	2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2023-04-26 Дугаар 2023_18 XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Монголын Улаан загалмайн нийгэмлэгээс хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Америкийн Нэгдсэн Улсын Хөгжлийн агентлагаас аймгийн хэмжээнд объектын болон ой хээрийн түймрийн хамгийн өндөр эрсдэлт үзүүлэлттэй Бат-Өлзий, Богд сумдын гал унтраах сайн дурын хэсгийг тус бүр нь 20.0 сая төгрөгийн үнэ бүхий багаж, техник хэрэгслийн тусламж үзүүлж, бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлээд байна. Дээрх 2 сум нь Орон нутгийн телевизүүдээр ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх шторкийг олон удаагийн давтамжтай нэвтрүүлж, аймгийн Онцгой байдлын газрын фэйсбүүк пэйж хуудаст сэрэмжлүүлэг, анхааруулах мэдээлэл нийт 25 удаа байршуулж, 4520 хүний хандалт авч ажилласан байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
128	244	2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2023-05-17 Дугаар 2023_21 XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Орон нутагт хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн хэрэгжилтийг тооцох шалгуур үзүүлэлтийг бодлогын баримт бичиг тус бүрээр гаргаж, хэрэгжилт үр дүнг үнэлэн ажилласан. Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг нийт 91 шалгуур үзүүлэлтээр, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг нийт 81 шалгуур үзүүлэлтээр тус тус үр дүнг тооцон жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажилласан бөгөөд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг үзүүлэлтийг нийт 45 үзүүлэлтийн дагуу үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тайлагнаж ажилласан. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			чиглүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрэх үр дүнг 18 чиглэлээр, хөтөлбөрийн хүрэх үр дүнг 67 чиглэлээр тодорхойлж энэ хүрээнд 275 үйл ажиллагааг хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллахаар төлөвлөн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэн баталлаа.		
129	245	2023 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2023-05-24 Дугаар 2023_22 XXI.5.3. Гамшгийн улмаас хорогдсон малын сэг, зэм булшлах, устгах ажлыг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн “Бог малын гоц халдварт цэцэг өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 03 албан даалгавар, аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай” А/193 дугаар захирамж, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн “Урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулах тухай” А/17 дугаар тушаалаар малын сэг зэм устгал болон гоц халдварт өвчний халдваргүйтгэлд 621 кг бодис, 315 ш хувцсыг хуваарийн дагуу олгосон. Энэ он гарсаар нийт сумдад хуваарийн дагуу 3 төрлийн 899 кг бодис, 650 ш халдвар хамгааллын хувцас нийт 45.5 сая төгрөгийн бодис, хувцас олгоод байна. Сэг зэм цуглуулж, булж, устгах арга хэмжээнд нийтдээ 37 Малын эмч, сумын ЗДТГ-аас 195, сумаас ажилласан гэрээт ажилтан болон малчин 298, нийт 530 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хамтран тэмээ 19, адуу 3925, үхэр 3150, хонь 40228, ямаа 35485, нийт 82807 мал, 114 амьтанг булж, устгах, халдваргүйтгэх ажлыг зохион байгуулж, ажлын гүйцэтгэл 97.3 хувьтай хийгдсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
130	246	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	Төрийн бодлого шийдвэр, түүний хэрэгжилтийн хүрээнд зохион байгуулагдаж буй үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэж uvurkhangai.gov.mn сайт, Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар пэйж хуудас гэсэн 2	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		XXII.2. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.	сувгийг хөтөлж, баяжилт хийн ажиллав. Вэб сайтад энэ оны 11 дүгээр сарын байдлаар цаг үеийн 309 мэдээ, Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар пэйж хуудсанд 564 мэдээг нийтэлж, олон нийтийг мэдээллээр ханган ажилласан. Ил тод байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд www.uvurkhangai.gov.mn сайтад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заагдсан 68 үзүүлэлтийн дагуу мэдээллийг шинэчлэн, баяжилтыг хийж байна. Жилийн эцсийн байдлаар 105 мэдээлэл шинэчлэгдэж нийтлэгдсэн. Вэб сайтад хандаж мэдээлэл авсан хүний тоо 14068, пэйж хуудсанд хандаж мэдээлэл авагчдын тоо 419814 тус тус бүртгэгдсэн байна. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу мэдээлэл шинэчлэн гаргах хуваарийг хэлтсүүдийн чиг үүргийн хүрээнд хуваарилан шаардлагатай мэдээллүүдийг шинэчлэн байршуулж ажиллав.		
131	247	2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25 XIII.5.2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон	Хугацаанд нь хэрэгжүүлж биелэлтийг холбогдох газар хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Бүрэн хэрэгжсэн тул хняалтаас	

		нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт,		хасуулах саналтай.)	
248	XIII.5.3. Зөвлөлдөх уулзалтад оролцогчдын манлайллаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг сурталчлан таниулах, санал авах хурлыг баг, хороо бүрд зохион байгуулж, хурлуудаас гарсан бүтээлч санал, санаачилгыг нэгтгэн шалгаруулж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Хугацаанд нь хэрэгжүүлж биелэлтийг холбогдох газар хүргүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Бүрэн хэрэгжсэн тул хняалтаас хасуулах саналтай.)		
249	XIII.10. “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийн хүрээнд “Цахим жишиг аймаг” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрт Өвөрхангай аймаг хамрагдан улсын төсвийн 1.9 тэрбум төгрөгөөр аймаг, орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн аж, ахуй нэгжид чиглэсэн нэгдсэн систем нэвтрүүлэх, түүнд шаардагдах багц тоног төхөөрөмж худалдан авах ажил хийгдсэн. Дээрх ажлын хүрээнд өгөгдөл солилцооны үндсэн систем, иргэдийн гар утасны аппликэйшн, байгууллагын удирдлагын систем, аж ахуйн нэгжийн систем, төлбөр тооцооны систем, шуурхай удирдлага, хяналтын систем, орон зайн мэдээллийн систем, удирдлагын мониторингийн дашбоард систем, тээврийн хэрэгслийн нэвтрэлтийн системийн хөгжүүлэлт тус тус хийгдсэн. Ингэснээр иргэд гар утаснаасаа төрөөс үзүүлж буй үйлчилгээ, мэдээ, мэдээлэлтэй танилцах, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж, бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж өөрийн явуулж буй үйл ажиллагааны талаарх	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

			мэдээллээ орон зай, цаг хугацаа үл хамааран сурталчлах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг түргэн шуурхай, ил тод явуулах зэрэг олон давуу талууд бий болж байна. Системүүдийг иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудад сурталчилан таниулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. Мөн 2024 оныг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтот жил болгон зарлаж, зорилтот жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг 89.2 хувьтайгаар дүгнэгдсэн.		
132	250	2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2023-09-26 Дугаар 2023_39 XVIII.8.1.Ургац хураалтын ажлыг шуурхай зохион байгуулах, ургацыг цаг агаарын гамшигт үзэгдэл болон малаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг тариалан бүхий аймгийн Засаг дарга нарт;	Ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд зохион байгуулж, тариалангийн бүс нутаг болох Хархорин суманд ургацын штабыг тогтмол ажиллуулж, техникийн бэлэн байдал болон ажиллах хүн хүчний судалгааг гаргаж, холбогдох газруудад зуучилсан. Тариалангийн талбайг малаас хамгаалах, ургац хураалтын ажил дуусах хүртэл тариалангийн талбайн ойр орчимд малчин, мал бүхий этгээдийг суурьшуулахгүй байх, малыг байнгын хариулгатай байлгахаар энэ оны 5 дугаар сарын 1-нээс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд тариалангийн талбайг бүрэн чөлөөлөх албан мэдэгдэл хүргүүлж, чөлөөлсөн эсэхэд байнгын хяналт тавин ажилласан. Энэ онд ургац хураалтад ажиллах хүн хүч техникийн бэлтгэл, бэлэн байдлын судалгаа гаргахад Хархорин сумаас 7 аж ахуйн нэгж 50 цэрэг, 30 оюутан ажиллуулах захиалга ирүүлснийг холбогдох газруудад холбон зуучилж ажилласан. Энэ оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 08-00-05/008/08 дугаар бүхий Салбарын хяналтын газраас Улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг хүргүүлж, ургацыг хаягдал хорогдол багатай хураах, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч ажиллав. Үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч өөрийн эзэмшлийн талбай, ургацаа бусдын	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			халдлага болон малаас хамгаалсан байдлыг шалгаж үзэхэд 18651 га талбайд тариалалт хийснээс 99.4 хувь нь ямар нэг байдлаар хашаажуулан ургацыг бусдын халдлагаас хамгаалсан тариалалтыг хийжээ. ХХААК ТӨХХК-ийн Хархорин салбарт үрийн буудай нөөцлөөгүй. Улсын нөөцийн Хархорин салбарт тарих үрийн стандарт шаардлага хангасан улсын байцаагчийн дүгнэлт гарсан улаан буудайн үрийг нөөцөлсөн. Хөдөө аж ахуйн инженер, агрономичтой эсэхийг шалгахад үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч 22 аж ахуйн нэгжид 8 агрономич, инженертэй, 19 сумын газар тариалан хариуцсан мэргэжилтнээс 4 мэргэжлийн агрономич ажиллаж байгаа ба аймгийн хэмжээнд мэргэжлийн боловсон хүчний хангамж 25.0 хувьтай байна.		
251	XVIII.1.1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авахыг холбогдох Засгийн газрын гишүүд, барилга байгууламжийн захиалагч нарт даалгав: 1.2024 онд шилжэн хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг эрчимжүүлж, гэрээт ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлийг хянаж, үнийн өсөлтийг бодитойгоор тооцож, дүгнэхийг захиалагч нарт;	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2024 он хүртэл шилжин хэрэгжиж буй Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор (Өвөрхангай, Хархорин сум), Соёлын төвийн барилга (Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум), Эрдэнэзуу музейн “Аялал жуулчлалын гудамж” төсөл (Өвөрхангай, Хархорин сум), Засаг даргын Тамгын газрын барилга (Өвөрхангай, Тарагт сум) эдгээр ажлуудын гүйцэтгэлд хяналт тавин үнийн өсөлтийг болон төсөв тооцоог мэргэжлийн байгуулагатай хамтран тооцож, ажлыг эрчимжүүлэх талаар зохицуулалт хийн ажиллаж байна. Мөн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 05 дугаар сарын 21-ний 95 дугаар тушаалаар барилга байгууламжийн төсвийн тооцоо хийхэд хэрэглэгдэх “Барилгын ажилтны тарифт цалингийн жишиг”-ийг шинэчилсэн баталсаны дагуу энэ онд Тарагт сумын Засаг даргын Тамгын газрын барилга, Хархорин сумын Аврах гал унтраах ангийн барилга, Баянгол сумын Соёлын төвийн барилга байгууламжийн төсөвт өртгийн цалингийн зардалд магадлал хийлгэхээр холбогдох материалыг	Хэрэгжих шатанд 70.0 хувь		

			“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т хүргүүлээд байна.		
252	XVIII.1.2. Хуульд заасан хугацаанд хэрэгжээгүй, 2023 онд ажлын гүйцэтгэл дутуу барилга байгууламжийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хүрээнд гүйцэтгэлийг 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дүгнэж, зайлшгүй шаардлагатай бол гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг захиалагч нарт	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй Арвайхээр сумын 50 ортой хүүхдийн эмнэлгийн барилга, Хархорин сумын 100 ортой нэгдсэн эмнэлгийн барилга, Аврах гал унтраах ангийн барилга, Баруунбаян-Улаан сумын Соёлын төвийн барилга, Тарагт сумын Засаг даргын Тамгын газрын барилга, Хужирт сумын Эрүүл мэндийн төвийн барилга, орон нутгийн төсвөөр хэрэгжиж буй Хужирт сумын төрийн албан хаагчдын орон сууцны барилгуудыг угсралтын ажлыг гүйцэтгэгч компаниуд бүрэн ашиглалтад хүлээлгэн өгөөгүй удаашралтай, хугацаандаа ороогүй байна.	Хэрэгжилт хангалтгүй 30.0 хувь		
253	XVIII.1.4. Зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас хуулиар тогтоосон хугацаанд ашиглалтад оруулаагүй зохиогч, гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчингүй болгох арга хэмжээ авахыг тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны төв байгууллагуудад, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийг хар жагсаалтад оруулахыг Сангийн сайд Б.Жавхланд, холбогдох мэдээллийг Сангийн яаманд хүргүүлж ажиллахыг захиалагч нарт	Зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас хуулиар тогтоосон хугацаанд ашиглалтад оруулаагүй зохиогч, гүйцэтгэгч байхгүй бөгөөд тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчингүй болгох талаарх санал хүргүүлээгүй.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		
254	XVIII.1.10. Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн барилга, байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	Улсын төсвөөр энэ онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд зураг төсөл, инженерийн газрын асуудал, дэд бүтэц нь шийдэгдсэн нийт 26 төсөл арга хэмжээ байна. Тус төсөл арга хэмжээнүүдийн саналыг 2024 онд улсын төсвөөр хэрэгжүүлэх жагсаалтад санал хүргүүлэн батуулсан. 2025 онд Өвөрхангай аймагт хэрэгжүүлэх шаардлагатай барилга байгууламжийн саналыг улсын төсөвт тусгахаар санал хүргүүлсэн	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

			боловч 2025 оны улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдаагүй. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баруунбаян-Улаан болон Өлзийт суманд баригдах төрийн албан хаагчдын орон сууцны барилгын газрын асуудлыг шийдвэрлээд байна.		
133	255	2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 40 дүгээр тэмдэглэл 2023-10-04 Дугаар 2023_40 1.6. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу тухайн орон нутгийн 2024 оны төсөвт тусган хэрэгжүүлэх доор дурдсан төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс 2024 онд хэрэгжүүлэхийг холбогдох аймгийн Засаг дарга нарт; 1.6.1.Баянхонгор аймгийн 6 дугаар цэцэрлэгийн барилгын их засвар (Баянхонгор сум), Хүүхдийн зуслангийн их засвар; 1.6.2.Дархан-Уул аймгийн Цэцэрлэгийн засвар; 1.6.3.Дорноговь аймгийн 1 дүгээр сургуулийн барилгын засвар; 1.6.4.Орхон аймгийн Сургуулийн барилгын их засвар (Орхон, Баян-Өндөр сум, 14 дүгээр сургууль); 1.6.5.Өвөрхангай аймгийн Багшийн хөгжлийн ордны барилгын санхүүжилтийн 50 хувь (Өвөрхангай, Арвайхээр сум), Халамж үйлчилгээний барилга (Арвайхээр сум); 1.6.6.Өмнөговь аймгийн Ахмадын сувиллын барилга, 44 ор (Өмнөговь,	Арвайхээр суманд баригдах Багшийн хөгжлийн ордон, Халамж үйлчилгээний барилгын зураг төсөл боловсруулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийн 50.0 хувийг аймгийн 2024 оны орон нутгийн хөгжлийн санд тусган баталсан. Зураг төсөв боловсруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн 50.0 хувь нь улсын төсөвт тусгагдаагүй байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		Даланзадгад сум); 1.6.7.Увс аймгийн Улаангом сумын арын 4 замын уулзвараас тойрог цагаан хаалга хүртэлх авто замын шинэчлэл, гэрэлтүүлэг; 1.6.8.Ховд аймгийн Цэцэрлэгийн барилгын их засвар (Ховд, Жаргалант сум, 2, 3, 4 дүгээр цэцэрлэг).			
256	2.6. Ипотекийн зээлийг орон нутаг руу түлхүү чиглүүлэх, шилжин суурьшиж байгаа нарийн мэргэжлийн ажилтныг орон сууцаар хангах асуудлыг судлан үзэж, арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, аймгийн Засаг дарга нарт;	Тайлант онд 326 иргэнд 33.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг арилжааны 4 банкаар олгосон. Үүнээс 3 хувийн хүүтэй 13.9 тэрбум төгрөгийн зээлийг 140 иргэнд олгосон. Эх үүсвэрийн зөвшөөрөл хүссэн 212 иргэний 22.7 тэрбум төгрөгийн зээл олгогдохоор судлагдаж байна. Мөн 9 аж ахуйн нэгж байгууллагад 1.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Эх үүсвэрээс шалтгаалан ипотекийн зээл түр зогссон байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		
257	2.22. Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг мал эмнэлгийн ажил, үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэх асуудлыг судалж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засагдарга нарт;	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын норматив Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/116, А/418 дугаар тушаалаар батлагдан хэрэгжиж байна. "Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний жишиг үнэлгээний жагсаалт батлах тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 10/02 дугаар тогтоолыг шинэчлэн батлах тухай төслийг аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 08 дугаар хурлаар хэлэлцэж, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх Мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг шинэчлэх асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.	Хэрэгжих шатанд 70.0 хувь		
258	2.28. Аймаг, сумын баяр наадам тэмдэглэх зардлыг нэмэгдүүлэх боломжийг судлан, саналаа холбогдох төрийн захиргааны төв байгууллагад	Засгийн газрын 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор баяр наадмын зардал аймагт 10.0 сая төгрөг, суманд 5.0 сая төгрөгөөр батлагдсан. Энэ нь одоогийн нөхцөл байдалд	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

		танилцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	тохирохгүй байгаа тул аймгийн баяр наадмын зардлыг 100.0 сая, сумын баяр наадмын зардлыг 30.0 сая төгрөг байхаар доод хэмжээг нь тус тус тооцож, Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газарт цахимаар хүргүүлсэн.		
	259	2.62. Хүүхдийн зуслан барих газрыг олгох, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийг дэмжих, өмгөөллийн үйлчилгээний өрөөг стандартын дагуу тохижуулах, сууц өмчлөгчдийн холбооны ажилчдын цалингийн асуудлыг судалж шийдвэрлэхийг Өвөрхангай аймгийн Засаг даргын орлогч И.Доржсүрэнд;	Хужирт суманд 2 байршлын 10.0 га, Есөнзүйл сумын 1 байршилд 0.4 га, Бат-Өлзий суманд 1 байршилд хүүхдийн зуслан барихаар төлөвлөж байна. Тус сумдын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь дууссан бөгөөд 2025 онд орон нутгийн төсвөөс сумдын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хийлгэхээр хөрөнгийг шийдвэрлээд байна. Хүүхдийн зуслан барих ажлын даалгаврыг батлуулан саналыг Гэр бүл, хүүхэд хөгжил, хамгааллын ерөнхий газарт хүргүүлээд байна. Есөнзүйл суманд хөдөлмөр зуслан байгуулах газрын асуудал шийдэгдэж аймгийн орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
	260	2.94. Энэ тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар (Б.Баасандорж)-т, хэрэгжилтийн явц, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим системд оруулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ.	Засгийн газрын хуралдааны 40 дүгээр тэмдэглэлээр Өвөрхангай аймагт хэрэгжүүлэхээр үүрэг болгосон 14 заалтыг дотоод хяналтад авч, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосон 6 заалтын биелэлтийг сар бүр тайлагнан ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
134	261	2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 41 дүгээр тэмдэглэл 2023-10-11 Дугаар 2023_41 XVII.1. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог	Аймгийн хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг улирал бүр тогтмол зохион байгуулж хэвшсэн бөгөөд 2024 онд 640.2 тн хог хаягдлыг цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргээд байна. Арвайхээр, Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Баян-Өндөр, Уянга, Богд, Хайрхандулаан, Гучин-Ус, Төгрөг, Өлзийт,	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Есөнзүйл, Сант, Зүүнбаян-Улаан, Баруунбаян-Улаан, Тарагт сумдууд төвлөрсөн хогийн цэгээ хашаажуулж, талбайн хэмжээг багасгах ажлыг зохион байгуулан ажилласан. Мөн Франц улсын “Тинк капитал оф Монголиа” ХХК-аас Хархорин суманд органик хог хаягдал буюу үхрийн баас, хүнсний хог хаягдлыг биотехнологийн аргаар боловсруулж, метан хий гарган өрхийн халаалтыг шийдвэрлэх бөгөөд туршилтын ажил амжилттай хэрэгжиж байна. Бүгд найрамдах Солонгос улсын “JH engineering and construction” компани хог хаягдлыг шатаах, байгаль орчинд ээлтэй, хорт утаа ялгаруулдаггүй зуух үйлдвэрлэдэг бөгөөд Арвайхээр суманд шатаах зуух ашиглах эдийн засгийн тооцооллыг судлах ажлууд хийгдэж байна.		
135	262	2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 дугаар тэмдэглэл 2023-11-08 Дугаар 2023_45 XI.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд чиглэл өгч ажиллаж байна. Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, хэрэгжилт бүрэн хангагдсан, тогтмолжсон шийдвэрийг хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтаас хасуулах саналыг тухай бүр өгч ажиллаж байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
136	263	2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэл 2023-11-29 Дугаар 2023_48 XIX.2. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй	Жил бүр Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлангийн дүгнэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, хүргүүлж байна. Аймгийн Засаг даргын хэм хэмжээ тогтоосон нийт худалдаа үйлчилгээний газруудын цагийн хуваарийг шинэчлэн баталж	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлангийн дүгнэлтийн хүрээнд ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн шийдвэрүүдийг хүчингүй болгох арга хэмжээ авч Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх, хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй 81 шийдвэрийг зохих журмын дагуу бүртгүүлэх арга хэмжээг тус тус 2024 оны 1 дүгээр улиралд багтаан авахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав	мөрдүүлэх тухай, 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/724 дүгээр “Худалдаа үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг шинэчлэн батлах тухай” буюу архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх худалдаа үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарийг шинэчлэн тогтоосон захирамж, 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/776 дугаар “Худалдаа, үйлчилгээний газруудад авах арга хэмжээний тухай”, Арвайхээр сумын Засаг даргын 2013 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/46 дугаар “Худалдаа, үйлчилгээний төвүүд болон захын ажиллах цагийн хуваарь, амрах өдрийг батлах тухай” захирамж тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд уг захирамжууд хуулийн үйлчлэл хангаж байгаа тул цаашид хэвээр үлдээж үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байна.		
137	264	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл 2023-12-06 Дугаар 2023_49 XIII.2. Зарим аймагт өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт үүрэг болгов.”	Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/118 дугаар захирамжаар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай арга хэмжээг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь (Цаг үеийн шинжтэй бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.)	
	265	XVI.5.2. Нөөцийн махны бэлтгэх, зарцуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Төв суурин газрын хүн амын махны үнийг тогтворжуулах, махны нөөц буурах үед үүсэх үнийн зохиомол хөөрөгдлөөс хамгаалах, улирлын нөөц бүрдүүлж, орон нутгийн төсвөөс 150.0 сая төгрөгийн	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	санхүүжилтээр махны нөөц бэлтгэх тендер зарлан, Арвайхээр сумын “Итгэлт хүнс баялаг” ХХК шалгарч, 20.0 тн хонины махны нөөц бүрдүүлсэн. Төв суурин газрын хүн амын махны улирлын нөөц бүрдүүлэлтэд Арвайхээр сумын ЗДТГ болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран чанар, аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан. Нөөцийн махыг Арвайхээр сумын баг тус бүрийн 13 хүнсний дэлгүүрүүдээр дамжуулан борлуулсан.	(Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай.)	
138	266	2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл 2023-12-20 Дугаар 2023_51 XXV.4.3. Орон нутгийн иргэдийн эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	Хүн амын нас, хүйс эрүүл мэндийн эрсдэлт суурилсан эрт илрүүлэгийн мэдээнд дүн шинжилгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангасан. БОЭТ, Хархорин, Чинмэнд эмнэлгүүдэд илрүүлэгт хамрагдсан хүн амын мэдээллийг тухайн хариуцсан сумдад өгдөггүй, нэгдсэн мэдээллийн дүн шинжилгээг ЭМГ-т ирүүлдэггүй, зөвхөн илрүүлэх ажил хийгдэж, Эрүүл мэндийн газар, сум, өрхийн эрүүл мэндийн төвтэй уялдаа холбоо сул байсан. Дээрх дүгнэлтээс БОЭТ, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Чинмэнд хувийн эмнэлэг мэдээ тайланг ЭМГ-т сар бүр өгөх, тухайн сард хамрагдсан хүмүүсийг нэрсээр гарган, ямар оноштой, цаашид хэрхэн эмчилгээнд хамруулах талаар сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлэх зөвлөмжийг өгч ажиллалаа. Мөн Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэгт хяналт хийж, эрт илрүүлэгт хамрагдсан хүмүүсийг бүртгэж, эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган, үр дүнг тооцох талаар зөвлөмж өгсөн.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
	267	XXV.5.2. Малчдыг отор, нүүдэл хийх боломжийг бүрдүүлэх, бэлчээрийн даац, нөөц боломжид тулгуурласан отор нүүдлийн зохицуулалтыг тухай бүр хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Архангай аймагт 6 малчны 1191 мал, Булган аймагт 20 малчин өрхийн 5076 мал, Төв аймагт 27 малчин өрхийн 14715 мал, Дорнод аймагт 8 малчин өрхийн 5141 мал, Сэлэнгэ аймагт 2 малчин өрхийн 1170 мал, Хэнтий аймагт 6 малчин өрхийн 3359 мал тус тус оторлож байна. Энэ нь урд жилүүдэд оторт явсан малчид байгаа юм. Энэ жилийн хувьд гадны аймаг	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, сумын Засаг дарга нарт даалгав	сумдад мал өвөлжүүлэхгүйгээр дотроо отор нүүдэл хийхээр бэлтгэл ажил ханган ажиллаж байна. Аймаг дундын отрын бүс нутаг Чилэнгийн бүсэд мал оруулахгүй өнжөөх бодлого барьж байгаа бөгөөд цагийн байдал хүндэрвэл 3 сумын 10000 малыг оруулах захиалга өгсөн. Хөх дэлийн отрын бүс нутагт хуучин өвөлжиж, хаварждаг 12 малчин өрхийн 10000 орчим мал өвөлжинө.		
268	XXV.3.2.5. Хог хаягдлаас үүсэж буй байгаль орчны бохирдол, доройтол нь агаар, хөрс, усны бохирдлыг ихээр үүсгэж байгаатай холбогдуулан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	“Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь 2021 онд хаягдал хуванцар дахин боловсруулах үйлдвэр барьж тогтмол үйл ажиллагаагаа явуулан хатуу хуванцрыг хайлуулан жилд 2000 гаруй хашааны шон замын хашлага, бохирын кольцо зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Усны сан бүхий газар түүний хамгаалалтын бүс орчмын газрын хог хаягдлыг Онги Таац голын сав газрын захиргаа, Зэвсэгт хүчний 256 дугаар ангитай хамтран Онги, Дайргын голын дагуух 30 га газрын 38 тн хог хаягдлыг цэвэрлэж, 2 тн дахивар хог хаягдлыг ангилж хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт хүргэн, Уянга сумын нутагт орших “Хүйсийн Найман нуур”, “Ногоон нуур” орчмын 1.3 тн хог хаягдлыг цэвэрлэх зэрэг ажлыг Онги Таац голын сав газрын захиргаатай хамтран хэрэгжүүллээ.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		
269	XXV.3.2.11.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийтийн болон амины орон сууцны бүсийг тогтоох, шинэчлэн боловсруулах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Аймгийн хэмжээнд нийт 15 сум болон аймгийн нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хугацаа дууссан байна. Тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах 700.0 сая төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар батлуулаад байна. Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаварт нийтийн болон амины орон сууцны бүсийг тусган батласан. Мөн Арвайхээр сумын 13 дугаар багийн шинэ суурьшлын бүсийн 20 га талбайд 1600 айлын нийтийн орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөг аймгийн	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь		

			иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 25/01 дүгээр тогтоолоор батлуулсан.		
	270	XVII.2.4.. Орон нутагт мах худалдан авах явуулын цэг ажиллуулах боломжийг судалж, холбогдох шийдвэрийг гарган арилжааны банкуудтай хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Хүнсний аюулгүй байдал, чанар стандартыг хангах хүрээнд ил талбайд мал, амьтны гаралтай мах, сүү цагаан идээ худалдахгүй байх, улмаар зориулалтын худалдан борлуулах цэгт нүүлгэн шилжүүлэх Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/646 дугаар захирамж гарч, Арвайхээр сумын цэцэрлэгт хүрээлэнгийн дэргэд эрүүл ахуйн шаардлага хангасан худалдааны асрыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэж, мал, амьтны гаралтай мах, сүү цагаан идээ борлуулж хэвшээд байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
139	271	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэл 2023-12-27 Дугаар 2023_52 XL.3.3. Батлагдсан төсөвт эх үүсвэрийнхээ хүрээнд мал, махны борлуулалт, худалдан авалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	Төв суурин газрын хүн амын махны үнийг тогтворжуулах, махны нөөц буурах үед үүсэх үнийн зохиомол хөөрөгдлөөс хамгаалах, улирлын нөөц бүрдүүлэх зорилгоор 2024 оны орон нутгийн төсвөөс 150.0 сая төгрөгийн санхүүжилтээр махны нөөц бэлтгэх тендер зарлан, Арвайхээр сумын “Итгэлт хүнс баялаг” ХХК шалгарч, 20.0 тн хонины махны нөөц бүрдүүлсэн.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	272	XXXX.11.4. Монгол Улсад 2024 онд зохион байгуулах олон улсын арга хэмжээний цаглабрыг гадаад сурталчлах арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Соёлын сайд Ч.Номин нарт, цаглабарт тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ болон Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.”	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гүйжөү мужийн Гуяан хотод болсон олон улсын аялал жуулчлал болон эгч дүү хотуудын уулзалтад Өвөрхангай аймгийн төлөөлөл оролцож орон нутгийн аялал жуулчлалын үйл ажиллагаа, онцлогыг танилцуулсан. Энэ үер Хужирт сумын “Хужирт Цагаан ” ХХК-ийн бүтээгдэхүүнүүдээр үзэсгэлэн гаргалаа. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин, Шанхай хотод зохион байгуулагдсан олон улсын зөвлөгөөн, сургалтад оролцож 12 улсын төлөөлөлд Монгол Улсын хөгжил дэвшил, аялал жуулчлал, соёл урлаг, нийгэм, эдийн засгийн талаар танилцуулга хийсэн.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

140	273	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл 2024-01-31 Дугаар 2024_5 12.9.2. Орон нутагт мал, мах худалдаалах зориулалтын цэг байгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Хүнсний аюулгүй байдал, чанар стандартыг хангах хүрээнд ил талбайд мал, амьтны гаралтай мах, сүү цагаан идээ худалдахгүй байх, улмаар зориулалтын худалдан борлуулах цэгт нүүлгэн шилжүүлэх Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/646 дугаар захирамж гарч, Арвайхээр сумын цэцэрлэгт хүрээлэнгийн дэргэд эрүүл ахуйн шаардлага хангасан худалдааны асрыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэж, мал, амьтны гаралтай мах, сүү цагаан идээ борлуулж хэвшээд байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
141	274	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 8 дугаар тэмдэглэл 2024-02-28 Дугаар 2024_8 22.6.2. Зудын улмаас хорогдсон малын сэг, зэм булшлах, устгах ажлыг өргөн хүрээтэй, шуурхай зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Аймгийн хэмжээнд сэг зэм устгал 96.3 хувьтай хийгдсэн. Үүнээс тэмээ 16, адуу 3747, үхэр 3000, хонь 40088, ямаа 36129, амьтан 114 нийт 83094 малын сэг зэмийг булж устгасан байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	275	22.10.3. Орон нутгийн хэмжээнд бэлтгэсэн махны чанар, аюулгүй байдалд хяналт, шалгалт хийх, стандартын шаардлага хангасан махыг төв, суурин газрын хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Төв суурин газрын хүн амын махны үнийг тогтворжуулах, махны нөөц буурах үед үүсэх үнийн зохиомол хөөрөгдлөөс хамгаалах, улирлын нөөц бүрдүүлэх зорилгоор 2025 оны орон нутгийн төсвөөс 150.0 сая төгрөгийн санхүүжилтээр 20.0 тн хонины махны нөөц бэлтгэх тендер зарлан “Түмний буян далай хоршоо” 20 тн мах бэлтгэн хадгалаад байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

142	276	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл 2024-03-27 Дугаар 2024_12 14.8. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 06 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын захирал, дарга нарт, үр дүнг нэгтгэж 2024 оны 06 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд тус тус даалгав.” (Үндэсний судалгааны нэгдсэн платформын ажлын явцын талаар)	Төрийн байгууллагууд өөрсдийн нөөц боломжоор болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн 2 судалгаа, түүний тайлан үр дүнг Үндэсний судалгааны нэгдсэн платформ болох https://sudalgaa.gov.mn/-д байршуулав. Үндэсний судалгааны нэгдсэн платформд Баянгол омгийн хонь, тээлийн улаан ямаа, монголын хоолойн тэмээн судалгаа, Өвөрхангай аймгийн төрийн алба хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгааг тус тус байршуулсан. Тайлант хугацаанд 1650 гаруй хандалт авч, судалгаатай холбоотой санал хүсэлт иргэдээс ирүүлээгүй байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
143	277	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл 2024-04-03 Дугаар 2024_13 22.6.1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар,	Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 97.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 34 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа эрх шилжин ирсэн. Үүнд: Боловсролын яамнаас 46.2 тэрбум төгрөгийн 13, Эрүүл мэндийн яамнаас 2.6 тэрбум төгрөгийн 4, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 9.2 тэрбум төгрөгийн 2, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 150.0 сая төгрөгийн 3, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас 4.2 тэрбум төгрөгийн 3, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас 18.9 тэрбум төгрөгийн 2, Сангийн яамнаас 1.3 тэрбум	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;(.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2024 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар)	төгрөгийн 1, Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 3.0 тэрбум төгрөгийн 2, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 4.3 тэрбум төгрөгийн 2, Зам, тээврийн хөгжлийн яамнаас 7.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээ тус тус эрх шилжин ирсэн байна. Эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээ Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд бүрэн хэрэгжиж гэрээ байгуулагдсан бөгөөд хэрэгжээгүй болон төсөв татагдсан төсөл арга хэмжээ байхгүй. Мөн худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод, байдлыг нэмэгдүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлж, тендерт оролцогчид шалгарсан оролцогчийн ирүүлсэн нууцалснаас бусад материалтай танилцах боломжийг бүрдүүлж, тендер шалгаруулалтын шийдвэр гарсан өдрөөр үр дүнг цахим системд нийтэлж хэвшсэн. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байхаар заасан тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчдын мэдээлэл, үндэслэл, гэрээний дүн, гэрээ байгуулсан этгээдийн мэдээлэл зэргийг аймгийн цахим сайтад байршуулсан.		
144	278	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэл 2024-04-10 Дугаар 2024_14 14.17.1.2. Бэлчээрийн газар ашиглалт, түүний даацыг тохируулах, өнжөөн сэлгэх, хүчтэй элэгдэл, эвдрэлд өртсөн тариалангийн газрыг нөхөн сэргээх, хот суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох хууль	Аймгийн 2024 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд 4 сумын 5 байршилд мод, бут, сөөг тариалах, 6 сумын 44 байршилд худаг шинээр гаргах болон сэргээн засварлах, 3 сумын 23 байршилд 82045.4 га талбайн хортон мэргэчтэй тэмцэх, 2 сумын 9 байршилын 1.8 га-д булаг шандны эхийг хашиж, хамгаалах, 1 сумын 1 байршилд 4 га газрыг элсний нүүлтээс хамгаалах, 3 сумын 3 байршилд 2965 га хог хаягдлаас цэвэрлэх, 3 сумын 6 байршилд 19.2 га газарт ногоон байгууламж бий болгох, 1 сумын 6 байршлын 55.6 га газарт нөхөн сэргээлт хийх, 5	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		тогтоомж, журмын дагуу хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;	сумын 19 байршлын 187148.2 га бэлчээрийн газрыг өнжөөж амрах зэрэг ажлыг төлөвлөөд байна.		
145	279	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл 2024-04-17 Дугаар 2024_15 20.11.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгах аргаар заасан мэдээллийг “Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)”-д байршуулах ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;(Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар)	Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй “Шил” ажиллагааны хүрээнд Цахим, хөгжил, инновац, харилцаа холбооны яамтай хамтран аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, 19 сумын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудын нийт 146 албан хаагчдад цахим болон танхимын сургалтыг зохион байгуулсан. Дээрх сургалтаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 8 агентлаг (хэвтээ удирдлагатай), 19 сумын цахим сайт хариуцсан албан хаагчдын мэдээллийг нэгтгэн, shilen.gov.mn цахим санд нэвтрэх, тайлагнах эрхийг үүсгэсэн. Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу тайлант онд 36 төрийн байгууллага шинээр бүртгүүлж, 29 байгууллагын байршуулсан индексийн тайланд үнэлгээ хийн илгээж баталгаажуулсан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
146	280	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл 2024-04-24 Дугаар 2024_16 26.3.5. Шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчиж газар олгохгүй байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт;	Шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчиж газар олголт хийгдээгүй.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	281	26.3.6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун	Улсын чанартай авто зам дагуу үйл ажиллагаа явуулдаг 14 шатахуун түгээх станцуудын хяналтын камерт үзлэг шалгалт хийхэд камерын хяналтын	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцад орчны дүрс бичлэгийн техник, хэрэгслийг байршуулж, цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр болон бүх шатны Засаг дарга нарт;	системтэй боловч MNS6423:2019 стандартын шаардлага хангаагүй, улсын чанартай автозам дагуу чиглэсэн хяналтын камергүй, үйлчлүүлсэн тээврийн хэрэгслийн улсын дугаар болон гадна орчныг бүрэн хянах хяналтын камергүй зэрэг зөрчлүүд илэрсэн. Илэрсэн зөрчлийг арилгуулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шатахуун түгээх станцуудад албан мэдэгдлийг хүргүүлсэн. Мэдэгдлийн мөрөөр арга хэмжээ зохион байгуулаагүй, хариуг хугацаанд нь ирүүлээгүй Сод монгол, Хийморь, Гор газ, Монсульт, Тес петролиум, Жаст, МТ, М-OIL, Арвайн сор ундрага, Хөрс, Их богд, Хүннү шатахуун түгээх станцуудад Зөрчлийн тухай хуулийн 5.9 дэх заалтаар арга хэмжээ авсан.		
147	282	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэл 2024-05-01 Дугаар 2024_17.1 28.3.1.“Нийгмийн түншлэлийг хэрэгжүүлэх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж аймаг, нийслэл, салбарын түвшинд ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагатай хэлэлцээ хийж хамтын хэлэлцээр байгуулан, ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн талаар улсын үзлэгийг зохион байгуулж нийт 36 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан. Дээрх байгууллагууд нь хамтын, хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй 5, хөдөлмөрийн гэрээ шинэчлээгүй 10, ХАБЭА-н ажилтан, зөвлөлгүй 8, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судлан бүртгэсэн акт, дүгнэлт гаргах эрх, үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг байгуулж ажиллуулдаггүй зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрч арилгуулах талаар үүрэг чиглэл өгч, байгууллагын удирдлагууд холбогдох ажилтан албан хаагч 101 хүнд сургалт зохион байгуулж ажилласан. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 19 аж ахуйн нэгж, байгууллагад зохион байгуулж, 17 аж ахуйн нэгж, байгууллагад улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилласан. Хяналт шалгалтын хүрээнд Уянга суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

			“Баярс гоулд” ХХК-д 1.5 сая төгрөгийн торгууль, 1.3 сая төгрөгийн акт, барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа “Дүүрэн цацрах” ХХК-д 1.5 сая төгрөгийн торгуулийг тус тус оногдуулсан.		
148	283	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэл 2024-05-08 Дугаар 2024_18.1 19.3.2. Уг төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулах, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгав.	“Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)” танилцуулах цахим уулзалтад аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар түүний эрхлэх асуудлын хүрээний газар агентлагууд нийт 40 байгууллагын 800 гаруй албан хаагчдыг оролцуулж уг төлөвлөгөөг танилцуулсан. Түүнчлэн аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон 2025 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 3 арга хэмжээг тусган, хэрэгжүүлэхээр төлөвлөв.	Хэрэгжилт хангалтгүй 30.0 хувь	
149	284	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэл 2024-05-15 Дугаар 2024_19.1 22.5.2. Хот байгуулалтын норм, стандартын дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилга барих зориулалтаар газар чөлөөлөх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль бариагүй орон сууцны хотхон, хорооллыг ашиглалтад хүлээн авахгүй байх, ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд тухайн орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны газраас төлөөлөл оруулж, хяналтыг	Энэ онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр суманд ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 320 хүүхдийн өргөтгөлийн барилга, 150 хүүхдийн тусгай хэрэгцээт цэцэрлэгийн барилга, Сант, Гучин-Ус суманд 250 суудалтай ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны барилга, Богд, Бүрд, Зүүнбаян-Улаан сумдад 50 ортой цэцэрлэгийн барилгын өргөтгөл, Уянга суманд 100 ортой дотуур байрны барилга, 250 суудалтай спорт заалны барилга, Баян-Өндөр суманд 320 хүүхдийн сургуулийн барилга, спорт заалны хамт, Баянгол суманд номын сан, урлаг заал бүхий 240 хүүхдийн сургуулийн барилга тус тус баригдаж байна. Дээрх төсөл арга хэмжээнүүд болон бусад шаардлагатай сургууль, цэцэрлэг газрын асуудлыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	батлуулан газрын асуудлын шийдвэрлэн, төлөвлөн ажиллаж байна. Мөн сургууль, цэцэрлэгийн угсралт болон засварын ажлын явцын хяналт, шалгалт, ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд аймгийн Боловсролын газар, тухайн сургууль, цэцэрлэгийн төлөөллийг оролцуулан зохион байгуулж байна.		
150	285	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэл 2024-05-22 Дугаар 2024_20.1 19.1. Үүнтэй холбогдуулан зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, тэднийг малжуулах хөтөлбөрт хамруулах, малчдын амьжиргааг дээшлүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаан бүрд танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд, малчныг малжуулах хөтөлбөрт хамруулах арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, аймгийн Засаг дарга нарт даалгав.(Зудын улмаас мал нь хорогдсон малчин өрхүүдийн талаар)	Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас 19 сумын 210 малчин өрхийг 1680.0 сая төгрөгөөр малжуулах хөтөлбөрт хамруулсан. Мөн Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран Малжуулах хөтөлбөрт хамрагдсан малчдад зориулан “Тэгш боломжийн төлөө-залуучуудын манлайлал” залуу малчдын чуулга уулзалтыг зохион байгуулсан. Дээрх чуулга уулзалтыг малчдын амьжиргааг дэмжих, малчид залуу халаагаа хэрхэн бэлдэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар болон жендерийн тэнцвэртэй байдлыг хангах, малчдын нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, малчин залуу гэр бүлийн тогтвортой байдлын талаарх санал санаачилгыг дэвшүүлж, хамтдаа шийдэл гаргах зорилготойгоор зохион байгуулсан.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
151	286	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл 2024-06-06 Дугаар 2024_22	“Шинэ хоршоо-чинээлэг малчин” хөдөлгөөний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗГХЭГ-аас 19 суманд 38 сургагч багш нар 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс ажиллаж тухайн сумаас байрлах байр, сургалтын танхим ажиллах нөхцөл бололцоогоор хангасан. "Шинэ хоршоо-чинээлэг	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		37.1.1. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий багийг орон нутагт үргэлжлүүлэн ажиллуулж, холбогдох албан хаагчдын албан томилолтын болон замын зардал, тээврийн хэрэгслийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга (захирал) нарт	малчин” хөдөлгөөний хүрээнд 19 сумдын 23007 малчдад газар дээр нь очин сум бүрт томилогдон ирсэн сургагч багш нартай хамтран сургалт, мэдээлэл, заавар, зөвлөгөөг өгч ажилласан.		
152	287	Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл 2024-09-04 Дугаар 2024_31 31.9.6. 2/ Төрийн байгууллагын “gov.mn” нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	"И-Монгол академи" УТҮГ-аас төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудасны ашиглалтын талаарх сургалтыг энэ онд 2 удаа цахимаар зохион байгуулсан. Тус сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газрын Цахим үйлчилгээ, бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн хамрагдаж систем ашиглалтын талаарх мэдээллийг авсан. Тус системд аймгийн 19 сумын Засаг даргын Тамгын газрыг бүртгэж, байгууллагын цахим хуудасны мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн системд оруулж байх дэд админ эрхийг нээж өгч, тайлант хугацаанд 34 мэдээ, мэдээллийг нийтлээд байна.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
153	288	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэл 2024-09-11 Дугаар 2024_32 32.6.2. 2.1.Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлээр	Аймгийн хэмжээнд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хугацаа дууссан Хархорин, Есөнзүйл, Тарагт, Өлзийт, Баруунбаян-Улаан, Зүүнбаян-Улаан, Бүрд, Баян-Өндөр нийт 8 сум байна. Тус сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2025 онд сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлэх чиглэлийг сумдын Засаг дарга нарт хүргүүлээд байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		өгсөн даалгаврыг хэрэгжүүлж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй сумдын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлыг эрчимжүүлж, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэхийг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт, төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурьд			
154	289	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлд 2024-10-02 Дугаар 2024_35 14.7.2. Газрын эрхийн давхцалтай 6206 зөрчлийг арилгах, тусгай хамгаалалттай газар нутагт олгогдсон 4953 нэгж талбар газрын эрх болон уул уурхай, ашигт малтмалын зориулалтаар олгогдсон 447 нэгж талбар газрын эрхийг баталгаажуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгав;	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас Хархорин, Уянга сумдад 2003-2023 онд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газрын хэмжээ, байршил, зориулалтаар нь өмчлүүлсэн, ашиглуулсан, эзэмшүүлсэн газрын захирамжийг мэдээллийн сантай тулган зөрчил бий эсэх дээр хяналт шалгалтыг явуулсан. Үүнтэй холбогдуулан зөрчил арилгах, эрх баталгаажуулах шаардлагатай тус аймагт хамаарах зөрчил үүссэн нэгж талбарын судалгааг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсний дараа холбогдох арга хэмжээг авахаар төлөвлөж байна.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
155	290	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл 2024-11-13 Дугаар 2024_39 39.29.11.3. Энэ тэмдэглэлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэгт зааснаас гадна захиргааны хэм хэмжээний актын	Жил бүр Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлангийн дүгнэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, хүргүүлж байна. Аймгийн Засаг даргын хэм хэмжээ тогтоосон нийт худалдаа үйлчилгээний газруудын цагийн хуваарийг шинэчлэн баталж мөрдүүлэх тухай, 2023 оны 11 дүгээр сарын 28-ны	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа өөрийн салбарын бусад шийдвэрийг дараах чиглэлээр хянан үзэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хариу мэдэгдэхийг бүх шатны захиргааны байгууллагын удирдлагад даалгав: (Үүнд :3.1.хүчингүй болсон тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.2. ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.3. нэмэлт, өөрчлөлт оруулсан буюу хөдөлгөөн хийгдээгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.4. хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.6. хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч батлаагүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.7. захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.8. энэ тэмдэглэлийн 3.2, 3.4-т заасан захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээллийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ зохих албан тушаалтан тэдгээрийг хүчингүй болгох шийдвэр гаргаж, хавсаргасан байх.) заалт бүрээр биелэлт ирүүлэх.	өдрийн А/724 дүгээр “Худалдаа үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг шинэчлэн батлах тухай” буюу архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх худалдаа үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарийг шинэчлэн тогтоосон захирамж, 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/776 дугаар “Худалдаа, үйлчилгээний газруудад авах арга хэмжээний тухай”, Арвайхээр сумын Засаг даргын 2013 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/46 дугаар “Худалдаа, үйлчилгээний төвүүд болон захын ажиллах цагийн хуваарь, амрах өдрийг батлах тухай” захирамж тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд уг захирамжууд хуулийн үйлчлэл хангаж байгаа тул цаашид хэвээр үлдээж үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байна.		
291	39.29.12.3. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах чиг үүргээ тодорхой албан тушаалтанд хариуцуулж, үйл		Дотоод хяналтад авч ажиллав.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.	

		ажиллагааны болон кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусгаж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт			
156	292	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэл 2024-11-20 Дугаар 2024_40 40.19.5.3. “Өвлийн идэш” арга хэмжээнд малчдын хоршоодын оролцоог хангахад дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ.	Нийслэлийн хүн амын өвлийн улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны хангамжийн тогтвортой байдлыг хадгалах, орон нутгийн малчид, хоршоологчдын малын махыг дундын зуучлалгүйгээр хэрэглэгчдэд шууд хүргэхээр “Хоршоологчдоос-Хотынхондоо” уриан доор хэрэгжүүлэх “Өвлийн идэш” арга хэмжээ 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс 21-ний өдрийг дуустал хугацаанд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Арга хэмжээнд гарал үүсэл нь тодорхой 5 төрлийн малын мах, дайвар бүтээгдэхүүн, цагаан идээ худалдаалах малчид, хоршоологчдыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, өргөн цар хүрээтэй оролцуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан. Арга хэмжээнд Арвайхээр сумын “Түмний буян далай” хоршоо малын мах, дайвар бүтээгдэхүүнээр оролцсон.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
	293	40.19.7.2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг тогтоосон Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолыг сахин мөрдөж, тэдгээрээс зөрүүтэй газар зүйн нэр, зургийг үндэслэн аливаа хилийн цэстэй холбоотой маргаан үүсгэхгүй байх талаар онцгой анхаарч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	Аймаг, сумын хилийн цэсийг тогтоосон Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолыг мөрдөн ажиллаж байна. Энэ онд хилийн цэстэй холбоотой маргаан үүсээгүй.	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	
157	294	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 43 дугаар тэмдэглэл	Аймгийн барьцаа хөрөнгийн дансанд 853.8 сая төгрөгийг авснаас энэ оны жилийн эцсийн байдлаар Төгрөг сумын Эрүүл мэндийн төвийн барилга,	Бүрэн хэрэгжсэн 100.0 хувь	

		2024-12-04 Дугаар 2024_43 43.6.2.. Төсвийн жилд багтаан барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөх боломжгүй, хэрэгжилт удаашралтай, зогссон төслүүдийн гэрээг дүгнэж, эцсийн тооцоог баталгаажуулан барьцаа хөрөнгийн данс дахь санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	Хархорин сумын 2 дугаар сургуулийн спорт заал ашиглалтад орж 354.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Хархорин сумын Аврах гал унтраах ангийн барилгын ажлыг гүйцэтгэгч компани нэмэлт санхүүжилт шийдвэрлэгдсний дараа ажлаа хийнэ гэсэн шалтгаанаар энэ онд ажил хийгээгүй тул барьцаа дансанд байршуулсан 499.8 сая төгрөгийг Сангийн яамны дансанд буцаан төвлөрүүлэхээр шийдвэрлээд байна.		
Хэсгийн дундаж: 92.4					
Монгол Улсын Засгийн газрын албан даалгавар					
158	295	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай 2022-07-05 Дугаар 2022_6 1.1. ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2. ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах;	Удирдлагын академитай хамтран Иргэн төвтэй Хөгжлийн төлөө багийн Засаг дарга нарыг чадавхжуулах богино хугацааны сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 4,5-ны өдрүүдэд Арвайхээр суманд зохион байгууллаа. Тус сургалтад 105 багийн Засаг дарга нар хамрагдсан. Сургалтыг: • Асуудал тодорхойлох, эрэмбэлэх • Засаглал, иргэдийн оролцоо • Багийн түвшинд үзүүлэх үйлчилгээ, Засаг даргын чиг үүрэг • Хамтран ажиллах арга, ур чадвар • Захиргааны шийдвэр, хууль тогтоомжий хэрэглээ • Манлайллын арга барил • Сайн туршлага, манлайллын түүх бүтээх • Төслийн санал боловсруулах гэсэн 8 сэдвийн хүрээнд зохион байгууллаа.	Хэрэгжих шатанд 70.0 хувь	
159	296	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга	Монгол Улсын Шадар сайдын ивээл дор “Эрсдэл ба стандарт” үндэсний форумыг Онцгой байдлын газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс хамтран аймгийн хэмжээнд 2023 онд зохион байгуулсан бөгөөд тус	Хэрэгжих шатанд 70.0 хувь	

		хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_01_1 1.14.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагын реформыг хэрэгжүүлэхийг Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан) С.Амарсайхан, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	форумд төр болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл 182 хүнийг хамруулсан. Форумд эрүүл мэнд, барилга, дэд бүтэц, хүнсний болон хөдөлмөрийн аюулгүй байдлын стандарт, орон нутгийн гамшиг эрсдэлийн өнөөгийн нөхцөл байдал, түүнийг бууруулах арга зам, тэдгээрийг даатгалаар хэрхэн шийдвэрлэх зэрэг 9 байгууллагын 10 илтгэл, мэдээлэл тавигдсан. Тус форумгаас гарсан санал, дүгнэлтийн дагуу 2024 онд нийт 6 бүлэг 22 заалт бүхий төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд энэ оны 3 дугаар улирлын байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 70.0 хувьтай байна. Аймгийн “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах хүрээнд 19 сумын “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө” болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бүлэг, тасаг, салаа, суман, иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшилд байгаа галт зэвсэг, техник, материал хэрэгслийг нэг бүрчлэн тодотгож, өөрчлөлт орсон бүрэлдэхүүн, техник, галт зэвсгийг нөхөн томилгоожуулсан бөгөөд сумдын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжид хуваарилсан нийт бие бүрэлдэхүүний тодотгол, нөхөн томилгоожуулалтад хяналт тавин ажиллаж байна. Орон нутгийн хамгаалалтын сургалтын төвийг Өвөрхангай аймгийн Тарагт суманд барихаар 7965 м2 газрын асуудлыг шийдвэрлэсэн. “Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө”- ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникийн оногдуулан бүртгэлтийг тодотгож, чанар, байдлын судалгааг шинэчилсэн. Орон нутгийн цэрэгт томилгоожсон бүрэлдэхүүний 5.2 хувийг дайчилгааны 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний давтан бэлтгэх сургалтад хамруулж, мэдлэг, чадварыг дээшлүүлсэн. Цаашид үндэсний сөрөн	
--	--	--	---	--

		тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх байгаль, нийгэм, эдийн засгийн эрсдэлийг тодорхойлон хэрэгжүүлэх үйл ажиллагааг Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бөгөөд тухайлбал: Орон нутгийн хөгжлийн дэд төв, орон нутгийн хамгаалалт, байгаль орчны тогтвортой байдлыг хадгалан хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засгийн бодлогын талаарх зохицуулалтуудыг тусган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлохдоо үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхид нөлөөлөх нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг авч үзсэн бөгөөд 2028 онд аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг 1146.4 тэрбум төгрөг, Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн (нэмэгдэл өртөг)-ийг 571.9 тэрбум төгрөг, Аж үйлдвэр, барилгын салбарын бүтээгдэхүүн (нэмэгдэл өртөг)-ийг 181.1 тэрбум төгрөг, Худалдаа, үйлчилгээний салбарын бүтээгдэхүүн (нэмэгдэл өртөг)-ийг 398.8 тэрбум төгрөг, Орон нутгийн төсвийн татварын орлогын бүрдүүлэлтийн дүнг 50.0 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөж, батлуулсан.	
Хэсгийн дундаж: 70.0			
Нийт дундаж хувь: 92.3			

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР